ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДААС АЙМГИЙН ЗАСАГ ДАРГАТАЙ 2022 ОНД БАЙГУУЛСАН ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ГЭРЭЭНИЙ БИЕЛЭЛТ

Орхон аймаг 2022.12

| № | Үндэслэж буй бодлогын баримт бичиг | Санхүүжилтийн эх үүсвэр | Шалгуур үзүүлэлт | Суурь үзүүлэлт | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин | Үнэлгээ |
|---|---|---|---|---|---|---|---|
| 3.2.1. Коронавируст халдвар /ковид-19/-ын цар тахлаас сэргийлэх, тэмцэх чиглэлээр | | | | | | | |
| 1 | 3.2.1.1. Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлаас сэргийлэх, цар тахалтай тэмцэх хариу арга хэмжээний төлөвлөгөөнд тухай бүр тодотгол хийж, хэрэгжилтийг тухай бүрт тайлагнан хяналт тавьж ажиллана. | | Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь | 90% | 90,5% | Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 66 дугаар тогтоол, Улсын онцгой комиссын 2022 оны 1 дүгээр тогтоолыг үндэслэн Орхон аймгийн засаг даргын 2022 оны А/84 дүгээр тоот захирамжаар Коронавируст (КОВИД-19) халдварын тархалтыг шар түвшинд шилжүүлсэн. Уг түвшинд дараах ажлуудыг төлөвлөгөөний дагуу хийсэн. Үүнд:<br>- ЭМС-ын А/165 “Коронавируст халдвар (КОВИД-19)-тай иргэнд тусламж үзүүлэх түр орыг татан буулгах тухай” тушаалаар нийт хувийн хэвшлийн 5 эмнэлгийг татан буулгасан.<br>- Коронавируст халдвар (КОВИД-19)-ын тархалтын үе шатыг 24 удаа үнэлж, мэдээ тайланг 7 хоног бүр ХӨСҮТ-д хүргүүлэн ажилласан. Тайлант хугацаанд Коронавируст халдварын 3988 тохиолдол бүртгэгдсэн нь өмнөх оноос 2.5 дахин бага, түргэвчилсэн шинжилгээг 22302 иргэнд, Бх-ПГУ шинжилгээг 9970 иргэнд хийсэн байна. Нийт батлагдсан 3988 тохиолдлын ойрын хавьтлын 9958 иргэнд тандалт судалгаа хийсэн. Нийт 70 багц өвчлөл бүртгэгдсэнээс зөөвөрлөгдсөн 25, аж, ахуй нэгж байгууллага 26, найз нөхдийн 19, гэр бүл, хамаатан садны 35 багц өвчлөлийн голомтыг идэвхгүй болсон.<br>- Гамшгаас хамгаалах иж бүрэн дадлага сургуулилтад оролцож жагсаалын үзлэг 6 удаа, танхимын сургалт 5 удаа, хээрийн эмнэлэг дэлгэх | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | үзүүлэх сургуулилтыг хийж чадавх 95%-тай болсон нь өмнөх оноос 15%-аар нэмэгдсэн.<br>- ЭМС-ын А/373 дугаар тушаалын дагуу аймгийн Засаг даргын захирамжаар батлагдсан “Амьсгалын замын халдварт өвчинтэй тэмцэх сэргийлэх” ажлын хэсэг 2 удаа хуралдаж 2022-2023 оны томуу, томуу төст өвчний дэгдэлтийн үед ажиллах 5 бүлэг 46 заалт бүхий төлөвлөгөө батлуулан ажиллаж хэрэгжилт 95%-тай байна.<br>- Тайлант хугацаанд Коронавируст /КОВИД-19/-ын цар тахалтай тэмцэх, халдвар хамгааллын дэглэм баримтлах, халдварын үеийн оношилгоо, эмчилгээ зэрэг сэдвээр давхардсан тоогоор 1184 эмч мэргэжилтэн, ажилтан, нийт эрүүл мэндийн салбарын ажилтнуудын 64,7%-ийг сургалтад хамруулсан.<br>- Тандалтын 9 багийг чадавхжуулах чиглэлээр цахим, танхимын сургалтыг 2 удаа, халдварт өвчний тандалтын тогтолцоог бэхжүүлэх төвийн бүсийн зөвлөлдөх уулзалтад 7 аймгийн 39 эмч, эмнэлгийн мэргэжилтнийг хамруулж чадавхжуулсан.<br>Хариу арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилт 92.3%-тай хэрэгжсэн. | |
| 2 | 3.2.1.2. Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлаас сэргийлэх, тандалт, ялангуяа хилийн нэвтрэх цэгтэй аймагт лабораторид суурилсан тандалт хийх, өвчлөл зөөврлөгдөхөөс сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлж ажиллана. | | Тандалтын тоо | - | Тухай бүр | Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн харьяа лабораторид болон Эрдэнэт клиникийн лабораторид шаардлагатай тохиолдолд ПГУ шинжилгээ хийж ажилласан. Тайлант хугацаанд коронавируст халдвар илрүүлэх түргэвчилсэн шинжилгээг 22302 иргэнд, Бх-ПГУ шинжилгээг 10422 иргэнд хийснээс коронавируст халдварын 3988 тохиолдол бүртгэгдсэн.<br>Батлагдсан тохиолдлын ойрын хавьтлын 9958 иргэнд тандалт судалгаа хийсэн. Нийт 70 багц өвчлөл бүртгэгдсэнээс зөөврлөгдсөн 25, аж, ахуй нэгж байгууллага 26, найз нөхдийн 19, гэр бүл, хамаатан | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | садны 35 багц өвчлөлийн голомтыг идэвхгүй болсон. | |
| 3 | 3.2.1.3. Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлын үед эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хэвийн, тасралтгүй байдлыг хангаж, хэнийг ч орхигдуулахгүй байх зарчим баримтлан ажиллана. | | Эмнэлгүүдийн үйл ажиллагааны тасалдлын хувь | 25% | 0 | Улсын хэмжээнд Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлын үе шаттай уялдуулан Ковидын тусгаарлах эмнэлгээр ажиллаж байсан хувийн хэвшлийн 5 эмнэлгийг ЭМС-ын А/165 дугаар тушаалаар татан буулгаж эмнэлгүүдийг үйл ажиллагааг 100% хэвийн үйл ажиллагаанд оруулан Ковидын дараах сэргээн засах тусламж үйлчилгээг өргөжүүлэн үзүүлсэн.<br>БОЭТ-ийн хүүхдийн тасгийг Ковидын тусгаарлах эмнэлгээс татан буулгаж хүүхдийн тасгийн үндсэн тусламж үйлчилгээнд шилжүүлж, халдвартын тасагт Ковидын хүлээн авах, 40 ортойгоор хэвтэн эмчлүүлэх тусламж үйлчилгээг үзүүлж, тайлант хугацаанд 2824 иргэн хэвтэн эмчлүүлсэн байна.<br>Бүсийн оношилгоо эмчилгээний төвд тархины харвалтын нэгж байгуулагдаж, 217 хүнд оношилгоог хийснээр зүрхний цочмог шигдээс өвчний нас баралтыг бууруулсан. Орон нутгаас 33,0 сая төгрөгийн санхүүжилт батлагдаж 10 ширхэг бүлэн хайлуулах РЭПИ/актилизе/-р хангасан.<br>БОЭТ-д Ковидын дараах сэргээн засах кабинетыг шинээр нээн ажиллуулж бүс нутгийн хэмжээнд 516 иргэнд сэргээн засах тусламж үйлчилгээг хийсэн. Нүдний кабинетад дутуу нярайн нүдний гажгийг илрүүлэх шинжилгээ, Эрэгтэйчүүдийн урологийн үзлэг, оношилгоо, хагалгааг бүс нутгийн хэмжээнд үзүүлж байна. Дүрс оношилгооны тасагт компьютертомограф, суурин дижитал аппарат суурилуулагдсан. Шинжилгээний хариу хэвлэх киоск машиныг байрлуулж, E Mongolia цахим системд бүс нутгийн иргэдийн цаг авах, шинжилгээний хариу авах үйлчилгээг нэвтрүүлсэн.<br>Хувийн хэвшлийн эмнэлгүүд амбулатори, өдрийн | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | эмчилгээний тусламж үйлчилгээгээр даатгалын сонгон шалгаруулалтад тэнцэж тусламж үйлчилгээний хүрээг тэлж 3-4 төрлийн тусламж үйлчилгээний кабинетыг шинээр нээж, өдрийн эмчилгээнд иргэдийг хамруулсан Баян-өндөр Мед Нэгдсэн эмнэлэг хөнгөвчлөх тусламж үйлчилгээг нэмж үзүүлэхээр хүний нөөцийг сургаж, 10 орыг хөнгөвчлөх тусламж үйлчилгээгээр нэмэгдүүлсэн. 2 эмнэлэгт дижитал рентген суурилагдаж хүртээмжийг нэмэгдүүлсэн. | |
| 4 | 3.2.1.4. Аймгийн Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн лабораторийн хүчин чадлыг сайжруулж, ПГУ шинжилгээ хийх болон антигенд суурилсан түргэвчилсэн оношлуураар шинжилгээ хийх чадавхыг бүрдүүлж, урвалж бодисоор тасралтгүй хангана. | | Лабораторийн чадавхын хувь | 80% | 90% | Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн харьяа лабораторид болон Эрдэнэт клиникийн лабораторид шаардлагатай тохиолдолд ПГУ шинжилгээ хийж ажилласан. ПГУ шинжилгээний дагалдах хэрэгсэл, урвалж оношлуур, фильтертэй хошуу, түргэвчилсэн шинжилгээний оношлуурын нөөц тус тус 2-3 сарын нөөцтэй байна. Эрүүл мэндийн яамнаас 5 удаагийн 885,3 сая төгрөгийн нөөц хангалтаар Бүсийн оношилгоо эмчилгээний төв, сум, өрхийн эрүүл мэндийн төвүүдэд 690,3 /85,1%/ сая төгрөгийн эм эмнэлгийн хэрэгсэл хамгаалах хэрэгсэл, КОВИД-19-ын ПГУ болон түргэвчилсэн оношлуурыг Эрүүл мэндийн газрын даргын тушаалуудаар олгож нөөцийг нэмэгдүүлснээр 3-4 сарын нөөцтэй байна.<br><br>Тайлант хугацаанд коронавируст халдвар илрүүлэх түргэвчилсэн шинжилгээг 22302 иргэнд, Бх-ПГУ шинжилгээг 10422 иргэнд хийснээс коронавируст халдварын 3988 тохиолдол бүртгэгдсэн. Лабораторийн чадавх өмнөх оноос 8,5%-аар нэмэгдэж 88,5% болсон байна. | 85% |
| 5 | 3.1.2.5. Коронавируст халдвар /КОВИД-19/-ын үйл ажиллагаанд зориулан ашиглаж буй программ хангамж, цахим системийн | | Мэдээллийн сангийн бүртгэл | 85% | 100% | Улсын онцгой комисс, ЭМЯ-наас Коронавируст халдварыг илрүүлэх ПГУ шинжилгээний бүртгэлийг ЭрүүлМН платформ eruul.gerege.mn системд бүртгэх чиглэл ирсний дагуу орон нутгийн төсвийн 15.0 сая төгрөгийн санхүүжилтээр Гэрэгэ системийн 10 ширхэг, | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | мэдээллийн санг чанартай бүрдүүлэн, өдөр тутам хяналт тавьж иргэдэд холбогдох мэдээллийг цахимаар гаргаж өгөх | | | | | байгууллагуудын өөрсдийн зардлаас 4, нийт 14 пос төхөөрөмж авч, Вируслогийн лабораториуд, шуурхай хариу арга хэмжээний багуудад ашиглагдаж байна. 2021 оны 05 дугаар сарын 03-ны өдрөөс тус системд бүрэн шилжиж нийт 17169 ПГУ шинжилгээг тус системээр 100% бүртгэсэн. Eruul.gerege.mn системд шилжсэнээр бүртгэлийг автоматжуулан хариуг eruul.gerege.mn сайт, гэрэгэ аппликейшн болон гар утсанд нь мессежээр хүргэдэг, шинжилгээний тайлан мэдээг цахимаар харах зэрэг үр дүнтэй байгаагаас гадна бүртгэлтэй холбоотой иргэдээс ирсэн гомдол 4 дахин буурсан байна.<br>Бүсийн оношилгоо эмчилгээний төв нь Метакс плас ХХК-тай хамтран ажиллах гэрээ байгуулж PCR, түргэвчилсэн шинжилгээ өгч буй иргэдийн шинжилгээний хариуг Emongolia гар утасны аппликейшн ашиглан үнэ төлбөргүй хүргэсэн. | |
| 6 | 3.1.2.6. Коронавируст /КОВИД-19/-ын харьяа нутаг дэвсгэрт бүртгэгдсэн тохиолдолд анхан шатны тусламж үйлчилгээг гэрээр үзүүлэх хэлбэрт шилжүүлэн гүйцэтгэлийн чанарт хяналт тавьж ажиллана. | | Гэрийн эргэлтийн хувь | 22.5% | 22,5%-аас бууруулахгүй байх | Тайлант хугацаанд сум, өрхийн эрүүл мэндийн төвүүд амбулаторийн 615823 үзлэг хийснээс 98248 буюу 15,9 хувийг гэрийн эргэлт, 2467 буюу 0.4 хувийг гэрийн дуудлага тус тус эзэлж байна.<br>Коронавируст /КОВИД-19/-ын халдварын 3586 тохиолдлыг гэрээр эмчилсэн байна. | 70 |
| 7 | 3.1.2.7. Нийт хүн ам болон зорилтот бүлэгт зориулсан Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахалтай тэмцэх, сэргийлэх мэдээлэл, сургалт, сурталчилгааг цахимаар тогтмол зохион байгуулах[5] | | Цахим хэлбэрээр хийгдсэн мэдээлэл, сургалтад хамрагдсан хүний хувь | 85% | 85%-с бууруулахгүй байх | Коронавируст халдвараас урьдчилан сэргийлэх мэдээлэл сургалт сурталчилгааг иргэдэд төлөвлөлтийн дагуу орон нутгийн хэвлэл мэдээллийн байгууллага болон цахимаар хүргэн тогтмол хүргэн ажилласан. Тайлант хугацаанд 297 төрлийн гарын авлага, шторк, зөвлөмжийг байршуулан 310584 иргэнд түгээн ажилласан. Коронавируст халдварын орон нутгийн нөхцөл байдлын мэдээлэл 94 удаа, Коронавируст халдвараас сэргийлэх | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | дархлаажуулалтын талаар 5 удаа хэвлэлийн бага хурал зохион байгуулж, вакцины үр дүн, ач холбогдлыг таниулах ганцаарчилсан зөвлөгөөг 1479 хүнд, утсаар 2110 хүнд өгч ажилласан. Коронавируст халдвараас урьдчилан сэргийлэх зөвлөмж, вакцинтай холбоотой 20 төрлийн сурталчилгааны материалыг 3450 иргэдэд түгээн ажилласан. Нийт иргэдийн 85%-ийг цахимаар мэдээллээр хангасан. | |
| 8 | 3.2.1.8. Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлын үед чанар, аюулгүй байдлын шаардлага хангасан хүнсээр хүн амыг тасралтгүй хангах ялангуяа орон гэргүй, нэн ядуу иргэдийг орон байр, хоол хүнс, ундны цэвэр усаар хангах, халдвараас сэргийлэх, сэтгэл зүйн дэмжлэг үзүүлэх ажлыг зохион байгуулна. | ОНТ 28,7 сая<br><br>ГБХЗХГ 2,0 сая | Зорилтот бүлгийн хамрагдсан хувь | 20 | 40 | Тайлант хугацаанд зорилтот бүлгийн 61%-ийг угтан сэргийлэлт болон эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд хамруулсан байна. Үүнд:<br>- ГБХЗХГ-тай хамтран 2,0 сая төгрөгийн төсвөөр зорилтот бүлгийн 100 хүүхдийг аминдэмжүүлсэн.<br>- Томуу, томуу төст өвчний улирал эхэлсэнтэй холбоотой эрсдэлт бүлгийн 4-5 насны хүүхдүүдэд аймгийн Засаг даргын 2021 оны А/616 тоот захирамжаар батлагдсан 28,7 сая төгрөгийн төсвийн хүрээнд 1028 хайрцаг /иммуновис №60/ аминдэмийг авч, Эрүүл мэндийн газрын даргын 2021 оны А/142 тоот тушаалын дагуу улсын болон хувийн нийт 37 цэцэрлэгийн ахлах бүлгийн 2145 хүүхдүүдэд олгосон.<br>- Нийгмийн халамж шаардлагатай жирэмсэн, хөхүүл 353 эхийг аминдэмжүүлэлтэд хамруулсан нь зорилтот бүлгийн 75%-ийг эзэлж байгаа ба үр дүн 83,3%-тай байна.<br>- Жирэмсний эрт үеийн хяналтад 1244 эмэгтэй хамрагдаж 96,5%-тай байгаа ба эхийн эндэгдэл бүртгэгдээгүй.<br>- Өсвөр үе, зорилтот бүлгийн эмэгтэйн 18,5%-ийг урьдчилан сэргийлэх үзлэг, сургалтад хамруулсан.<br>Бужинлхам хүүхдийн клиникийн сувилалд зорилтот бүлгийн уураг илчлэгийн хурц болон архаг дутал, сульдаа, цус багадалт, хөгжлийн бэрхшээлтэй 264 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хүүхдийг нар, ус, агаараар чийрэгжүүлэн эмчилгээний хоол, сүү цагаан идээ, аминдэмжүүлэлтэд хамруулж, үр дүн 85%-тай байна.<br>- Орон гэргүй 19 иргэнийг түр байраар ханган, эмчилгээ сургалтад хамруулсан.<br>- Сэтгэлийн анир III" зорилтот төслийн хүрээнд хөгжлийн бэрхшээлтэй байнгын асаргаанд байдаг хүүхдүүд болон тэдний асран хамгаалагчдыг 4 удаагийн сэтгэл зүйн бүлгийн ярилцлага, 5 удаагийн сэтгэл зүйн сургалтад хамруулж, 75 хөгжлийн бэрхшээлтэй иргэнд сэтгэл зүйн цогц тусламж үйлчилгээг үзүүлсэн. | |
| 9 | 3.2.1.9. Коронавируст халдвар /ковид-19/-ын цар тахлын үед ариутгал халдваргүйтгэлийн нөөц бүрдүүлэх, тасралтгүй хуваарилахын зэрэгцээ урьдчилан сэргийлэх, голомтын халдваргүйжүүлэлтэд үнэлгээ хийж, шаардлагатай арга хэмжээг зохион байгуулна. | | Үнэлгээний дүн | 1 | 1 | Тайлант хугацаанд Байгаль орчин аялал, жуулчлал, хүнс, хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэр, эрүүл мэндийн сайдын хамтарсан 2022 оны А/25А/46А75 дагаар тушаалаар батлагдсан ариутгал, халдваргүйтгэлийн бодисыг үйл ажиллагаанд хэрэглэх зөвлөмж өгч, хяналт тавин ажилласан. Гамшиг, нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үеийн нөөцөд 12 төрлийн 194,3 сая төгрөгийн эм, эмнэлгийн хэрэгсэл, халдваргүйтгэлийн бодис байна. Эрүүл мэндийн байгууллагуудын нөөц бүрдүүлэлт дунджаар 83,3%-тай, 32 хоногийн нөөцтэй байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 31,25%-аар нэмэгдсэн байна. Хувийн хэвшлийн ариутгал, халдваргүйтгэлийн 5 байгууллага Баян-Өндөр сумын багуудад хуваарын дагуу халдваргүйтгэл, мэрэгч, шавьжгүйтгэлийг хийж гүйцэтгэсэн. Тус байгууллагуудын үйл ажиллагаанд 2 удаагийн үнэлгээ, зөвлөмж өгч ажиллалаа. Тайлант хугацаанд Баян-Өндөр сумын гэр хорооллын 14 багийн 260 өрхийн нүхэн жорлон, муу усны нүх болон 145 аж ахуйн нэгжийн 8000мкв талбайд урьдчилан сэргийлэх халдваргүйтгэл хийгдсэн. Намрын улиралд | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | 477 аж ахуйн нэгж, 464 айл өрхийн 42315м2 талбайд төлбөртэй халдваргүйтгэлийг 3 төрлийн бодис ашиглан хийсэн байна. | |
| 10 | 3.2.1.10. Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахалтай тэмцэх, халдвар хамгааллын дэглэм баримтлах, халдварын үеийн оношилгоо, эмчилгээ гэх мэт сэдвээр эрүүл мэндийн ажилтнуудад тасралтгүй сургалт зохион байгуулах, сургалтад цахимаар хамрагдах боломж нөхцөлийг бүрдүүлэн ажиллана. | | Сургалтад хамрагдсан эрүүл мэндийн ажилтны тоо | 60% | 60%-65% | Тайлант хугацаанд Коронавируст /КОВИД-19/-ын цар тахалтай тэмцэх, халдвар хамгааллын дэглэм баримтлах, халдварын үеийн оношилгоо, эмчилгээ зэрэг сэдвээр давхардсан тоогоор 1184 эмч мэргэжилтэн, ажилтан, нийт эрүүл мэндийн салбарын ажилтнуудын 64,7%-ийг сургалтад хамруулсан. Үүнд:<br>- Ковидын сэжигтэй иргэдийг түр тусгаарлах хариу арга хэмжээг хэрхэн авах, биологийн шингэн асгарсан, цацарсан үед хэрэглэх цомгийг бэлтгэх, хэрэглэх чиглэлээр 9 эрүүл мэндийн байгууллагын 95 эмч, эмнэлгийн мэргэжилтэн<br>- Бүсийн оношилгоо эмчилгээний төвтэй хамтран эрүүл мэндийн салбарын чанарын алба, багийн дарга, гишүүн 45 хүн<br>- Коронавируст халдварын тархалтын түвшинд үндэслэн хүн, хуулийн этгээдийн үйл ажиллагааг зохицуулах журмын сургалтад 12 мэргэжилтэн<br>- Зонхилон тохиолдох халдварт өвчний тандалтын тогтолцоог бэхжүүлэх чиглэлээр төвийн бүсийн зөвлөлдөх уулзалтад 7 аймгийн 39 эмч, эмнэлгийн мэргэжилтэн<br>- Коронавируст халдвар, томуугийн эсрэг дархлаажуулалтын сургалтад давхардсан тоогоор 48 эмч, мэргэжилтэн<br>- Томуугийн 10 дугаар зөвлөгөөнд 11 эмч мэргэжилтэн<br>- Тандалтын 9 багийн 45 эмнэлгийн мэргэжилтэн 2 удаагийн сургалтад<br>- Эрүүл мэндийн байгууллагуудын дотоодын сургалтад давхардсан тоогоор 394 эмч, эмнэлгийн мэргэжилтэн<br>Коронавируст халдварын тандалт судалгаа, хариу | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | арга хэмжээний чадавхыг нэмэгдүүлэх цахим сургалтад 450 эмч, эмнэлгийн мэргэжилтэн тус тус хамрагдсан байна. | |
| 11 | 3.2.1.11. Коронавируст халдвар /ковид-19/-аас урьдчилан сэргийлэх, голомтын болон шуурхай хариу арга хэмжээ авч хэрэгжүүлэх үед эрүүл мэндийн ажилтнуудыг халдвараас сэргийлэх, тэдний дархлааг дэмжих, ажлын байрны эрүүл ахуйн шаардлага хангасан орчин бүрдүүлнэ. | ОНТ 10,0 сая | Дархлааг дэмжсэн эрүүл мэндийн ажилтны хувь | 100% | 100% | Өрхийн эрүүл мэндийн төвүүд, Бүсийн оношилгоо эмчилгээний төв болон Эрүүл мэндийн газрын 687 ажилтан урьдчилан сэргийлэх үзлэгт насны ангиллаар орж байгаагаас 92% нь хамрагдсан.<br>“Эмч” хөтөлбөрийн хүрээнд 10 сая төгрөгийн санхүүжилтээр Эрүүл мэндийн газар, Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн 40-өөс дээш насны 330 ажилтныг хавдрын маркерын шинжилгээнд хамруулснаас 3 ажилтан өөрчлөлттэй гарсныг лавлагаа шатлалын эмнэлэгт илгээсэн.<br>Эрүүл мэндийн бүх ажилтнуудыг халдвараас сэргийлэх, тэдний дархлааг дэмжих зорилгоор хүрээнд томуугийн сайн дурын дархлаажуулалтад 115 эмч эмнэлгийн ажилчдыг хамруулж 512 ажилтанд витамин С 1000 мг, витамин Д 2000 ед нэг сарын хэрэглээгээр хангасан. Эрүүл мэндийн салбарын ажилтнуудыг 100% дархлааг дэмжих аминдэм, халуун хоол, халуун аарц, чацаргана, амны хаалт зэргээр хангасан. Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн сургалтын хэсэг, ангиографийн кабинет, шуурхайн зал, амбулаторийн 2-р давхар, дотрын тасагт улсын болон орон нутгийн, өөрийн хөрөнгө оруулалтаар нийт 1,9 тэрбум төгрөгийн засвар үйлчилгээ хийж ажлын байрны эрүүл ахуйн шаардлагыг хангасан. | 100 |
| 12 | Нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдал болон Коронавируст халдвар /КОВИД-19/-ын үйл ажиллагаанд дайчлан ажиллуулсан эрүүл мэндийн ажилтны цалин урамшууллын | Байгууллага 9,4 сая | Дайчлан ажиллуулсан цалин урамшууллын асуудлыг шийдсэн эрүүл мэндийн | 1348 | Тухай бүр | Коронавируст халдвар /КОВИД-19/-ын үеэр аймгийн шуурхай штабт 2022 оны эхний улирлыг дуустал ажилласан эмч, мэргэжилтнүүдэд Гамшгийн тухай хууль болон Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлаас сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуульд заасны дагуу ажлын бус цагаар болон амралтын | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | асуудлыг Эрүүл мэндийн тухай хууль, Гамшгийн тухай хууль болон Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлаас сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуульд заасны дагуу шийдвэрлэж ажиллах[5] | | ажилтны тоо | | | өдрүүдэд ажилласан мэргэжилтнүүдэд илүү цагаар бодож олгосон. Нийт 60 хүнд илүү цагийн хөлс 9,4 сая төгрөгийг олгосон байна. Үүнд:<br>- Шуурхай штабт дайчлан ажиллуулсан 6 хүнд илүү цагийн 312,000 төгрөгийг олгосон.<br>- Өрхийн эрүүл мэндийн төвүүдэд Коронавируст халдвар /КОВИД-19/- ын үйл ажиллагаанд ажилласан 54 ажилтанд 9,1 сая төгрөгийн илүү цагийн хөлсийг олгосон байна. | |
| 13 | 3.2.1.13. Коронавируст халдвар /КОВИД-19/-ын үед сум, өрхийн эрүүл мэндийн төвийн үйл ажиллагааны жигд тасралтгүй ажиллагааг хангах зорилгоор тусламж, үйлчилгээ үзүүлэхэд нэн шаардлагатай тоног, төхөөрөмж, эм, эмнэлгийн хэрэгсэл, багаж, шатахуун, тослох материал, сэлбэгийг аймгийн Засаг даргын нөөц сан, Орон нутгийн төсвийн хөрөнгө, орон нутгийн хөгжлийн сангаас шийдвэрлэх арга хэмжээ авч ажиллана. | ОНТ 139,6 сая | Нэн шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангагдсан хувь | 90-95% | 90-95% | Тайлант хугацаанд сум, өрхийн эрүүл мэндийн төвийн үйл ажиллагааны жигд тасралтгүй ажиллагааг хангах зорилгоор орон нутгаас нийт 139.6 сая төгрөгийн хөрөнгө оруулалтыг хийсэн. Үүнд:<br>- Орон нутгийн 50,0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар 8 өрхийн эрүүл мэндийн төвийг билиметр болон УВЧ аппаратаар хангасан.<br>- Жаргалант суманд орон нутгийн хөгжлийн сангийн 16,4 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар 5 нэр төрлийн эмнэлгийн хэрэгсэл, орон нутгийн 10,0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар сургалтын өрөөг бүрэн тохижуулсан.<br>- Томуу, томуу тест өвчний алаг цоог дэгдэлтийн түвшинд өрхийн эрүүл мэндийн төвүүдийг гэрийн эргэлтэд шилжүүлж орон нутгаас шатахууны зардалд 1 сая төгрөгийг шийдвэрлэн олгосон.<br>- “Цахим Эрдэнэт-1” хөтөлбөрийн хүрээнд өрхийн эрүүл мэндийн төвүүдийг тус бүр 1 таблетаар хангаснаар өрхийн гэрийн эргэлтээр тусламж үйлчилгээ үзүүлсэн эмч тухайн иргэний өвчний түүхийн мэдээллийг цахим системээс харах, үзлэгийн бүртгэл шивэлт хийх, хөнгөлөлттэй эмийн жорыг тухай бүрт нь бичиж хүлээгдэл, чирэгдлийг бууруулсан.<br>Сум өрхийн эрүүл мэндийн төвүүдийн тоног | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | төхөөрөмжийн хангалт 98%-тай байна. | |
| 14 | 3.2.1.14. Хүчилтөрөгчийн бэсрэг үйлдвэрийн ашиглалт, аюулгүй ажиллагаа, хүний нөөцийн хангалт, сургалт зэрэгт дэмжлэгт удирдлагаар хангаж ажиллана. | | Хүчилтөрөгчийн хангалтын хувь | 95 | 100 | Хүчилтөрөгчийн бэсрэг үйлдвэр нь цагт 3 ширхэг баллон буюу 18 м3 хоногт 72 ширхэг баллон үйлдвэрлэх хүчин чадалтай, ажиллах 10 цагийн хугацаанд 9 тасгийн 48 төгсгөвч тасалдалгүй ажиллуулсан. Хоногт дунджаар 46 баллоныг цэнэглэн БОЭТ-ийн хэрэгцээнд нийлүүлсэн байна. Хүчилтөрөгчийн ханын системд аюулгүй ажиллагааны зааварчилгаа байршуулж, 26 тасгийн 66 эмч, сувилагчид эмнэлгийн хийн системтэй ажиллах аюулгүй ажиллах заавар зааварчилгааны сургалтыг 4 удаа зохион байгуулсан. Өдөр бүр аюулгүй байдалд хяналт, шалгалт хийж ажилласан. Дулааны улиралд тус үйлдвэрийг 08.00-20.00 цаг хүртэл, өвлийн улиралд 24 цаг ажиллуулж 2 техникч ээлжлэн шалгалт тохируулга хийж ажилласан.<br>Тайлант хугацаанд хүчилтөрөгч үйлдвэр 4,790 баллон цэнэглэж 22,627 м3 хүчилтөрөгч ашигласан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 5%-аар их байна. | 100 |
| 15 | 3.2.1.15. Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлаас сэргийлэх тэмцэх чиглэлээр тухай бүрт гарч байгаа хууль, дүрэм, тушаал, зааврын хэрэгжилтэд байнгын хяналт тавьж ажиллана. | | Хяналтын дүн, зөвлөмж | 3 | 4 | Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 66 дугаар тогтоол, улсын Онцгой комиссын 2022 оны 1 дүгээр тогтоолыг үндэслэн Орхон аймгийн Засаг даргын 2022 оны А/84 дүгээр тоот захирамжаар Коронавируст (КОВИД-19) халдварын тархалтыг шар түвшинд шилжүүлсэн.<br>Коронавируст халдвар (КОВИД-19)-ын тархалтын үе шатыг 24 удаа үнэлж, мэдээ тайланг 7 хоног бүр ХӨСҮТ-д хүргүүлэн ажилласан. Тайлант хугацаанд Коронавируст халдварын 3988 тохиолдол бүртгэгдсэн нь өмнөх оноос 2.5 дахин бага, түргэвчилсэн шинжилгээг 22302 иргэнд, Бх-ПГУ шинжилгээг 9970 иргэнд хийсэн байна. Батлагдсан тохиолдлын ойрын хавьтлын 9958 иргэнд тандалт судалгаа хийсэн. Нийт 70 багц өвчлөл бүртгэгдсэнээс зөөвөрлөгдсөн 25, аж, | 75 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | ахуй нэгж байгууллага 26, найз нөхдийн 19, гэр бүл, хамаатан садны 35 багц өвчлөлийн голомтыг идэвхгүй болсон.<br>ЭМС-ын А/373 дугаар тушаалын дагуу аймгийн Засаг даргын захирамжаар батлагдсан “Амьсгалын замын халдварт өвчинтэй тэмцэх сэргийлэх” ажлын хэсэг 2 удаа хуралдаж 5 бүлэг 46 заалт бүхий төлөвлөгөө батлуулан хэрэгжүүлж, төлөвлөгөөний хэрэгжилт 95% байна.<br>ЭМГ-ын даргын А/80 дүгээр тушаалаар гамшиг, нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үед ажиллах эрүүл мэндийн албаны бүтэц бүрэлдэхүүнийг шинэчлэн томилж нийт 7 удаагийн дадлага, сургуулилтыг хийсэн.<br>Мэргэжлийн хяналтын газартай хамтран ажиллах гэрээ байгуулж, эрсдэл өндөр 34 байгууллагуудад эрүүл зүйн шинжилгээ хийлгэхэд, эмгэг төрөгч илрээгүй.<br>Эрүүл мэндийн байгууллагуудын төрөл, үзүүлж буй тусламж үйлчилгээ чиглэлээс хамааран хуваарийн дагуу дэмжлэгт хяналтыг 3 удаа хийж, зөвлөмж өгч ажилласан. | |
| 3.2.2. Нийтийн эрүүл мэндийн тусламжийн бодлого, хэрэгжилтийг зохицуулах чиглэлээр | | | | | | | |
| 16 | 3.2.1.1. Нийгмийн эрүүл мэндийн төв байгуулах бэлтгэл ажлыг хангана. | | Бэлтгэл ажлын хэрэгжилтийн хувь | - | 80 | Аймгийн Засаг даргын 2021 оны А/253 дугаар захирамжаар Эрүүл мэндийн газрын бүтцэд Нийгмийн эрүүл мэндийн төвийн бүтцийг 10 эмч, мэргэжилтний орон тоотойгоор баталж аймгийн хүн нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг удирдлага арга зүйгээр ханган ажилласан. Тайлант хугацаанд Нийгмийн эрүүл мэндийн төвд 2 мэргэжилтэн шинээр ажилд авч хангалтыг нэмэгдүүлсэн. Нийгмийн эрүүл мэндийн төвийн давхардсан тоогоор 9 мэргэжилтэн чадавхжуулах сургалтад, халдварын тандалт сэргийлэлтийн мэргэжилтэн мэргэжил олгох сургалтад | 80 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хамрагдсан. Нийгмийн эрүүл мэндийн төвд нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний үндсэн нэгж болох хэвлэлийн студи, хоол шим тэжээлийн боловсрол олгох кабинет, чийрэгжүүлэлтийн кабинет, сэтгэ зүйн зөвлөгөө өгөх кабинет ажилла:ж байгаагаас гадна гамшгийн нөөцийн өрөө, дархлаажуулалтын хүйтэн хэлхээ байрлаж байна. Тус төвийн 2 давхарт Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн харьяа Эрүүл мэндийг дэмжих төвийг байгуулан улс болон орон нутгаас нийт 2,0 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтыг хийснээс орон нутгаас их засварын ажилд 289,0 сая төгрөг, улсын төсвөөс их засварт 180,0 сая, багаж тоног төхөөрөмжид 1,5 тэрбум төгрөгийн үзлэг шинжилгээ болон оношилгооны 34 нэр төрлийн багаж тоног төхөөрөмжөөр хангагдан үйл ажиллагааг эхлүүлсэн. Тайлант хугацаанд Эрүүл мэндийг дэмжих төвд 2908 буюу насанд хүрэгчдийн 4,2% үзлэгт хамрагдсан байна. | |
| 17 | 3.2.2.2. Салбарын хэмжээнд эрүүл мэндийн чиглэлээр хэрэгжих зорилтот арга хэмжээ (“Халдварт бус өвчин”, “Халдварт өвчний эсрэг цогц арга хэмжээ”, “Хавдрын эсрэг арга хэмжээ”, “Элэг бүтэн Монгол” гэх мэт)-г өөрийн орон нутгийн түвшинд хэрэгжүүлэх дэд төлөвлөгөө батлан ажиллана. | ОНТ 267,0 сая | Төлөвлөгөөний дундаж хэрэгжилт | 87,7 | 87,8 | Орон нутгийн түвшинд 5 арга хэмжээний төлөвлөгөө батлагдан хэрэгжиж, хэрэгжилт дунджаар 83,8 хувьтай байна. Тайлант хугацаанд арга хэмжээнүүдийн хүрээнд 267,0 сая төгрөгийн дэмжлэгийг орон нутгаас шийдвэрлэсэн.<br>- Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2022 оны 05 дугаар сарын 03-ны өдрийн 09/05 дугаар тогтоолоор 70.0 сая төгрөг батлагдан тайлант хугацаанд 130 хорт хавдартай иргэнд буцалтгүй тусламж үзүүлсэн.<br>- “Томуу, томуу төст өвчний урьдчилан сэргийлэх болон дэгдэлтийн үеийн хариу арга хэмжээнд орон нутгаас 150 сая төгрөгийг шийдвэрлэсэн.<br>- Зонхилон тохиолдох халдварт бус өвчний эрт илрүүлэг эрчимжүүлэх, эрүүл мэндийн боловсрол олгох чиглэлээр 12,0 сая төгрөгийг шийдвэрлэн 280 | 70 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | иргэнийг сургалтад хамруулж, 5 төрлийн 5000 ширхэг гарын авлага хэвлүүлэн, 1 теле цэнгээнт нэвтрүүлгийг бэлтгэн иргэдэд хүргэснээр эрт илрүүлэг үзлэг 6,3%-аар ахисан.<br>- Орон нутгийн төсвөөс 12.0 сая төгрөгийг шийдвэрлэснээр зорилтот бүлгийн 500 иргэнийг бэлгийн замаар дамжих халдварын эрт илрүүлэгт хамруулж, ерөнхий боловсролын сургуулийн 23 эрүүл мэндийн багш, 27 сурагчийг үе тэнгийн сургагч багшаар бэлтгэсэн.<br>- "Эх хүүхдэд ээлтэй өрхийн эрүүл мэндийн төв" шалгаруулах 3 сарын болзолт уралдааныг Орон нутгийн 5,0 сая төгрөгийн санхүүжилтээр зохион байгуулж, 3 өрхийн эрүүл мэндийн төвийг шалгаруулсан.<br>- "Зүрх мартахгүй" төслийн хүрээнд зүрхний төрөлхийн гажигтай 0-16 насны 152 хүүхдийг үзлэгт хамруулж, 45 хүүхдийг хагалгаанд оруулахаар 13,0 сая төгрөгийг шийдвэрлэсэн.<br>- Элэгний В, С, Д вирусийн илрүүлэг шинжилгээнд 8658 иргэн хамрагдсанаас 555 хүн буюу 6.4 хувьд нь С вирус, 551 хүн буюу 6.3 хувьд нь В вирус илэрсэн. Эмчийн хяналтад 258 иргэн эмчилгээ хийлгэсэн.<br>- Тайлант хугацаанд арга хэмжээнүүдийн хүрээнд нийт 211851 урьдчилан сэргийлэх үзлэг хийгдсэн. Мөн 1163 удаагийн сургалт, сурталчилгаа зохион байгуулж давхардсан тоогоор 65950 иргэнийг хамруулж, 1550 удаагийн мэдээ сурвалжилгыг орон нутгийн телевизүүдтэй хамтран бэлтгэж иргэдэд хүргэсэн байна. | |
| 18 | 3.2.2.3. Хүн амын дунд зонхилон тохиолдож буй халдварт бус өвчих (элэг, хөх, | | -Артерийн даралт ихсэх өвчний эрт | 54 | 64.0 | Тайлант хугацаанд хөх, умайн хүзүү, элэгний хатуурал, хорт хавдар, чихрийн шижин, цусны даралт ихсэх зэрэг өвчнийг эрт илрүүлэх үйл ажиллагааг | 73,6 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | умайн хүзүүний хорт хавдар, чихрийн шижин, цусны даралт) зэрэг эрт илрүүлэх үзлэг иргэдэд өгөх мэдээлэл, сургалт, сурталчилгааг эрчимжүүлэн салбар хоорондын уялдааг ханган ажиллана. | | илрүүлэгт хамрагдсан 18 ба түүнээс дээш насны хүн амын эзлэх хувь<br>-Чихрийн шижин хэв шинж-2 өвчний эрт илрүүлэгт хамрагдсан 40 ба түүнээс дээш насны хүн амын эзлэх хувь<br>-Хөхний өмөнгийн эрт илрүүлгийн үзлэгт хамрагдсан 30 ба түүнээс дээш насны эмэгтэйчүүдийн тоо<br>-Умайн хүзүүний эрт илрүүлгийн үзлэгт хамрагдсан 30 ба түүнээс дээш насны эмэгтэйчүүдийн тоо | 68,3<br>12898<br>28,9 | 78,3<br>13543<br>33,9 | зохион байгуулж үр дүнг тооцон ажилласан. Эрт илрүүлэг үзлэг 40.5% байна. Үүнд:<br>- Артерийн гипертензи эрт илрүүлгийн үзлэгт 28981 буюу хамрагдвал зохих хүн амын 42,2 хувийг эзэлж, өмнөх оноос 1,2 хувиар өсч үр дүнгийн үзүүлэлтээр 0.7 хувь нь онош батлагдсан.<br>- Чихрийн шижин өвчний эрт илрүүлгийн үзлэгт 17717 буюу хамрагдвал зохих хүн амын 52,2 хувийг эзэлж, өмнөх оноос 4,9 хувиар буурч, үр дүнгийн үзүүлэлтээр 0.2 хувь онош батлагдсан байна.<br>- Хөхний эрт илрүүлэг үзлэгт 12678 эмэгтэй хамрагдаж, хамрагдвал зохих насны эмэгтэйчүүдийн 36.8 хувийг эзэлж, өмнөх оны мөн үеэс 33.7 хувиар буурсан байна.<br>- Умайн хүзүүний эрт илрүүлэг үзлэгт зорилтот насны нийт 2458 эмэгтэй хамрагдаж, хамрагдвал зохих насны эмэгтэйчүүдийн 30.9 хувийг эзэлж, өмнөх оны мөн үеэс 7.1 хувиар буурсан ба 1392 буюу 86.9 хувь нь пап шинжилгээнд хамрагдсан байна.<br>- Халдварт бус өвчний эрсдэлт хүчин зүйлсийг бууруулах, сэргийлэх чиглэлээр 35 төрлийн постер зөвлөмжийг 18569 иргэнд хүргэж, 3 өдөрлөгт давхардсан тоогоор 4786 иргэнийг хамруулан 6 эх бэлтгэл, 3 шторка бэлтгэн цахим хуудсаар иргэдэд хүргэсэн. | |
| 19 | 3.2.2.4. Сургуулийн өмнөх | | Салбар дундын | 5 | 14 | Ерөнхий боловсролын сургуулиудын эрүүл мэндийн | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | болон сургуулийн хүүхдийн эрүүл мэндийг хамгаалах, эрүүл мэндийн боловсрол олгох хичээлийн чанар, хүртээмж, амны хөндийн эрүүл мэндийг сайжруулах, осол гэмтлээс сэргийлэх, "Үдийн хоол" хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд салбар дундын оролцоог хангана | | оролцоотой зохион байгуулсан арга хэмжээний тоо | | | хичээлийг 7 хоногт 1 цаг орж байгаа бөгөөд Эрүүл мэндийн хичээлийг бага ангид анги удирдсан багш, 6-12 дугаар ангид биологийн болон "Биеийн тамир–Эрүүл мэнд" мэргэжлийн дипломтой багш нар зааж ажилласан. Аймгийн хэмжээнд 24 сургуульд 177 багш эрүүл мэндийн хичээл орж байгаагаас бага боловсролын түвшинд 133, суурь болон бүрэн дунд боловсролын түвшинд 44 багш эрүүл мэндийн хичээл орсон байна. Хүүхдийн эрүүл мэндийг дэмжих чиглэлээр ерөнхий боловсролын сургуулиудад "Эрүүл хүүхэд", төслийг орон нутгийн 100,0 сая төгрөгийн санхүүжилтээр хэрэгжүүлж 8553 хүүхдийг "Өглөөний цайгаа ууцгаая" аянд хамруулсан. Сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тухай хууль, үдийн хоол хэрэгжилтийн хүрээнд БШУГ-тай хамтран 10 удаагийн арга хэмжээг зохион байгуулан, хяналт тавьж, үйл ажиллагаанд арга зүйн зөвлөмж өгч ажилласан. Цэцэрлэг, сургуулийн дотуур байрны ус, ариун цэвэр, эрүүл ахуйд тавигдах норм шаардлага батлах тухай А/253, 251/173 дугаар тушаалд үнэлгээ хийхэд "Гал тогоо болон хоол хүнс боловсруулахад тавигдах шаардлага", "Хүнсний эрүүл ахуйн байдал"-ын дундаж хэрэгжилт 70 хувь болж, өмнөх онтой харьцуулахад 2%-аар өссөн үзүүлэлттэй байна. Ерөнхий боловсролын сургуулиудад хоол зүйчийн орон тоог орлон гүйцэтгэж буй эмч нарт хоол, шим тэжээлийн ойлголт, мэдлэг олгох сургалтыг 8 удаа зохион байгуулж давхардсан тоогоор 370 хүнийг хамруулсан. Ерөнхий боловсролын төрийн өмчийн 17 сургууль, хувийн өмчийн 5 сургуульд "Үдийн хоол" хөтөлбөрийн хүрээнд 1-5 дугаар ангийн 12289 сурагчид халуун хоолоор үйлчилж байгаа ба өдөр тус бүрээр үдийн хоолны илчлэгийг тооцооны аргаар тооцоход 580-630 ккал бүхий илчлэгтэй байгаа нь өдөрт авах нийт | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | илчлэгийн хэмжээг хангаж байна.<br>БШУГ-тай хамтран зонхилон тохиолдох халдварт болон халдварт бус өвчин, амны хөндийн эрүүл ахуй, осол гэмтлээс сэргийлэх чиглэлээр эрүүл мэндийн сургагч багш бэлтгэх 5 удаагийн сургалтад сургууль, цэцэрлэгийн эмч, эрүүл мэндийн багш, цэцэрлэгийн арга зүйч, цэцэрлэгийн эрхлэгч, сургуулийн захирлууд нийт 152 хүнийг хамруулсан бөгөөд мэдлэгийн түвшнийг үнэлэхэд дунджаар 17-28%-аар дээшилсэн байна. Салбар дундын оролцоотой 16 арга хэмжээг зохион байгуулсан байна. | |
| 20 | 3.2.2.5. Нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдал, халдварт өвчний дэгдэлт, цар тахлын үеийн хариу арга хэмжээний бэлэн байдлыг хангаж ажиллана. | | Төлөвлөгөөний хэрэгжилт | 90 | 91 | Нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдал, халдварт өвчний дэгдэлт, цар тахлын үеийн хариу арга хэмжээний бэлэн байдлыг хангаж ажилласан. Үүнд:<br>- ЭМГ-ын даргын А/80 дүгээр тушаалаар гамшиг, нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үед ажиллах эрүүл мэндийн алба бүтэц бүрэлдэхүүнийг шинэчлэн томилсон.<br>- Гамшгаас хамгаалах иж бүрэн дадлага сургуулилтад оролцож жагсаалын үзлэг 6 удаа, танхимын сургалт 5 удаа, хээрийн эмнэлэг дэлгэх үзүүлэх сургуулилтыг хийж “Онц” үнэлгээгээр дүгнэгдсэн. ЭМГ-аас 2.7 сая төгрөгөөр иж бүрэн хамгаалах хувцас хэрэгслээр хангасан. Чадавх 95%-тай болсон нь өмнөх оноос 15%-аар нэмэгдсэн.<br>- Эрүүл мэндийн гамшгийн нөөцийг нэмэгдүүлж Эрүүл мэндийн яамнаас 5 удаагийн 885,3 сая төгрөгийн нөөц хангалт хийгдсэн. Бусийн оношилгоо эмчилгээний төв, сум, өрхийн эрүүл мэндийн төвүүдэд 690,3 /85,1%/ сая төгрөгийн эм эмнэлгийн хэрэгсэл хамгаалах хэрэгсэл олгож нөөцийг нэмэгдүүлсэн. Гамшиг, нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үеийн нөөцөд 12 нэр төрлийн 289,5 сая төгрөгийн эм, эмнэлгийн хэрэгсэл, | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | халдваргүйтгэлийн бодис байна. 2022 оны байдлаар Эрүүл мэндийн байгууллагуудын нөөц бүрдүүлэлт дунджаар 89,8%-тай, 54 хоногийн нөөцтэй байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 52,1%-аар нэмэгдсэн<br>- Лабораторийн чадавх өмнөх оноос 8,5%-аар нэмэгдэж 88,5% байна.<br>- Тандалтын 9 багийг 2 удаагийн чадавхжуулах сургалтад хамруулсан.<br>- Коронавируст /КОВИД-19/-ын цар тахалтай тэмцэх, халдвар хамгааллын дэглэм баримтлах, халдварын үеийн оношилгоо, эмчилгээ зэрэг сэдвээр давхардсан тоогоор 1184 эмч мэргэжилтэн, ажилтан, нийт эрүүл мэндийн салбарын ажилтнуудын 64,7%-ийг сургалтад хамруулсан.<br>Хариу арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилт 92.3%-тай хэрэгжсэн. | |
| 21 | 3.2.2.6. Сүрьеэ өвчний илрүүлэлтийн хувийг зорилтот түвшинд хүргэх, далд хэлбэрийн сүрьеэг илрүүлэх арга хэмжээг зохион байгуулж, үр дүнг тооцно. | | Сүрьеэгийн нийт үзлэгт эзлэх урьдчилан сэргийлэх, эрт илрүүлгийн хувь | 86,6 | 87 | Тайлант хугацаанд сүрьеэгийн үзлэгт нийт 8859 хүн хамруулснаас 87,5% нь урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэгт хамрагдсан байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад урьдчилан сэргийлэх үзлэг 19.9%-иар өссөн. Сүрьеэгийн эрт илрүүлгийн үзлэг шинжилгээг эрчимжүүлэх чиглэлээр бүсийн оношилгоо эмчилгээний төв, сум, өрхийн эрүүл мэндийн төвүүдтэй хамтарч 186-р цэргийн ангийн 168 хугацаат цэрэг, алба хаагч, Эрдэнэт үйлдвэрийн 26 ажилтан, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын нээлттэй 437-р хорих ангийн албан хаагч болон хүмүүжигч 198, цэргийн насны 525 залуучуудыг үзлэгт хамруулж сэжигтэй 7 тохиолдол илрүүлж цэрний шинжилгэгээр 1 тохиолдол батлагдаж эмчилгээнд хамруулсан. Сүрьеэгийн диспансерын хяналтад 29 өвчтөн эмчлэгдэж байна. Эмчилгээний амжилт 79%-тай байна. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Тайлант хугацаанд сүрьеэгийн өвчлөл 51 бүртгэгдэж, 10000 хүн амд 4,8 байна. Тус хугацаанд тандалт судалгаа 2 хийгдсэн. Үүнд:<br>- Сүүлийн 4 жилд бүртгэгдсэн сүрьеэгийн шинэ тохиолдлуудын дунд тандалт, судалгаа хийхэд тохиолдлын тоо 5 болон 10 саруудад босго үзүүлэлтээс дээгүүр, эрэгтэйчүүдийн сүрьеэгийн тохиолдол эмэгтэйчүүдтэй харьцуулахад 40%-аар илүү бүртгэгдсэн бөгөөд өвчлөл 15-29 нас, 65-аас дээш насныхны дунд өндөр, нас баралт 60-аас дээш насныхан дунд их, нийт бүртгэгдсэн тохиолдлын 61%-д уушгины сүрьеэ илэрч байгаа нь цаашид сүрьеэгийн халдвар өсөх хандлагатай байгааг харуулж байлаа.<br>- Сумын эмч мэргэжилтнүүдийн холбооноос хавьтлын үзлэг шинжилгээнд 1.4 сая төгрөгийг шийдвэрлэн сүүлийн 4 жилийн сүрьеэ өвчин батлагдсан 270 иргэний ойрын хавьтлын 325 иргэнийг өрхийн эрүүл мэндийн төвүүдтэй хамтран дижитал рентген болон сүрьеэ илрүүлэх асуумжид хамруулснаар сүрьеэгийн сэжигтэй 8 тохиолдлыг илрүүлж цэрний түрхцийн шинжилгээнд илгээснээс 1 эерэг, уушгины сөрөг 2, хавдар 1 тохиолдлыг илрүүлсэн. | |
| 22 | 3.2.2.7. Бэлгийн замаар дамжих халдварыг илрүүлэх урьдчилан сэргийлэх үзлэгт зорилтот бүлгийг хамруулах арга хэмжээг төр, төрийн бус байгууллага, ажил олгогчидтой хамтран зохион байгуулж, халдвартай иргэдийг эмчилгээнд бүрэн хамруулж, эмчилгээний үр дүнг тооцон ажиллана | ОНТ<br>12,0 сая | БЗДХ-ын илрүүлэг үзлэгийн хамралтын хувь | 36,2% | 40% | Тайлант хугацаанд 4876 иргэн бэлгийн замаар дамжих халдварын эрт илрүүлэг, оношилгоонд хамрагдсанаас 70,9% нь эрт илрүүлэх урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдсан байна. Сум, өрхийн эрүүл мэндийн төвүүдэд ХДХВ-ийн шинжилгээнд 1939, тэмбүүгийн шинжилгээнд 1961 иргэнийг хамруулсан. “БЗДХ/ХДХВ/ДОХ-ын тусламж үйлчилгээ, урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны өнгөрсөн хугацааны ололт амжилт, тулгамдаж буй асуудал” хэлэлцүүлгийг 10 салбарын 15 төлөөллийг хамруулан зохион байгуулж, тулгамдсан 3 асуудлыг хэлэлцэн | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | шийдвэрлэсэн. БЗДХ/ХДХВ/ДОХ-ын зорилтот бүлэгт чиглэсэн үйл ажиллагааны чиглэл бүхий “Залуус–Эрүүл мэнд”, “Төгс бүсгүйчүүд” төрийн бус байгууллагын үйл ажиллагааг идэвхжүүлж, арга зүйн зөвлөмжөөр ханган, давхардсан тоогоор 680 эмэгтэй болон залуусыг үзлэг шинжилгээнд үнэгүй хамруулж, сургалт сурталчилгааг зохион байгуулсан. ДОХ/ХДХВ/БЗДХ-ын эрт илрүүлэг, оношилгооны хамрагдалтыг эрчимжүүлэхээр сургалтад 1689, сурталчилгаанд 1325 хүн хамруулж, ганцаарчилсан зөвлөгөөг 1568 хүнд өгч, 1535 ширхэг гарын авлага түгээн, цахим сурталчилгааг 13240 хүнд хүргэж ажилласан. Орон нутгийн төсвөөс 12.0 сая төгрөгийг шийдвэрлэснээр зорилтот бүлгийн 500 иргэнийг бэлгийн замаар дамжих халдварын эрт илрүүлэгт хамруулж, ерөнхий боловсролын сургуулийн 23 эрүүл мэндийн багш, 27 сурагчийг үе тэнгийн сургагч багшаар бэлтгэсэн.<br>Тайлант хугацаанд бэлгийн замаар дамжих халдварын 154 тохиолдол бүртгэгдсэнээс 48,7%-ийг тэмбүү, 22,1%-ийг заг хүйтэн, 29,2%-ийг трихомониаз тус тус эзэлж, нийт халдварт өвчний 3,2%-ийг эзэлж байгаа нь өнгөрсөн оны мөн үеэс 1,7%-аар, 10 000 хүн амд 14,5 промилл байгаа нь өмнөх оны мөн үеэс 6,3 промиллоор тус тус нэмэгдсэн байна. | |
| 23 | 3.2.2.8. Сэтгэцийн эрүүл мэнд, ялангуяа хүүхэд, өсвөр үеийнхэнд сэтгэлзүйн тусламж үйлчилгээг үзүүлэх, сэтгэцийн эрүүл мэндийг дэмжих, хамгаалах, архи, тамхи, мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисын хор хөнөөл, түүний талаарх | | Зохион байгуулсан арга хэмжээний тоо | 18 | 26 | Аймгийн Засаг даргын 268-р захирамжийн дагуу “Бүх хайраа гэр бүлдээ сэтгэл зүйн өдөрлөг, 91 хүнд сэтгэл зүйн ганцаарчилсан зөвлөгөө, 24 төрлийн сэтгэц оношилгоонд 255 иргэн, бүлгийн сэтгэл зүйн зөвлөгөөнд 240 иргэн, 8 удаагийн сэтгэл зүйн сургалтад 712 иргэнийг хамруулж, 4 удаагийн шторк, 5 удаагийн мэдээлэл хүргэн, цахимаар 12500 гаруй иргэнд сэтгэл зүйн цогц тусламж үйлчилгээг үзүүлсэн. Ерөнхий боловсролын 5 сургуулийн ахлах ангийн 885 | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | мэдлэг олгох, хэрэглээг бууруулах, урьдчилан сэргийлэх, осол гэмтлээс сэргийлэх (ахуйн орчны осол гэмтэл, уналт, авто тээврийн гэх мэт) зэрэг салбар дундын хамтын ажиллагааг хангаж хамтарч ажиллана. | | | | | сурагчаас “Өсвөр насны хүүхдийн сэтгэл гутрал, стресс, өөрийн үнэлгээ, цахим хамаарлын түвшин болон түүний гэр бүлийн байдал, оршин суугаа харьяалал хоорондын хамаарлын байдлыг судлахад 55.4% өөртөө итгэх итгэлтэй, 1.8% өөрийн үнэлгээ багатай, 14.4% сэтгэл гутралын хүндэвтэр түвшин, 7.9% сэтгэл гутралын хүнд түвшинд, 33.2% стрессийн түвшин өндөр, 70,9% интернэтийг эрсдэлтэй нөхцөлд ашигладаг гэсэн үр дүн гарсан байна.<br>“Сэтгэлийн анир III” зорилтот төслийн хүрээнд хөгжлийн бэрхшээлтэй байнгын асаргаанд байдаг хүүхдүүд болон тэдний асран хамгаалагчдыг 4 удаагийн сэтгэл зүйн бүлгийн ярилцлага, 5 удаагийн сэтгэл зүйн сургалтад хамруулж, 75 хөгжлийн бэрхшээлтэй иргэнд сэтгэл зүйн цогц тусламж үйлчилгээг үзүүлэн, 15 удаагийн шторк бичлэгийг цахимаар сурталчлан 43000 гаруй иргэн цахим хандалт хийсэн байна.<br>Эрүүл мэндийг дэмжих сангийн санхүүжилтээр хэрэгжүүлсэн эрүүл мэндийн боловсрол олгох төслийн хүрээнд 10 удаагийн сургалтад 170 багш, нийгмийн ажилтанд сэтгэцийн эрүүл мэнд, архи, тамхи, мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисын хор хөнөөл, осол гэмтлээс урьдчилан сэргийлэх чиглэлээр сургалт, цэцэрлэгийн 75 багшид “Сэтгэл зүйн бүлгийн ярилцлагыг зохион байгуулсан. Осол гэмтлээс сэргийлэх чиглэлээр 5 удаагийн сургалтад 250 төрийн болон төрийн бус байгууллагын төлөөллийг хамруулсан.<br>Тайлант хугацаанд осол гэмтлийн өвчлөл 619 бүртгэгдсэнээс зам тээврийн осол 144 тохиолдол буюу 23,3%-ийг эзэлж өмнөх оны мөн үеэс 3,5%-аар буурсан. Зам тээврийн ослын шалтгаант нас баралт 3 бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 5 тохиолдол буюу | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | 2,7 дахин буурсан.<br>Салбар дундын хамтын ажиллагааны хүрээнд нийт 26 арга хэмжээг зохион байгуулсан. | |
| 24 | 3.2.2.9. Хөгжлийн бэрхшээлтэй иргэн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ авах нөхцлийг бүрдүүлэн эрүүл мэндийн байгууллагын гадаад, дотоод орчны тохижилт (тэргэнцэрт зориулсан үүдний хэсэг, хананы бариул, дуугүй хөтөч, тусгайлсан жорлон, дуут дохио гэх мэт)-ыг сайжруулна. | | Хөгжлийн бэрхшээлтэй иргэн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ авах нөхцөлийг бүрдүүлсэн эрүүл мэндийн байгууллагын хувь | 75% | 75,1% | Тайлант хугацаанд хөгжлийн бэрхшээlтэй иргэдэд ээлтэй орчныг бүрдүүлэх зорилгоор эрүүл мэндийн байгууллагуудын 80%-д нь хөгжлийн бэрхшээлтэй иргэн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ авах гадна болон дотоод орчны тохижилт хийгдэж, өнгөрсөн оноос 5%-аар нэмэгдсэн. Үүнд:<br>- БОЭТ-ийн гадна зам талбай, хүлээн авахыг засварлан тэргэнцэртэй хүн орох боломжийг бүрдүүлж, амбулаторийн лифтийг ашиглалтад оруулсан. Хэвтүүлэн эмчлэх тасгуудын ариун цэврийн өрөөг нэмэгдүүлж, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан стандартад нийцүүлсэн.<br>- Эрүүл мэндийн байгууллагуудад ханын бариул 60%, тэргэнцэрийн тоо 105 болж өмнөх оноос 4%-иар нэмэгдсэн байна.<br>- Хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагуудын 80%-д нь хөгжлийн бэрхшээлтэй иргэн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ авах гадна болон дотоод орчны тохижилт хийгдсэн нь өмнөх оноос 5%-аар сайжирсан<br>- Сум, өрхийн эрүүл мэндийн төвүүдэд хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд асаргаа сувилгаа үзүүлэхэд шаардлагатай орчны тохижилтыг бүрэн хийж, 100% суудлын тэргэнцрээр хангагдсан.<br>- Аймгийн ЗДТГ, Хөдөлмөр, халамж үйлчилгээний газартай хамтран дохионы хэлний анхан шатны сургалтад 17 эрүүл мэндийн байгууллагын 34 эмч, мэргэжилтнийг хамруулж хөгжлийн бэрхшээлтэй иргэд эмнэлгийн тусламж үйлчилгээг саадгүй авах боломж бүрдүүлсэн.<br>- Бусийн оношилгоо эмчилгээний төвд 2021 оны 11 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | дүгээр сараас “Хан шунхлай нуруу” ХХК-ийн 8 хөтөч сувилагчийг ажиллуулснаар үйлчлүүлэгчийн сэтгэл ханамж 90% болж өмнөх оноос 15%-иар нэмэгдэж, иргэдийн тодорхойгүй, мэдээлэлгүй, ойлгомжгүй байдал 88,2 хувиар багассан. | |
| 25 | 3.2.2.10. Эрүүл ахуйн тухай хуулийн хэрэгжилтийг хангах, ундны ус, ариун цэврийн байгууламжийн төлөвлөгөө хэрэгжүүлэх, стандартын дагуу жорлон, муу усны нүх барьж, ашиглах, нийтийн эзэмшлийн зам, талбайд нус, цэр хаяхгүй байх хөдөлгөөн өрнүүлж ажиллана. | | Зохион байгуулсан арга хэмжээний тоо | 3 | 3 | - Дэлхийн усны өдрийн хүрээнд мэргэжлийн 7 байгууллагатай хамтран аймгийн хэмжээнд 13 төрлийн арга хэмжээг зохион байгуулсан. Мөн эрүүл мэндийн салбарын хүрээнд зохион байгуулах ажлын төлөвлөгөөг эрүүл мэндийн газрын даргын удирдамжаар батлан, салбаруудад хүргүүлж, хэрэгжилтийг 92% хангаж ажиллалаа.<br>- “Хог хаягдлын менежментийг иргэдийн оролцоотой сайжруулах” орон нутгийн дэд хөтөлбөрийн хүрээнд хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилж, хог хаягдлын хэмжээг багасгах, иргэдийн мэдлэг, хандлагыг нэмэгдүүлэх, сайн туршлагыг салбарын хэмжээнд нэвтрүүлэн ажиллалаа. Төлөвлөгөөний биелэлт 81,6%-тай хэрэгжиж байна.<br>- Хувийн хэвшлийн 5 байгууллага Баян-Өндөр сумын багуудад хуваарийн дагуу халдваргүйтгэл, мэрэгч, шавжгүйтгэлийг хийж гүйцэтгэж байна. Тус байгууллагуудын үйл ажиллагаанд 2 удаагийн зөвлөмж өгч ажиллалаа. Баян- Өндөр сумын гэр хорооллын 14 багийн 260 өрхийн нүхэн жорлон, муу усны нүх болон 145 аж ахуйн нэгжийн 8000м3 талбайд урьдчилан сэргийлэх халдваргүйтгэл хийгдээд байна. Намрын улиралд 477 аж ахуйн нэгж, 464 айл өрхийн 42315м2 талбайд төлбөртэй халдваргүйтгэлийг 3 төрлийн бодис ашиглан хийсэн байна.<br>- Нүхэн жорлонгийн стандартаар 2 төрлийн гарын авлага бэлтгэн тус бүр 100ш түгээж, цахимаар 924 хүнд хүргэсэн. Орон нутгийн хэвлэлээр 2 удаа | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | мэдээлэл өгч, 3 удаагийн нээлттэй хаалганы өдрөөр 300 гаран иргэд зөвлөгөө өгч, 3 төрлийн гарын авлага 450ш түгээж ажилласан. Мөн цахим хуудсаар 4 төлийн мэдээлэл түгээж, 3424 иргэнд хүргэсэн байна. | |
| 26 | 3.2.2.11. Орчны эрүүл мэндийг сайжруулахад салбар дундын оролцоог хангах, ундны ус, хөрс агаарын бохирдлоос хүний эрүүл мэндэд үзүүлэх нөлөөллийг тандан судлах эмч, эмнэлгийн мэргэжилтнийг чадавхжуулах, ундны ус, хэрэглээний бохир усанд мэргэжлийн байгууллагаар тогтмол давтамжтайгаар шинжилгээ хийлгэн, шугам сүлжээний бүрэн бүтэн байдлыг хангаж, засвар үйлчилгээний үед ажилтан, албан хаагчийн аюулгүй байдлыг хангана. | | Хийгдсэн шинжилгээний тоо | 1 | 1 | “Дэлхийн орчны эрүүл мэнд”-ийн өдрийг тохиолдуулан салбар дундын уулзалт зохион байгуулж, 3 асуудал хэлэлцэн шийдвэрлэсэн. Сүүлийн 10 жилд аймгийн ус хангамжийн эх үүсвэр, өргөх, дамжуулан шахах насос станц, усан сан, ус түгээх байр, хэрэглэгчийн цэгээс нийт 1583 дээжид хийсэн шинжилгээний дүнд үнэлгээ дүгнэлт өгөхөд нян судлалын шинжилгээгээр 98.8% нь ундны усны стандартын шаардлага хангасан байна.<br>Ундны уснаас шалтгаалсан зонхилон тохиолдох халдварт болон халдварт бус өвчний сүүлийн 5 жилийн байдалд судалгаагаар:<br>- Гэдэсний халдварт өвчний 75% гэр хороололд бүртгэгдсэн.<br>- Ундны усны эх үүсвэрийн худгийн усанд иодын дундаж агууламж 0.12±0.007 мг/л, ундны усны стандартын шаардлага хангасан.<br>- Ундны ус зөөвөрлөх болон хадгалах савны хэрэглээнд зориулалтын канестрыг 62,5% нь ашигладаг, 60% нь өдрийн хэрэглээндээ 20 хүртэл литр усыг хэрэглэдэг байна.<br>Ус хөрс, агаарын бохирдлын сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх 3 төрлийн гарын авлага, 11 төрлийн мэдээллийг 17549 хүнд хүргэсэн. Орчны эрүүл мэндийн чиглэлээр 84 эмч, эмнэлгийн мэргэжилтнийг чадавхжуулах сургалтад хамруулсан.<br>Ундны ус, хэрэглээний бохир усанд мэргэжлийн хяналтын байгууллагаар тогтмол давтамжтайгаар эмнэлзүйн болон эрүүлзүйн шинжилгээ хийлгэж байгаа бөгөөд тайлант хугацаанд МХГ-аас ундны | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | усны 121 дээж лабораторийн шинжилгээнд хамруулахад стандартын шаардлага хангасан дүгнэлт гарсан.<br>Орон нутгийн төсвийн 150.0 сая төгрөгийн санхүүжилтээр БОЭТ-ийн гадна инженерийн шугам сүлжээний засварыг “Аривлах” ХХК болон гэрээт “Маут Консалтинк” ХХК-тай гэрээ байгуулан хийлгэж, гүйцэтгэл 100% байна | |
| 27 | 3.2.2.12. Нийгмийн эрүүл мэндийн чиглэлээр эрүүл мэндийн боловсрол олгох мэдээлэл, сургалт, сурталчилгаа, эрүүл аж төрөх зан үйлийг төлөвшүүлэх үйл ажиллагааг зохион байгуулах, идэвх санаачилгатай, шинэлэг хэлбэрээр салбар дундын хамтын ажиллагааг ханган хамтарч ажиллана. | | Сургалт сурталчилгаанд хамрагдсан иргэдийн хувь | 90 | 90 | Төрийн болон төрийн бус байгууллагууд, хэвлэл мэдээллийн байгууллагуудтай хамтран урьдчилан сэргийлэх, сургалт сурталчилгааг өргөжүүлэх чиглэлээр хамтран ажилласан. Үүнд:<br>- Тайлант хугацаанд нийт 1278 удаагийн сургалт, сурталчилгаа зохион байгуулж давхардсан тоогоор 155466 /146%/ иргэнийг хамруулж, 20 төрлийн сурталчилгааны материалыг 9951 иргэнд түгээсэн.<br>- Цахим хуудаст 261 төрлийн гарын авлага, шторка, зөвлөмжийг байршуулан давхардсан тоогоор 647002 иргэнд түгээсэн. Нийт иргэдийн 85%-ийг цахимаар мэдээллээр хангасан.<br>- Тайлант хугацаанд эрүүл мэндийг дэмжих чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг 6 төрийн бус байгууллагатай хамтран ажиллаж 3412 хүнийг сургалт сурталчилгаанд хамруулан ажилласан.<br>Өвчлөлөөс урьдчилан сэргийлэх болон цаг үеийн нөхцөл байдлын мэдээллийг өдөр тутам олон нийтийн цахим сүлжээгээр болон аймгийн Засаг даргын тамгын газрын хэвлэлийн алба, орон нутгийн сайт, FM радио, телевизээр дамжуулан иргэдэд хүргэн хамтран ажилласан. | 100 |
| 28 | 3.2.2.13. Нийгмийн эрүүл мэндийн чиглэлээр гарч байгаа тушаал, шийдвэрийг хэрэгжүүлж, хэрэгжилтэд | | Тушаал, шийдвэрийн хэрэгжилтийн хувь | 84,5% | 85% | Монгол улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө, Эрүүл мэндийн сайдын тушаалаар батлагдсан 5 арга хэмжээний | 80 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | байнгын хяналт тавина. | | | | | төлөвлөгөөний хүрээнд орон нутгийн түвшинд 5 арга хэмжээний төлөвлөгөө батлагдан хэрэгжиж, хэрэгжилт дунджаар 83,8 хувьтай байна. Тайлант хугацаанд арга хэмжээнүүдийн хүрээнд 267,0 сая төгрөгийн дэмжлэгийг орон нутгаас шийдвэрлүүлэн хэрэгжүүлсэн. Тайлант хугацаанд нийгмийн эрүүл мэндийн чиглэлээр гарсан тушаал шийдвэрийн хэрэгжилтэд 17 удаагийн хяналтыг хийж, зөвлөмжөөр хангасан. Тушаал шийдвэрийн хэрэгжилт дунджаар 84,9% байна. Үүнд:<br>- Эрт илрүүлэг үзлэгийг эрчимжүүлэх чиглэлээр ажлын хэсэг томилогдож 2 удаагийн хяналтыг хийж, мэргэжил арга зүй, зөвлөмжөөр хангаж ажилласнаар хамралт 6%-аар нэмэгдсэн.<br>- Зоонозын халдварт өвчний чиглэлээр ЭМС-ын 160 дугаар тушаалын хэрэгжилтийг Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн яаралтай тусламж, халдвартын тасаг, сум, өрхийн эрүүл мэндийн төв нийт 11 цэгт дотоодын дэмжлэгт хяналт хийн, зөвлөмж өгч ажиллахад зөвлөмжийн биелэлт 87,3% байна.<br>- Дархлаажуулалтын тухай хууль, тогтоол шийдвэрийн хэрэгжилтэд 4 удаагийн дэмжлэгт хяналт хийж зөвлөмж өгч хамтран ажилласнаар хэрэгжилт 85%-95,5% хүрч, 15,5% өссөн дүнтэй байна.<br>- Аймгийн Засаг даргын тамгын газар, Мэргэжлийн хяналтын газар, Онцгой байдлын газартай хамтран 19 цэцэрлэг, 16 сургуулийн халдвараас сэргийлэх үйл ажиллагаанд 2 удаагийн удирдамжаар хяналт хийж, зөвлөмжөөр хангасан.<br>- Хог хаягдлын менежментийг сайжруулах чиглэлээр удирдамжтай 2, төлөвлөгөөт бус 2 удаагийн хяналтыг бүх шатны эрүүл мэндийн байгууллагуудад хийж, зөвлөмжөөр хангасан ба | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | зөвлөмжийн хэрэгжилт 80,5-88,5% болж, 3% нэмэгдсэн.<br>- Эрүүл мэндийн байгууллагуудын төрөл, үзүүлж буй тусламж үйлчилгээ чиглэлээс хамааран хуваарийн дагуу дэмжлэгт хяналтыг 2 удаа хийж, арга хэмжээ 2 удаа зохион байгуулж, зөвлөмж өгч эргэн хянахад зөвлөмжийн биелэлт 85,7% байна.<br>- Сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тухай хууль, үдийн хоол хэрэгжилтэд Боловсрол шинжлэх ухааны газартай хамтран 1 удаа хяналт хийхэд “Гал тогоо болон хоол хүнс боловсруулахад тавигдах шаардлага”, “Хүнсний эрүүл ахуйн байдал”-ын дундаж хэрэгжилт 70 хувь болж өмнөх онтой харьцуулахад 2%-иар өссөн үзүүлэлттэй байна.<br>- ЭМС-ын 2021 оны “Сургуулийн орчинд хүүхдэд худалдаалахыг хориглосон хүнсний бүтээгдэхүүний жагсаалт батлах тухай” А/370 дугаар тушаалын хэрэгжилт 95 хувьтай байна. | |
| 3.2.4. Анхан шатлалын эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чиглэлээр | | | | | | | |
| 29 | 3.2.4.1.Өрхийн эрүүл мэндийн төвтэй байгуулах гүйцэтгэлийн гэрээгээр хүлээсэн үүргээ бүрэн биелүүлж, өрхийн эрүүл мэндийн төвийн үйл ажиллагааны гүйцэтгэлд хяналт тавин ажиллана. | | Өрхийн эрүүл мэндийн төвтэй байгуулах гүйцэтгэлийн гэрээний хэрэгжилтийн дундаж хувь | 88,2% | 90,0% | Аймгийн Засаг даргын 2022 оны А/104 дүгээр захирамжаар байгуулагдсан өрхийн эрүүл мэндийн төвийн гүйцэтгэлийн гэрээг дүгнэх ажлын хэсэг 2 удаа дүгнэсэн. 2022 оны жилийн эцсээр эрүүл мэндийн тусламж үйлчилгээ бүлгээр 90,1%, төвийн удирдлага, манлайллын бүлгээр 90,6%, нэгдсэн үнэлгээгээр 90.2%-аар үнэлэгдсэн. | 100 |
| 30 | 3.2.4.2. Орон нутгийн хүн амын шилжилт хөдөлгөөнийг үнэн зөв бүртгэх, явуулын иргэдэд үзүүлэх тусламж, үйлчилгээний тасралтгүй байдлыг хангаж ажиллана | | Тусламж үйлчилгээнд хамрагдсан явуулын иргэдийн тоо | 5670 | 8600 | Аймгийн хэмжээнд нийт 8 өрхийн эрүүл мэндийн төв анхан шатны тусламж үйлчилгээг 106145 хүн амд үзүүлэн ажилласан. Баян-Өндөр сумын 22 баг, Жаргалант сумын 4 багтай сум, өрхийн эрүүл мэндийн төвүүд улирал тутамд хүн амын тулгалт хийж ажилласан. Нийт хүн амын 96,8% нь эрүүл мэндийн даатгалд хамрагдсан байна. Тайлант хугацаанд 1977 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | иргэн шилжин ирсэн нь өмнөх оны мөн үеэс 26,3%-аар нэмэгдсэн. Шилжин ирэгчдийг харьяа өрхийн эрүүл мэндийн төвүүд дээр бүртгэн тусламж үйлчилгээг үзүүлэн ажилласан. Тус хугацаанд явуулын 8600 иргэнд тусламж үйлчилгээг үзүүлэн ажилласан байна. | |
| 31 | 3.2.4.3. Алслагдсан орон нутгийн хүн амд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор “Явуулын эрүүл мэндийн тусламж үйлчилгээ”-г бүх сумдад зохион байгуулна. | | Явуулын тусламж үйлчилгээнд хамрагдсан хүний тоо | 845 | 860 | Аймгийн хэмжээнд нээлттэй хаалганы өдөр, өдөрлөгөөр Жаргалант сум, Баян-Өндөр сумын 22 багийн 7650 иргэнд эрт илрүүлэг үзлэг шинжилгээний мэдээллийг хүргэж эрүүл мэндийн тусламж үйлчилгээг үзүүлсэн. Цагдаагийн газар болон Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, хорих ангийн 420 алба хаагчийг хамруулан ажлын байран дээр явуулын үзлэгийг зохион байгуулж, зөвлөмжөөр хангасан.<br>Тайлант хугацаанд нийт 8070 иргэнийг явуулын туламж үйлчилгээнд хамруулсан нь өмнөх оноос 6 дахин нэмэгдсэн байна. | 100 |
| 32 | 3.2.4.4. Сумын эрүүл мэндийн төвийн байр ашиглалт, урсгал засварын зардлыг Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хуулийн дагуу орон нутгийн төсвөөс санхүүжүүлнэ. | | Орон нутгийн төсвийн санхүүжилт | - | 145,0 | Жаргалант сумын эрүүл мэндийн төвийн өргөтгөлийн ажил 477,0 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдэж сумын эмнэлгийн тусламж үйлчилгээний чанар хүртээмж нэмэгдсэн байна. Жаргалант сумын эрүүл мэндийн төвийн барилгын засварт 145,0 сая төгрөгийн төсвийг Жаргалант сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлаар баталж 2023 онд их засварын ажлыг хийлгэхээр шийдвэрлүүлсэн. | 50 |
| 33 | 3.2.4.5. Анхан шатлалын эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чиглэлээр гарч байгаа тушаал, шийдвэрийг хэрэгжүүлж, хэрэгжилтэд байнгын хяналт тавьж ажиллана. | | Тушаал, шийдвэрийн хэрэгжилтийн хувь | 81% | 82% | Анхан шатлалын эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чиглэлээр гарч байгаа тушаал, шийдвэрийн хэрэгжилтэд 4 удаагийн хяналт хийхэд дунджаар хэрэгжилт 83,3%-тай байна. Үүнд:<br>- ЭМС-ын 2022 оны А/104 “Журам, гэрээний загвар, шалгуур үзүүлэлт батлах тухай” дугаар тушаалын дагуу өрхийн эрүүл мэндийн 8 төвтэй гэрээ байгуулан гүйцэтгэлийн гэрээний хэрэгжилт эхний хагас жилээр дунджаар 79,8%-тай дүгнэгдсэн. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Жилийн эцсийн гүйцэтгэлийн гэрээг дүгнэгдэж байна.<br>- Хүн амын нас, хүйс, эрүүл мэндийн эрсдэлд суурилсан зонхилон тохиолдох халдварт болон халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, шинжилгээ, оношилгоо, зохион байгуулах журмын хэрэгжилтэд 2 удаа хяналт хийж, зөвлөмжөөр хангасан. Тайлант хугацаанд 0-5 насны эрт илрүүлэг 8176 буюу хамрагдвал зохих хүн амын 66.7%, 6-17 насны эрт илрүүлэгт 11553 буюу хамрагдвал зохих хүн амын 11553 буюу 42.7% тус тус хамрагдаж хэрэгжилт 80%-тай байна.<br>- ЭМС-ын 2020 оны А/126 “Нэн шаардлагатай тусламж, үйлчилгээний багц батлах тухай” тушаалын хэрэгжилт 90% байна. Үүнд: халдварт бус өвчний эрт илрүүлгийн дундаж 40,2%-тай байна. Жирэмсний эрт үеийн хяналт 96,5%, өмнөх оны мөн үеэс эрт үеийн хяналт (0.3) хувиар буурсан. Аймгийн хэмжээнд тайлант хугацаанд 13221 хүүхэд буюу 98.7 хувь байна. | |
| 3.2.5. Эх, хүүхдийн эрүүл мэндийн чиглэлээр | | | | | | | |
| 34 | 3.2.5.1. Эх, нялхас, 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл, ялангуяа сэргийлж болох эндэгдлийг тууштай бууруулах чиглэлээр тэгш хүртээмжтэй, чанартай тусламж, үйлчилгээг орон нутгийн түвшинд зохион байгуулна. | | Эхийн эндэгдэл<br>Нялхсын эндэгдэл //1000 амьд төрөлт тутамд/<br>5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл /1000 амьд төрөлт тутамд/ | 1<br>12.6<br>13.3 | 0<br>4,3<br>4,8 | “Эх, хүүхэд нөхөн үржихүйн эрүүл мэнд" арга хэмжээг 2021-2024 онд хэрэгжүүлэх төлөвлөгөөний хэрэгжилт 85% байна. Тайлант хугацаанд:<br>- Жирэмсний хяналт, эх хүүхдийн тусламж үйлчилгээний чанарыг сайжруулахаар салбаруудад мэдээлэл 5, 5 удаагийн хяналт хийж, зөвлөмж 3 удаа хүргүүлж ажилласан.<br>- Орон нутгийн 5,0 сая төгрөгийн санхүүжилтээр "Эх хүүхдэд ээлтэй өрхийн эрүүл мэндийн төв" 3 сарын болзолт уралдааныг зохион байгуулж, 3 өрхийн эрүүл мэндийн төвийг шалгаруулж, урамшуулсан.<br>- Орон нутгаас төсөв шийдвэрлэж амьсгал хямралын хам шинжтэй, дутуу төрсөн 15 нярайд сурфактант эмчилгээг хийж, 86,6 хувийн үр дүн өгсөн байна. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | - Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газартай хамтран 2,0 сая төгрөгийн төсвөөр зорилтот бүлгийн 100 хүүхдийг аминдэмжүүлсэн.<br>- "Зүрх мартахгүй" төслийн хүрээнд зүрхний төрөлхийн гажигтай 0-16 насны 152 хүүхдийг үзлэгт хамруулж, 45 хүүхдийг хагалгаанд оруулахаар 13,0 сая төгрөгийг шийдвэрлэсэн.<br>- Давхардсан тоогоор сум, өрхийн 112, хүүхдийн байгууллагын 52 эмч, эмнэлгийн мэргэжилтэн, баг, сургуулийн нийгмийн ажилтан, цагдаагийн 141 ажилтныг мэдээлэл, зөвлөмжөөр хангасан.<br>- Томуу томуу төст өвчин алаг цоог дэгдэлтийн түвшинд хүрсэн тул нэмэлтээр 200-250 ор дэлгэж, гэрийн эргэлт, уртасгасан цагийн зохицуулалт хийж, өрх, хувийн хэвшлийн 48 эмч, эмнэлгийн мэргэжилтнийг нэмэлтээр ажиллуулсан.<br>- ЭМГ-ын дэргэдэх Магадлан хэлэлцэх зөвлөлөөс сургалт хэлэлцүүлэг 3 удаа зохион байгуулж, 21 багийн хүүхэд хамгааллын багийн гишүүдийг чадавхжуулсан.<br>- 16-49 насны эмэгтэйчүүдийн 62,1 хувь гэр бүл төлөвлөлтийн 5 төрлийн арга хэрэгсэлд хамрагдсан нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 4,5 хувиар нэмэгдсэн.<br>- Төрөлт 1901 бүртгэгдэж өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 10%-аар буурсан. Нялхсын эндэгдэл 1000 амьд төрөлтөд 4,3 промилл байгаа нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 8,3 промиллоор, 5 хүртэл насны хүүхдийн эндэгдлийн 10 тохиолдол бүртгэгдэж, 1000 амьд төрөлтөд 4.8 промилл байгаа нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 8.5 промиллоор тус тус буурсан байна. | |
| 35 | 3.2.5.2. Жирэмсний эрт үеийн хяналтын хамралтыг | | Эрт үеийн жирэмсний | 96,8 | 99,8 | Сум, өрхийн эрүүл мэндийн 8 төв нь эх баригчийг орон тоогоор дагнан ажиллуулж, жирэмсний нэрийн | 70 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | нэмэгдүүлэх, жирэмсний хяналтын чанарыг сайжруулан жирэмсэн үеийн ХДХВ, тэмбүү, гепатитын В, С, вирусийн илрүүлэг шинжилгээний хамрагдалт, тэмбүүтэй жирэмсэн эмэгтэйн эмчилгээ, эмчилгээний дараах хяналт, бэлгийн хавьтагчийн илрүүлэлт, оношилгоо, эмчилгээний байдалд байнга хяналт тавина. | | хяналтын хувь | | | хяналт, төрөх насны эмэгтэйчүүдийн шилжилт хөдөлгөөн, бүртгэлийг хянаж нэгтгэн, товлолын дагуу жирэмсний эхийг хяналтад бүрэн хамруулж, эрүүл мэндийн боловсрол олгох сургалтад давхардсан тоогоор 968 жирэмсэн эхийг хамруулсан нь нийт жирэмсэн эхийн 75,9%-ийг эзэлж байна.<br>Тайлант хугацаанд жирэмсний хяналтад шинээр 1422 жирэмсэн эмэгтэйчүүд хамрагдан эхний 3 сартайд 1368 буюу 96.2 хувь нь хяналтад орж, өмнөх оны мөн үеэс эрт үеийн хяналт 0.8 хувиар буурсан.<br>- Хяналтад орсон жирэмсэн эмэгтэйчүүдийн 100 хувь цусны шинжилгээнд хамрагдсанаас 20 буюу 1.4 хувь нь цус багадалттай байна.<br>- Хяналтад хамрагдсан жирэмсэн эмэгтэйг гепатитын В,С вирусийн илрүүлэг шинжилгээ, ХДХВ, тэмбүүгийн хурдавчилсан сорилд 100% хамруулж, тэмбүүгийн тест эерэг гарсан 38 жирэмсний оношийг баталгаажуулан, хавьтагчийн хамт эмчилгээнд 100% хамруулсан.<br>- Төрөлхийн тэмбүүгийн 1 тохиолдол бүртгэгдсэн.<br>- Шинээр хяналтад хамрагдсан жирэмсэн эмэгтэйчүүдээс трихомониаз 18 буюу 1.2 хувь нь эерэг, заг хүйтэн 7 буюу 0.5 хувь нь эерэг, тэмбүү 19 буюу 1.3 хувь нь эерэг гарсан байна. Сард дунджаар 140 эмэгтэй жирэмсний хяналтад ордог ба жирэмсний эрт үеийн хяналт 96.2%, 4-6 сартайд 3.6%, 7-оос дээш сартайд 2 тохиолдол буюу 0.2% эзэлж байна.<br>- Хяналтад байгаа нийт жирэмсний 828 буюу 79,2% анхан шатлалд, 224 буюу 20,8% нь жирэмсний өндөр эрсдэлтэй гэж үнэлэгдэн лавлагаа шатлалын эмнэлэгт хянагдсан.<br>Тайлант хугацаанд 1901 эх төрсөн нь өнгөрсөн оны мөн үеэс 228 төрөлтөөр буурсан байна. Төрсөн | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | эхчүүдийн 1106 нь буюу 58.2 хувь нь эмчийн хяналтын үзлэгт 6 ба түүнээс дээш удаа хамрагдсан байна. | |
| 36 | 3.2.5.3. Өрх, сумын эрүүл мэндийн төвд 18 сар, 36 сартай хүүхдийн эрүүл мэнд, хөгжлийн цогц үзлэгийг тогтмол зохион байгуулна. (ХНХ-ын сайд, БСШУС-ын сайд, Эрүүл мэндийн сайдын 2018 оны А/304, А/699, А/460 дугаар тушаал ) | | Хөгжлийн цогц үзлэгт хамрагдсан хүүхдийн хувь | 100% | 90-100% | Сум, өрхийн эрүүл мэндийн төв нь 5 хүртэл насны хүүхдийг MNS 5292:2017 стандартын дагуу идэвхтэй хянаж байгаа ба (ХНХ-ын сайд, БСШУС-ын сайд,Эрүүл мэндийн сайдын 2021 оны А/220, А/475, А/812 шинэчилсэн дугаар тушаалын дагуу 9 сартай 3194, 18 сартай 3826, 36 сартай 4469 хүүхдэд эрүүл мэндийн хөгжлийн үзлэгийг тухай бүр бүрэн хамруулж үнэлгээ хийж 15 хөгжлийн хоцрогдлыг эрт илрүүлсэн.<br>Тайлант хугацаанд тус үзлэгээр илэрсэн 87 хүүхдийн хөгжлийн бэрхшээлийн үнэлгээг БОЭТ-ийн хүүхэд, мэдрэл, сэргээн засахын эмчид үзүүлэн оношийг баталгаажуулсан. Аймгийн “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд боловсрол нийгмийн хамгааллын салбар комисс“ нь 403 хүүхдийн /сунгалт 316, шинээр 87/ асуудлыг шийдвэрлэж, боловсрол эрүүл мэндийн бусад үйлчилгээнд 32 хүүхдийг хамруулсан байна.<br>Аймгийн Засаг даргын А/124 захирамжийн хүрээнд Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сэргээн засах хөгжлийн төвийн дэмжлэгийн багтай хамтран хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн талаар төрөөс баримталж буй бодлого, Портеж эрт үеийн хөгжлийн дэмжлэг болон бусад холбогдох хөтөлбөрийн талаарх мэдээллийг авч 9,18,36 сартай хүүхдийн хоцрогдлыг үнэлж оношлох, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хөгжлийн дэмжлэг үзүүлэх сургалтад 57 эмч, мэргэжилтнийг хамруулж чадавхжуулсан. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй 93 эцэг эхэд хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэйгээ харилцах, хөгжлийн дэмжлэгийг үзүүлэх чиглэлээр мэдлэг, мэдээллийг олгосон. Сэргээн засах тусламж үйлчилгээ зайлшгүй авах шаардлагатай байгаа 85 хүүхдийг Хөгжлийн | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | бэрхшээлтэй хүүхдийн сэргээн засах хөгжлийн төв эмнэлэгт хэвтэн эмчлүүлэхээр холбон зуучилсан. Эмнэлэг хөдөлмөрийн магадлах өвчний хувь, хугацааны жагсаалт шинэчлэгдсэнтэй холбоотойгоор 2 удаагийн сургалтад Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссын төрөлжсөн мэргэжлийн эмч нарыг хамруулж, өрхийн эрүүл мэндийн төвөөс 2 сургагч багшийг бэлтгэсэн. Тайлант хугацаанд сум, өрхийн эрүүл мэндийн төвүүдийн 134 эмч, сувилагчийг бага насны хүүхдийн эрүүл мэнд, хөгжлийн цогц үзлэг хийх, бэрхшээлийг эрт илрүүлэх, арга зүйн дэмжлэг үзүүлэх сургалтад хамруулсан. | |
| 37 | 3.2.5.4. Хүүхдийг осол гэмтэл, хүчирхийллээс сэргийлэх чиглэлээр салбар дундын хамтын ажиллагааг өргөжүүлж, арга хэмжээний хэрэгжилтэд байнгын хяналт тавина. | | Осол гэмтэл, хүчирхийлэлд өртсөн тухайн насны хүүхдийн эзлэх хувь | 26,6 | 25 | Аймгийн Хүүхдийн эрхийг хамгаалах хороо, Хүүхдийн зөвлөл тус бүр 3 удаа хуралдан 2022 онд хийх ажлын төлөвлөгөөг батлуулан хэрэгжилтийг салбар дундын оролцоотой байгууллагуудтай хамтран 21 багийн хүүхэд хамгааллын багийн гишүүдийг хүүхдийг осол гэмтэл, хүчирхийллээс сэргийлэх чиглэлээр чадавхжуулах сургалтыг 5 удаа, дэмжлэгт хяналтыг 2 удаа, хэлэлцүүлэг 3 удаа, хүүхэд өсвөр үеийнхэнд чиглэсэн нөлөөллийн НҮЭМ, БЗДХ-аас сэргийлэх сургалтыг 6 удаа зохион байгуулж, давхардсан тоогоор 1145 хүнийг хамруулсан. Мөн бүх шатлалын эрүүл мэндийн байгууллагуудад хүчирхийлэлд өртсөн хохирогч хүүхдэд эмнэлгийн болон сэтгэл зүй, сэтгэл заслын үйлчилгээ үзүүлэх, мэдээлэх талаар чиглэл хүргүүлж, Цагдаагийн газарт аймгийн хэмжээнд ажиллаж байгаа хувийн хэвшлийн нөхөн үржихүйн клиникүүд, үр хөндөлтийн тусламж үйлчилгээ үзүүлдэг эрүүл мэндийн байгууллагуудын мэдээллийг хүргүүлж хүчирхийлэлд өртсөн 3 өсвөр насны охидын мэдээллийг солилцсон. Эрүүл мэндийн яам, НҮБ-ын ХАС-аас гэр бүлийн хүчирхийлэлд өртөгсдөд үзүүлэх эмнэлгийн тусламжийн чанар хүртээмж, мэдээллийн | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | урсгал, хариу арга хэмжээний чадавхын үнэлгээг БОЭТ, сум, өрхийн эрүүл мэндийн төвд хийж, судалгаанд нийт 51 эмч, эмнэлгийн мэргэжилтнийг хамруулсан байна. Тайлант хугацаанд осол гэмтэл, хүчирхийлэлд өртсөн 0-18 хүртэл насны 206 хүүхэд өртсөн нь 24,8%-ийг эзэлж өмнөх оны мөн үеэс 1,8%-аар, хүүхдийн осол гэмтлийн шалтгаант эндэгдлийн 7 тохиолдол бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 0,8%-аар тус тус буурсан байна. | |
| 38 | 3.2.5.5. Байгууллага, аж, ахуйн нэгжид хүүхэд саатуулах, өдөр өнжүүлэх бүлэг ажиллуулах, хүүхэд хөхүүлэх өрөө гаргах зэргээр эх, хүүхдэд ээлтэй орчин бүрдүүлэхэд дэмжлэг үзүүлнэ. | | Эх, хүүхдэд ээлтэй орчин бүрдүүлсэн байгууллагын хувь | 17,3% | 18% | Орхон аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж байгууллагуудаас Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ, Эрдэнэт хивсний үйлдвэр, худалдаа үйлчилгээний байгууллагууд, Эрүүл мэндийн салбарын ажилчдын 75-80% -ийг эмэгтэйчүүд эзэлж байна. Аймгийн Хүүхдийн зөвлөлтэй хамтран 2019 онд Засаг даргын А/24 дүгээр захирамжийн дагуу 42 байгууллагын дэргэд байгуулагдсан “Эцэг эхийн зөвлөл”-д эцэг эхийн зүгээс хүүхдэд тавих хараа хяналтыг сайжруулах, хүүхэд харах үйлчилгээг бий болгох, сэргийлж болох өвчлөл эндэгдлийг бууруулах, эх хүүхдэд ээлтэй орчин бүрдүүлэх чиглэл өгч ажилласны үр дүнд :<br>- Хүүхэд саатуулах өрөөг 11 төрийн болон аж ахуйн нэгж байгууллага тохижуулан эх хүүхдэд ээлтэй орчинг бүрдүүлсэн.<br>- Ресторан, хоолны газруудын 15%-д хүүхэд саатуулах тоглоомын булан байгуулж, хүүхдийн зориулалтын сандлаар хангагдсан.<br>- Банк, санхүүгийн байгууллагуудын 10%-д хүүхдийн ном унших, тоглох буланг тохижуулсан.<br>- Эрүүл мэндийн байгууллагуудын түвшинд Эрдэнэт Медикал эмнэлэг, Бүжинлхам, Элит baby эмнэлгүүд хүүхэд хөхүүлэх хэсгийг байгуулсан.<br>- Аймгийн Засаг даргын А/88 дугаар захирамжаар “Эх | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хүүхдэд ээлтэй өрхийн эрүүл мэндийн төв" шалгаруулах 3 сарын аяныг зохион байгуулж, хүүхэд хөхүүлэх, хуурайлах хэсгийг 7 өрхийн эрүүл мэндийн төв шинээр тохижуулан эх хүүхдэд нэг цэгээс тусламж үйлчилгээ үзүүлэх ээлтэй байдлыг хангасан анхан шатны байгууллага 75,0%-ийг эзэлж байна.<br>- Төрийн байгууллагуудын 45% нь сургууль, цэцэрлэгээс хүүхдээ авахад зориулж эцэг эхийн ажлын цагт уян хатан зохицуулалтыг хийсэн.<br>Эх, хүүхдэд ээлтэй орчин бүрдүүлсэн байгууллагын хувь 20,5 болж өнгөрсөн оноос 3,2 %-иар өссөн байна | |
| 39 | 3.2.5.6. Жирэмсэн эмэгтэйн амь насанд ноцтой хүндрэл гарч зайлшгүй тээвэрлэх шаардлага үүссэн тохиолдолд онгоц болон бусад тээврийн хэрэгслийн зардлыг Засаг даргын нөөц хөрөнгөөс гарган дэмжлэг үзүүлнэ. | | Дэмжлэг үзүүлсэн тоо | 2 | Тохиолдол бүрт | 2022 онд эхийн ноцтой хүндрэлийн 5 тохиолдол бүртгэгдсэн бөгөөд Бүсийн оношилгоо эмчилгээний төвд шаардлагатай тусламж үйлчилгээг багаар үзүүлж, эхийн амь нас аврагдсан тул Улаанбаатар хотын лавлагаа шатлалын эмнэлэгт тээвэрлээгүй байна. | - |
| 40 | 3.2.5.7. Эх, хүүхдийн эндэгдлийг бууруулах чиглэлээр аймгийн хэмжээнд хэрэгжүүлж байгаа үйл ажиллагааны талаарх тайлан, мэдээллийг аймгийн Засаг даргын зөвлөлийн хурлаар жилдээ нэгээс доошгүй удаа хэлэлцүүлж, тодорхой шийдвэр гаргана. | | Хэлэлцүүлсэн тоо | - | 1 | Аймгийн Засаг даргын зөвлөлийн хурлаар 1 удаа хэлэлцүүлж, эх, хүүхдийн эндэгдлийг бууруулах чиглэлээр гарсан шийдвэрийг хэрэгжүүлэх хүрээнд:<br>- Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэнд" арга хэмжээг 2021-2024 онд хэрэгжүүлэх төлөвлөгөөг батлуулан хэрэгжүүлж, хэрэгжилт 85,0 хувьтай байна.<br>- орон нутгийн төсвөөс 260,1 сая төгрөгийг шийдвэрлэснээс нярайн тусламж үйлчилгээнд дэвшилтэт технологи нэвтрүүлэхэд 58,5 сая, дутуу нярайн тусламж үйлчилгээнд шаардлагатай багаж тоног төхөөрөмж болох нярайн амьсгалын аппарат 2, шарлагын аппарат 10, инкубатор 4 ширхгийг хангаснаар 28-36 долоо хоногтой төрсөн дутуу нярайг амьдруулсан хувь 96,9-д хүрч, нялхсын | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | эндэгдэлд эзлэх нярайн эндэгдэл 66,6 хувь байгаа нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 17,2 хувиар буурсан үр дүнд хүрсэн.<br>- Аймгийн Засаг даргын 2022 оны А/88 дугаар захирамжаар 5,0 сая төгрөгийн төсөв бүхий “Эх хүүхдэд ээлтэй өрхийн эрүүл мэндийн төв” шалгаруулах 3 сарын болзолт уралдааныг анхан шатлалын эрүүл мэндийн байгууллагуудын дунд зохион байгуулснаас Мөнхсүндрэл, Үйлсбадрах, Мөнхийн гэгээ өрхийн эмнэлгүүд эхний байрыг эзэлсэн байна. Тус аяны хүрээнд эх хүүхдэд тусламж үйлчилгээ үзүүлэх багаж тоног төхөөрөмжийн хангалт 95,0%-д хүрч, сэргийлж болох эндэгдлийг бууруулах, осол гэмтлээс сэргийлэх эрүүл мэндийн боловсрол олгох сургалтад 0-5 насны хүүхэдтэй 456 эцэг эх, асран хамгаалагчдыг хамруулсан.<br>- Тав хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн 10 тохиолдол бүртгэгдэж, өмнөх оны мөн үеэс 21 тохиолдлоор буюу 8.5 промиллоор буурсан бөгөөд ялангуяа сэргийлж болох эндэгдэл өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 7тохиолдлоор буурсан үр дүнд хүрсэн.<br>- 2022 онд эх хүүхдийн эндэгдлийг бууруулах чиглэлээр аймгийн хэмжээнд хэрэгжүүлж байгаа үйл ажиллагааны талаарх тайлан мэдээллийг Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвийн Тандалт судалгааны албаны дэмжлэгт хяналтын багт танилцуулан хэлэлцүүлж, “Хангалттай сайн” үнэлгээ авсан.<br>- Эрүүл мэндийн яамны үнэлгээний баг Орхон аймгийн төрөх үеийн болон нөхөн үржихүйн тусламж үйлчилгээ, гэр бүл төлөвлөлт, жирэмсний хяналт, жирэмсэн үеийн тэмбүү өвчний илрүүлэлт, | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | салбар дундын уялдаа холбоо, мэдээллийн байдалд үнэлгээ хийж, “Хангалттай сайн” гэж дүгнэн холбогдох зөвлөмжийг өгсөн байна. | |
| 41 | 3.2.5.8. Эх, хүүхдийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чиглэлээр гарч байгаа тушаал, шийдвэрийг хэрэгжүүлж, хэрэгжилтэд байнгын хяналт тавьж ажиллана. | | Тушаал, шийдвэрийн хэрэгжилтийн хувь | 81% | 85% | Тушаал шийдвэрийн хэрэгжилт 90%-тай байна. Үүнд:<br>- Өрхийн гүйцэтгэлийн гэрээний хэрэгжилт, MNS 529252017 стандарт, ХӨЦМ-ийн хэрэгжилтэд 2 удаа үнэлгээ хийж, зөвлөмжөөр хангасан.<br>- Жирэмсний хяналт, эх хүүхдийн тусламж үйлчилгээний чанарыг сайжруулахаар салбаруудад мэдээлэл 5, зөвлөмж 3 удаа хүргүүлэн 5 удаагийн хяналт хийгдсэн.<br>- 2022 онд шинээр батлагдсан Эрүүл мэндийн сайдын 3 тушаалыг хяналтад авч, сурталчилж, хэрэгжилтэд хяналт тавин ажилласан.<br>- Амьсгал хямралын хам шинжтэй, дутуу төрсөн 15 нярайд сурфактант эмчилгээг хийж, 86,6 хувийн үр дүн өгсөн.<br>- Нярайн эрт үеийн нэн шаардлагатай тусламжийг төрсөн 1920 нярайд 100 хувь үзүүлсэн. Нярайн тандалт шинжилгээ скрининг хөтөлбөрийн хүрээнд түнхний үений ЭХО оношилгоонд 1920, ретинопатийн оношилгоонд 56 нярайг хамруулж, 2 нярайг лавлагаа шатлалд илгээсэн.<br>- Эрүүл мэндийн байгууллагуудын томуугийн тусламж үйлчилгээ, эмнэлзүйн удирдамжийн хэрэгжилт, бэлэн байдалд 3 удаа хамтарсан хяналт, салбар дундын зохицуулалтыг хийж, тусламж үйлчилгээний хүлээгдэл, амьсгалын замын халдварын шалтгаант өвчлөл, эндэгдлийг бууруулсан.<br>- Сум, өрхийн эрүүл мэндийн төвүүдийн 16-49 насны эмэгтэйчүүдийн шилжилт хөдөлгөөн, бүртгэл, жирэмсний хяналт, жирэмсний тэмбүүгийн тусламж үйлчилгээ, хурдавчилсан сорилын хангалт, хавьтагчийн илрүүлэлт, эмчилгээ, | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | дархлаажуулалтад сар бүр хяналт хийж, зөвлөмж өгч ажилласнаар хэрэгжилт 88,5% байна.<br>- Эх хүүхдийн эрүүл мэндийн чиглэлээр 12 удаагийн цахим хуралд давхардсан тоогоор эх барих, хүүхдийн мэргэжлийн 154 эмч, нярайн эрт үеийн нэн шаардлагатай тусламж, хүчирхийлэлд өртсөн охид, эмэгтэйчүүдэд үзүүлэх тусламж үйлчилгээг сайжруулах чиглэлээр бүсийн 2 удаагийн сургалтад давхардсан тоогоор 85 эмч, эмнэлгийн мэргэжилтэн хамрагдсан.<br>- Магадлан хэлэлцэх зөвлөл нь 3 удаа хуралдан 2022 онд бүртгэгдсэн амьгүй төрөлтийн 9, гэрийн төрөлтийн 4, нялхсын эндэгдлийн 6, 1-5 хүртэл насны хүүхдийн 1, эхийн ноцтой хүндрэлийн 5 тохиолдолд үзүүлсэн тусламж үйлчилгээг дүгнэн хэлэлцэж, сургамж, дүгнэлт, зөвлөмжийг эрүүл мэндийн байгууллагуудад хүргүүлсэн.<br>- ЭМЯ-ны үнэлгээний баг төрөх үеийн болон нөхөн үржихүйн тусламж үйлчилгээ, салбар дундын уялдаа холбоо, мэдээллийн байдалд үнэлгээ хийж, “Хангалттай сайн” гэж дүгнэсэн. | |
| 3.2.6. Аймгийн хүн амд үзүүлэх эмнэлгийн мэргэшсэн тусламж үйлчилгээний чиглэлээр | | | | | | | |
| 42 | 3.2.6.1. Эрүүл мэндийн салбарын шинэчлэлийн хүрээнд тусламж үйлчилгээний эмнэл зүйн олон улсын удирдамж “Up to Date” платформыг нэвтрүүлж бүх эмч нар ашиглах боломжийг хангана. | | “Up to Date” платформыг ашиглаж буй эмчийн хувь | 54% | 55% | Олон улсын эмнэлзүйн Uptodate цахим платформыг хэрэглэх сайжруулах хүрээнд зохион байгуулсан “Up to date программын хэрэглээг өргөжүүлэх нь” ажил мэргэжлийн уралдаанд эрүүл мэндийн салбарын 5 баг оролцсоноос тэргүүн байрыг Медипас эмнэлэг, дэд байрыг Бүсийн оношилгоо эмчилгээний төв, гутгаар байрыг хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагын багууд тус тус эзэлж, өргөмжлөл мөнгөн шагналаар шагнагдлаа. Орон нутгаас бэлтгэгдсэн 2 сургагч багш эмч нарыг цахим сургалтад үе шаттай хамруулж ажилласан. Нийт эмч нарын 62% нь тус платформд бүртгэл үүсгэж ашиглаж, өмнөх онтой | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | харьцуулахад 8%-аар нэмэгдсэн. | |
| 43 | 3.2.6.2.Харьяа нутаг дэвсгэрийн эрүүл мэндийн байгууллагын бүтэц, зохион байгуулалт, өмчийн харьяаллыг өөрчлөх, төрийн өмчит байгууллага шинээр байгуулах, хүчин чадлыг нэмэгдүүлэх тохиолдолд Захиалагч талтай харилцан зөвшилцсөний үндсэн дээр шийдвэрлэнэ. | | Шийдвэрийн тоо | 1 | Тухай бүр | Тайлант хугацаанд эрүүл мэндийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох комисс 5 удаа хуралдан тусгай зөвшөөрлийг шинээр 14 байгууллагад олгосон байна.<br>Монгол улсын Засгийн газрын 2022 оны 138 дугаар тогтоолоор "Эрдэнэт үйлдвэр" төрийн өмчит үйлдвэрийн газрын "Эрдэнэт медикал" төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг байгуулагдаж, эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг ЭМЯ-наас олгосон.<br>Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн харьяа Эрүүл мэндийг дэмжих төвд улс болон орон нутгаас нийт 2,0 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтыг хийснээс орон нутгаас их засварын ажилд 289,0 сая төгрөг, улсын төсвөөс их засварт 180,0 сая, багаж тоног төхөөрөмжид 1,5 тэрбум төгрөгийн үзлэг шинжилгээ болон оношилгооны 34 нэр төрлийн багаж тоног төхөөрөмжөөр хангагдан үйл ажиллагааг тогтмолжууллаа.<br>Түргэн тусламжийн төвийн 6 эмч, жолоочийн цалин, шатахуунд аймгийн Засаг даргын 2022 оны А/33 дугаар захирамжаар 285,0 сая төгрөгийг шийдвэрлүүлсэн. | 100 |
| 44 | 3.2.6.3. Эмнэлгийн яаралтай тусламж, үйлчилгээний чанарыг сайжруулж, тусламж, үйлчилгээг олон улсын стандартад нийцүүлэн хөгжүүлнэ. | | Амь тэнссэн үеийн тусламж үйлчилгээний чадавх | 90% | 90% | Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн Яаралтай тусламжийн хүлээн авах тасагт Жайка олон улсын хамтын ажиллагааны төслөөс 120 сая төгрөгийн 4D ЭХО аппарат, амилуулах өрөөнд суурин амьсгалын аппарат шинээр суурилуулсан. Ажиглах хяналтын хэсэгт телемедицины дэлгэцийг дагалдах тоног төхөөрөмжийн хамт байрлуулан лавлагаа шатлалын эмнэлгүүдтэй шууд холбогдож 30 иргэнд зөвлөгөө авсан. Шархны анхны цэгцлэлт хийх мэс заслын | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | өрөөнд туяагаар гар ариутгагч, оёдлын иж бүрдэл 3 ширхгээр хангаснаар эмнэлгийн тусламж үйлчилгээтэй холбоотой халдвар гарахаас сэргийлсэн. Яаралтай тусламжийн хүлээн авах тасгийн багаж тоног төхөөрөмжийн хангалт 85% болж өмнөх оны мөн үеэс 5%-аар нэмэгдэж, яаралтай тусламж үзүүлэх чадавх 90%-д хүрсэн. Тайлант хугацаанд Эрүүл мэндийн яамнаас түргэн тусламжийн тасгийг тоноглол бүхий 1 автомашинаар хангаснаар 13 түргэн тусламжийн машин дуудлагад үйлчилж ажилласан.<br>Өрхийн эрүүл мэндийн төвүүдэд яаралтай тусламж үзүүлэх нэгжийг шинээр байгуулж амилуулах суурь тусламжийг үзүүлэх багийг томилон гардан үйлдлийн сургалтыг Бүсийн оношилгоо эмчилгээний төвтэй хамтран 2 удаа зохион байгуулж чадавхжуулсан. Тус нэгжүүдэд хяналтын монитор 8, хүчилтөрөгч өтгөрүүлэгч 10, отсос 8, дефибрилятор 5 ширхгийг байрлуулсан ба хүчилтөрөгчийн гуурс нэг сарын нөөцтэй, амин чухал эм, тариа 1-2 сарын нөөцтэй байна. Үйлсбадрах өрхийн эрүүл мэндийн төв, Бүсийн оношилгоо эмчилгээний төвд Жаргалант сумын эрүүл мэндийн төвд төрөх болон яаралтай тусламжийн иж бүрдлийн цүнхээр хангагдсан. Сум, өрхийн эрүүл мэндийн төвүүдийн яаралтай тусламжийн тоног төхөөрөмжийн хангалт 95%, гардан үйлдлийн чадавх 89%-тай байна. Баян-Өндөр мед нэгдсэн эмнэлэгт эрчимт эмчилгээний тасгийг нээн ажиллуулж багаж тоног төхөөрөмжөөр 100% хангасан. Хувийн хэвшлийн ортой эмнэлгүүдийн яаралтай тусламжийн нэгжийн багаж тоног төхөөрөмжийн хангалт 85%, гардан үзүүлэх чадавх 82%-тай байна. Тайлант хугацаанд 75 эмч, эмнэлгийн мэргэжилтэн, 500 гаруй сурагч, 60 гаруй сургууль цэцэрлэгийн багш ажилтныг амилуулах | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | суурь тусламжийн сургалтад хамруулсан. Монголын яаралтай тусламжийн нийгэмлэгтэй хамтран “Яаралтай тусламжийн үеийн үнэлгээ болон авах арга хэмжээ” сургалтыг зохион байгуулж 150 эмч, эмнэлгийн мэргэжилтэн хамрагдсан.<br>Амь тэнссэн үеийн тусламж үйлчилгээний чадавх 95% байна. | |
| 45 | 3.2.6.4. Уламжлалт анагаах ухааны төв, нэгдсэн эмнэлгийн тусламж үйлчилгээг өргөжүүлэх зорилгоор аймаг нийслэлийн хөгжлийн бодлогод үйл ажиллагаа болон хүний нөөцийг дэмжихэд чиглэсэн арга хамжээ, төсөв хөрөнгийг тусгаж хэрэгжилтэд анхаарна. | | Үйл ажиллагааны тайлан, хэрэгжилтийн хувь | 80% | 81% | Тайлант хугацаанд уламжлалт эмчилгээний 7 төрлийн 20 зөөлөн болон ширүүн засал, 30 гаруй нэр төрлийн танг эмчилгээндээ ашиглаж, 6854 хүнд амбулаторийн үзлэг хийж өдрийн эмчилгээнд хамруулсан ба 3456 үйлчлүүлэгчийг хэвтүүлэн эмчилж, тусламж үйлчилгээ үзүүлсэн байна. Нийт 7413 иргэнийг сэргээн засах тусламж үйлчилгээнд хамруулсан байна.<br>Мажаа клиник Diers formetric тоног төхөөрөмжийг авч оношилгоо, эмчилгээнд шинэ технологи болох нэвтрүүлсэн. Мөнхийн Үйлс клиник 36 сая төгрөгийн дотоод засвар хийж, тоног төхөөрөмжийг шинэчлэн, шинээр сэргээн засах тоног төхөөрөмжүүдээр хангагдсан.<br>Эрүүл мэндийн сайдын А/738 дугаар тушаалын дагуу Коронавируст халдвараас уламжлалт аргаар урьдчилан сэргийлэх болон халдварын дараах нөхөн сэргээх эмчилгээний мэдээлэл, сургалт сурталчилгааг цахимаар иргэдэд тогтмол хүргэсэн.<br>Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн сэргээн засах кабинетаар 536 иргэн урт болон богино хугацааны сэргээн засах тусламж үйлчилгээг авсан байна.<br>Тайлант хугацаанд уламжлалт анагаах ухааны нэр төрөл өмнөх оны мөн үетэй харьцуулахад 1.3%-аар өссөн үзүүлэлттэй байна. Үйл ажиллагааны хэрэгжилт 90%-тай байна.<br>Хүний нөөцийг дэмжих чиглэлээр:<br>- Аймгийн хэмжээнд уламжлалт анагаах ухааны | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хүний их эмч 39, уламжлалтын бага эмч 18, уламжлалтын сувилагч 15, сэргээн засахын их эмч 6, хөдөлгөөн засалч 3, хөдөлмөр засалч 1, бариа заслын сувилагч 9 ажиллаж, уламжлалт анагаах ухааны хүний нөөцийн хангалт 75 хувьтай болж 3%-аар нэмэгдсэн.<br>- Тайлант хугацаанд зүүний мэргэжил дээшлүүлэх сургалтад 2 эмч, дотор судлалаар 1 эмч хамрагдсан. Нийт эмч нараас зүү, төөнө заслаар 9, дотор судлалаар 5 эмч үндсэн мэргэжил эзэмшсэн байна.<br>- Уламжлалт анагаах ухааны тусламж үйлчилгээний чиг хандлага, өнөөгийн байдал, тулгамдсан асуудлаар зөвлөлдөх уулзалтыг зохион байгуулж үйл ажиллагаа явуулж буй 25 эрүүл мэндийн байгууллагын их эмч, эмнэлгийн тусгай мэргэжилтэн 55 хүнийг хамруулан, уулзалтаас 12 зөвлөмжийг гарган салбаруудад хүргүүллээ.<br>- “ЭБИС” сэргээн засах клиник, Эрдэнэт сувилал нь сэргээн засах тусламж үйлчилгээг сурталчлах, туршлага судлах ажлыг зохион байгуулж сэргээн засахын бага эмч, сувилагч нарыг хамруулан чадавхжуулсан.<br>Үйл ажиллагааны хэрэгжилт 85%-тай байна. | |
| 46 | 3.2.6.5. Эрүүл мэндийн байгууллага бүрт Халдварын сэргийлэлт хяналтын баг, Чанар, аюулгүй байдлын албаны үйл ажиллагааг тогтмолжуулан хяналт тавьж ажиллана. | | Халдварын сэргийлэлт хяналтын төлөвлөгөөний хэрэгжилт<br><br>Чанар, аюулгүй байдлыг сайжруулах төлөвлөгөөний | 90%<br><br>90% | 90%<br><br>90% | Халдварын сэргийлэлт хяналтын салбар зөвлөлийн 2022 оны 13 заалт бүхий төлөвлөгөөг батлан хэрэгжүүлэн ажилласан. Мэргэжлийн хяналтын газартай гэрээ байгуулж, эрсдэл өндөр 34 байгууллагад эрүүл зүйн шинжилгээ хийлгэхэд эмгэг төрөгч илрээгүй. Эрүүл мэндийн байгууллагуудад хуваарийн дагуу дэмжлэгт хяналтыг 2 удаа хийж, зөвлөмж өгч ажилласан.<br>“Эмнэлгийн тусламж үйлчилгээтэй холбоотой халдвараас сэргийлье” сарын аяны хүрээнд эрүүл | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | хэрэгжилт | | | мэндийн ажилтны мэдлэгийг сорих тэмцээнийг 2 үе шаттай зохион байгуулж, 52 багийн 260 хүн хамрагдсанаас 2 өрхийн эрүүл мэндийн төв тэргүүлж, аяны хүрээнд зохион байгуулсан ажлын үнэлгээгээр 1 өрхийн эрүүл мэндийн төв шалгарсан. Халдварын сэргийлэлт хяналтын төлөвлөгөөний хэрэгжилт 90,7%-тай байна.<br>Сум, өрхийн эрүүл мэндийн төвүүд, хувийн хэвшлийн ортой 13 клиникт чанарын баг, Бүсийн оношилгоо эмчилгээний төв, Эрдэнэт Медикал төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, Баян-Өндөр мед нэгдсэн эмнэлэг, Эрдэнэт сувилалд орон тооны бус чанарын алба ажилласан. 2022 оныг “Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар аюулгүй байдлыг сайжруулах жил” болгон зарласантай холбоотой ЭМГ-ын даргын тушаалаар “Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар аюулгүй сайжруулах 2022-2025 оны төлөвлөгөө”-г батлан хэрэгжүүлсэн. Эрүүл мэндийн хөгжлийн төвтэй хамтран чанарын алба, багийн дарга 50 хүн, Эрүүл мэндийн газраас эрүүл мэндийн байгууллагын удирдлагууд болон чанарын алба, багийн дарга нарыг чадавхжуулах сургалтад 40 хүнийг хамруулсан. Эмчилгээний хоолны чанарыг сайруулах, уламжлалт анагаах ухаан, сэргээн засах тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх 2 зөвлөгөөн зохион байгуулж 160 эрүүл мэндийн байгууллагын удирдлагууд, эмч, эмнэлгийн мэргэжилтнийг хамруулсан. Магадлан итгэмжлэл сунгуулах 6 байгууллага, шинээр орох 3 байгууллагын чанарын багийн үйл ажиллагаанд хяналт хийж мэргэжил арга зүйн ханган ажилласан. Эрүүл мэндийн 6 байгууллагад хөндлөнгийн явцын хяналт, 12 байгууллагад эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар аюулгүй байдлыг сайжруулах төлөвлөгөөний | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хэрэгжилт 95%-тай байна. | |
| 47 | 3.2.6.6. Иргэдийн дунд сайн дурын авлагагүй донорын эгнээг өргөжүүлж аюулгүй цус, цусан бүтээгдэхүүний бэлдмэлийн хангамжийг нэмэгдүүлнэ | | Цус, цусан бүтээгдэхүүний бэлдмэлийн хангамжийн хувь | 96% | 96%-аас буурууулахгүй байх | Тайлант хугацаанд бүртгэлтэй 607, үүнээс байнгын донор 341, шинэ донор 266, хүндэт донор 78, цусаа бэлэглэж буй 10 донор байна. Аймгийн Засаг даргын 2022 оны А/172 дугаар захирамжаар 5,0 сая төгрөгийг шийдвэрлэж, “Дусал цусаар амьдрал бэлэглэе” уриан дор сайн дурын авлагагүй донорын эгнээг өргөжүүлэх, цусны аюулгүй байдлыг хангах, донор хадгалах идэвх санаачилгыг өрнүүлэх аяныг зохион байгуулж цусны донорын талаарх үнэн зөв мэдээллээр хангах, донор элсүүлэх чиглэлээр 6 байгууллагын 106 хүнийг сургалтад хамрууллаа. Суурин цус цуглуулалтаар 526 донороос 571 нэгж цус, сийвэнгийн 36 донороос 108 нэгж сийвэн тус тус цуглуулсан. Цусны салбар төвд бүртгэлтэй 607 донорт цусны АВО, Резус бүлэг, Келл бүлэг, цус, цусан бүтээгдэхүүнээр дамжих халдвар илрүүлэх шинжилгээг хийж 100% баталгаажуулсан. Тайлант хугацаанд цус цусан бүтээгдэхүүний үйлдвэрлэл 17.2%-аар, шинжилгээний хасагдалт өмнөх онтой харьцуулбал 1,5%-аар буурсан. Цус цусан бүтээгдэхүүний хангалт 100%-тай байна. | 100 |
| 48 | 3.2.6.7. Эрүүл мэндийн даатгалын хамралтыг нэмэгдүүлэх ялангуяа ядуу, эмзэг бүлгийн иргэдийг бүрэн хамруулах, энэ чиглэлээр орон нутгийн удирдлага, иргэдтэй хамтран ажиллах, эрүүл мэндийн даатгалын талаар мэдээлэл, сурталчилгааг тогтмол хийж, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг шуурхай авах нөхцөлийг бүрдүүлж | | Эрүүл мэндийн даатгалд хамрагдсан хувь | 94.2% | 96.2 | Эрүүл мэндийн даатгалд даатгуулагчийн хамрагдалтыг нэмэгдүүлэхээр Эрүүл мэндийн даатгалын хэлтэстэй хамтран эрүүл мэндийн салбаруудын шуурхайд 1 удаа мэдээлэл, эрүүл мэндийн байгууллагуудын 35 удирдлага, эмч нарыг хамруулсан сургалтыг 1 удаа хийж, нээлттэй хаалганы өдөрлөгөөр урьдчилан сэргийлэх эрт илрүүлэг шинжилгээ хийлгэхэд эрүүл мэндийн даатгалд хамрагдсан байхыг сурталчилж, иргэдийг эрүүл мэндийн даатгалд хамруулах ажил хийгдсэн. Мөн ЭМДЕГ-ын 01, 05, 06 дугаар тогтоолуудыг иргэдэд сурталчлан ажилласан. 2022 оны байдлаар албан журмын даатгалд 28820, сайн дурын даатгалд 3210 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | ажиллана. | | | | | иргэн эрүүл мэндийн даатгалд хамрагдаж, төрөөс 70782 иргэний даатгалыг төлж эрүүл мэндийн даатгалд хамрагдсан иргэний тоо 102818 буюу эрүүл мэндийн даатгалд хамрагдалт 96.8%-д хүрсэн байна. | |
| 49 | 3.2.6.8 Эм, эмнэлгийн хэрэгслийн нөөцийн байдалд тогтмол хяналт тавьж нөөцийн талаарх мэдээллийг сар бүр, шаардлагатай тохиолдолд тухай бүр Засаг даргын хурлаар хэлэлцэж, шаардлагатай хариу арга хэмжээг шуурхай авна | | Эм, эмнэлгийн хэрэгслийн нөөцийн хувь 80% | 75% | 80% | Коронавируст халдвар /ковид-19/ цар тахлын үед ЭМЯ болон Орхон аймгийн Засаг даргын тамгын газар, Орхон аймгийн Онцгой байдлын газар болон өөрийн хөрөнгөөр цар тахалтай тэмцэх, хүндрэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор Эрүүл мэндийн байгууллагууд 5 нэр төрлийн 44 нэрийн эм, 6 нэрийн эмнэлгийн хэрэгсэл, 15 нэрийн хувийн хамгаалах хэрэгсэл, 4 нэрийн ариутгалын бодисыг бэлтгэн бэлэн байдлыг хангаж ажилласан. Тайлант хугацаанд дунджаар 42 хоногийн нөөцтэй байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 21 /50,25%/ хоногийн нөөцөөр илүү байна. Үүнд:<br>- Вирусийн болон нянгийн эм, тарилгын шингэнүүд, халуун бууруулах, өвдөлт намдаах, амилуулах суурь тусламжийн эмийн нөөц 21 хоног<br>- Хувийн хамгаалах хэрэгслийн нөөц 2-3 сар<br>- Эмнэлгийн хэрэгслийн нөөц 14-21 хоногийн нөөцөөр тус тус нэмэгдсэн байна.<br>Онцгой байдлын ерөнхий газарт долоо хоног бүр, ЭМХТ-д өдөр тутам эм, эмнэлгийн хэрэгслийн нөөцийн мэдээг явуулж ажилласан ба тайлант хугацаанд 32 удаа мэдээ тайланг хүргүүлсэн.<br>Эрүүл мэндийн байгууллагуудын нөөц бүрдүүлэлт дунджаар 89,6%-тай байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 5%-аар нэмэгдсэн. Тухайлбал: Эрүүл мэндийн газарт 94%, Бүсийн оношилгоо эмчилгээний төвд 96,5%, сум, өрхийн эрүүл мэндийн төвүүдэд дунджаар 82,5%, эм ханган нийлүүлэх байгууллагын нөөцийн хувь 85,4%-тай байна. | 100 |
| 50 | 3.2.6.9. Эм, эмнэлгийн | | Худалдан авах | 100% | 100% | Тайлант хугацаанд Бүсийн оношилгоо эмчилгээний | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | хэрэгслийн хэрэгцээг оновчтой тооцон худалдан авах ажиллагааны үр ашгийг нэмэгдүүлэх, ерөнхий гэрээгээр худалдан авч байгаа эм, эмнэлгийн хэрэгслийг өөр эх сурвалжаас авахгүй байх арга хэмжээ хэрэгжүүлнэ. | | ажиллагаа зохион байгуулсан, ерөнхий гэрээнд заасан эм, эмнэлгийн хэрэгсэл худалдан авалтын хувь | | | төвд төрийн болон орон нутгийн өмч хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу 45 багцад 3,0 тэрбум төгрөгийн нээлттэй тендер зохион байгуулж, үүний дагуу 24 компанитай гэрээ байгуулан 100% тендерээр авч ажилласан. Мөн ерөнхий гэрээгээр худалдан авах 71 нэрийн эм, 3 нэрийн эмнэлгийн хэрэгслийг 12 компанитай 400 сая төгрөгийн жилийн гэрээ байгуулснаас 10 компаниас 375/93,75%/ сая төгрөгийн эм, эмнэлгийн хэрэгсэл худалдан авч, тусламж үйлчилгээг үзүүлсэн. | |
| 51 | 3.2.6.10. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд үзүүлэх тусламж, үйлчилгээг өргөжүүлэх зорилгоор эрүүл мэнд, боловсрол, нийгмийн халамжийн салбар комиссын үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллана | | Комиссын шийдвэрийн хэрэгжилтийн хувь | 100% | 100% | Орхон аймгийн хэмжээнд хөгжлийн бэрхшээлтэй нийт 4216 хүн, 412 хүүхэд байна. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн мэдээллийн санг бүрдүүлж, бусдын адил эрхээ эдлэх, нийгэм дэх оролцоог нэмэгдүүлж, тэдний боловсрол, эрүүл мэнд, нийгмийн хамгааллын үйлчилгээг сайжруулах зорилгоор аймгийн Засаг даргын 2017 оны А/156 тоот захирамжийн дагуу "Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комисс" байгуулагдан үйл ажиллагаа нь тогтмолжиж тайлант хугацаанд 403 хүүхдийн /сунгалт 316, шинээр 87/ асуудлыг шийдвэрлэж, боловсрол эрүүл мэндийн бусад үйлчилгээнд 32 хүүхдийг хамруулсан байна.<br>Аймгийн Засаг даргын 2022 оны А/124 дүгээр захирамжаар Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн сэргээн засах төвүүдийн үйл ажиллагааг дэмжиж 183 сая төгрөг, хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдтэй асран хамгаалагчдыг эрүүл мэнд, нийгмийн даатгалын сайн дурын даатгалд хамруулах зардалд 55,0 сая төгрөг шийдвэрлэсэн байна. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, залуусыг сэргээн засах, хөгжүүлэх чиглэлээр аймгийн Засаг даргатай Найдвар төв, Пондолой аутизмын төв, Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн эцэг эхчүүдийн холбоо | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хамтран ажиллах гэрээ байгуулан ажиллаж байна. Хөгжлийн бэрхшээлтэй иргэд үйлчлүүлэх нөхцөлийг сайжруулах зорилгоор Эрүүл мэндийг дэмжих төвийн байранд Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссын үйл ажиллагааг шилжүүлж 7 хоног бүрийн Пүрэв гаригт үйл ажиллагааг явуулж хэвшсэн. Комиссын шийдвэрийн хэрэгжилт 100% байна. | |
| 52 | 3.2.6.11. Хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагатай төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ байгуулж эмнэлгийн ачаалал хуваалцах, эмчилгээ оношилгооны дутууг нөхөн тусламж, үйлчилгээний тасралтгүй, шуурхай хүртээмжтэй байдлыг ханган үр дүнг тооцон ажиллана. | | Гэрээний хэрэгжилтийн хувь | 90% | 92% | Хувийн хэвшлийн Баян-Өндөр мед нэгдсэн эмнэлэг болон ор бүхий 11 клиниктэй аймгийн Засаг дарга, Эрүүл мэндийн газартай гурвалсан гэрээ байгуулан гэрээний хэрэгжилтэд хяналт тавьж хагас бүтэн жилээр үнэлэхэд дунджаар 85-98%, дунджаар 93% үнэлэгдсэн.<br>Тайлант хугацаанд хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагууд 92157 үзлэг хийсэн нь аймгийн хэмжээнд хийгдсэн нийт үзлэгийн 16.7%-ийг, 16322 иргэнийг хэвтүүлэн эмчилсэн нь нийт эмнэлэгт хэвтэн эмчлүүлэгчийн 50,9%-ийг эзэлж Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн ачааллыг хуваалцсан байна.<br>Тайлант хугацаанд хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагууд оношилгооны чадавхыг сайжруулж 85% байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 15%-аар нэмэгдсэн байна.<br>- Талын булаг, Тайхар эмнэлгүүд зөөврийн дижитал рентген суурилуулсан.<br>- Баян-Өндөр мед нэгдсэн эмнэлэгт Япон улсын Сисмекс корпорацийн цусны анализатор суурилуулсан. Хүүхдийн нүдний харааг ретиноскопи, биомикроскопоор шинжлэх, дуран, чих хамар хоолойн иж бүрэн үзлэгийн кабинеттай болсон.<br>- “Очир-Увидас” клиник эмнэлгийн байр, хүчин чадлыг нэмэгдүүлж сэргээн засах, дотрын тусламж үйлчилгээ, амбулаторийн үйл ажиллагааг өргөжүүлэн, хөдөлгөөн засалчийг орон тоогоор | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | ажиллуулан 258 иргэнд тусламж үйлчилгээг үзүүлсэн.<br>- “Нейрон” клиникт 24 цагийн нойрны бичлэг, уналт таталтыг тогтоох бичлэгийг бүс нутгийн хэмжээнд үзүүлэн ажилласан.<br>- “Бадархундага” клиникт 100 гаруй үзүүлэлт үздэг биохимийн анализатор, уушгины багтаамж үздэг спирометрийн аппарат, 3D ЭХО аппаратаар хангаж оношилгооны чадавхыг өмнөх оноос 1.5 хувиар нэмэгдүүлж 88.5% болсон байна. | |
| 53 | 3.2.6.12.Эмнэлгийн тусламж үйлчилгээний чиглэлээр гарч байгаа тушаал, шийдвэрийг хэрэгжүүлж, хэрэгжилтэд байнгын хяналт тавьж ажиллана | | Тушаал шийдвэрийн хэрэгжилтийн хувь | 95% | 95-100% | Тайлант хугацаанд Эрүүл мэндийн сайдын эмнэлгийн тусламж үйлчилгээтэй холбоотой 30 тушаалыг хяналтад авч хэрэгжүүлэн ажилласан. Тухайлбал:<br>- Коронавируст халдвар (КОВИД-19)-ын чиглэлээр оношилгоо эмчилгээ, халдвар сэргийлэлт, эмнэл зүйн зөвлөх баг, эм, эмнэлгийн хэрэгсэл хуваарилсан тушаалуудыг 100% хэрэгжүүлэн ажилласан.<br>- ЭМС-ын А/33 “Шинэ коронавируст халдвар (КОВИД-19)-ын оношилгоо, эмчилгээний түр заавар шинэчлэн батлах тухай” тушаалын дагуу нийт 120 эмч, эмнэлгийн мэргэжилтэнд 2 удаагийн сургалтыг ЭМЯ, ХӨСҮТ-тэй хамтран зохион байгуулсан.<br>- ЭМГ-ын даргын “Коронавируст халдвар Омикрон хувилбарын 4 дэх давлагааны үеийн эмнэлгийн тусламж үйлчилгээний бэлэн байдлыг хангах тухай” А/02 тушаалыг гарган хэрэгжүүлсэн.<br>- ЭМС-ын А/165 “Коронавируст халдвар (КОВИД-19)-тай иргэнд тусламж үзүүлэх түр орыг татан буулгах тухай” тушаалаар нийт хувийн хэвшлийн 5 эмнэлгийг татан буулгасан.<br>- “Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар аюулгүй байдлыг сайжруулах жил” болгон зарласантай холбоотой ЭМГ-ын даргын 2022 оны | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | А/39 дүгээр тушаалаар эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар аюулгүй сайжруулах 2022-2025 оны төлөвлөгөөг батлан 95%-тай хэрэгжүүлсэн.<br>- Тайлант хугацаанд төлөвлөсөн 11 байгууллагыг 100% магадлан итгэмжлэлд хамруулж, магадлан итгэмжлэлийг 2-4 жилээр сунгуулсан. Үүнээс шинээр 3 байгууллагыг магадлан итгэмжлэлд оруулж батламжлуулсан. 26 эрүүл мэндийн байгууллагын хөгжлийн хөтөлбөрийн хэрэгжилт 93.5%-тай үнэлэгдсэн.<br>Тусламж үйлчилгээтэй холбоотой гарсан тушаалыг дунджаар 95%-100% хэрэгжүүлэн ажилласан. | |
| 3.2.7. Эрүүл мэндийн мэдээлэл технологи, цахим шилжилтийн чиглэлээр | | | | | | | |
| 54 | 3.2.7.1. Эрүүл мэндийн байгууллагад мэдээлэл, технологийн техник хангамж, сүлжээ, программ хангамжийн дэд бүтцийг өргөжүүлэн хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлж тасралтгүй байдлыг хангана. | | Шилэн кабельд холбогдсон эрүүл мэндийн байгууллагын тоо | 10 | 12 | Аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа эрүүл мэндийн 168 байгууллага интернетийн сүлжээнд 100% холбогдсоноос 13 эрүүл мэндийн байгууллага Юнивишн, Мобинет ХХК-ийн dedicated 20mb хурдтай өндөр хурдны шилэн кабелийн интернетийн сүлжээнд холбогдсон.<br>ХӨСҮТ, Жайка олон улсын байгууллагын санхүүжилтээр дархлаажуулалтын бүртгэл хийхэд ашиглах 9 зөөврийн компьютерыг сум, өрхийн мэндийн төвүүдэд хүлээлгэн өгсөн. Аймгийн Засаг даргын тамгын газраас хэрэгжүүлж буй “Цахим Эрдэнэт-1” хөтөлбөрийн хүрээнд аймгийн Бүсийн оношилгоо эмчилгээний төв, өрхийн эрүүл мэндийн төвүүдийг 20 ширхэг таблетаар хангаснаар түргэн тусламжийн дуудлага болон өрхийн гэрийн эргэлтээр тусламж үйлчилгээ үзүүлсэн эмч тухайн иргэний өвчний түүхийн мэдээллийг цахим системээс харах, үзлэгийн бүртгэл шивэлт хийх, хөнгөлөлттэй эмийн жорыг тухай бүрт нь бичиж хүлээгдэл, чирэгдлийг бууруулсан бөгөөд сум өрхийн эрүүл мэндийн төвүүдийн компьютерын хангалт 95%-д хүрсэн. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Өрхийн эрүүл мэндийн төвүүдэд Юнивишн, Мобинет ХХК-ийн dedicated 20mb хурдтай өндөр хурдны шилэн кабелийн интернетийн сүлжээнд холбогдож 100% интернэт сүлжээний дэд бүтцийг сайжруулсан. 2022 онд Мөнхийн гэгээ өрхийн эрүүл мэндийн төв Мобинет ХХК-ийн шилэн кабелийн өндөр хурдны интернэтийн сүлжээнд шинээр холбогдсоноор өрхийн эрүүл мэндийн төвүүд 100% өндөр хурдны шилэн кабелийн интернетийн сүлжээ ашиглаж, сүлжээний дэд бүтцийг сайжруулсан. | |
| 55 | 3.2.7.2. Эрүүл мэндийн яамны Цахим эрүүл мэндийн удирдах хороо, техникийн ажлын хэсгийн дүгнэлт, шийдвэрээр албан ёсны програм хангамж, цахим системийг эрүүл мэндийн байгууллагад ашиглуулна. | | Албан ёсны програм хангамж, цахим систем ашиглалтын хувь | 100 | 100 | БОЭТ, сум, өрхийн эрүүл мэндийн төвүүд, хувийн хэвшлийн ортой эмнэлгүүд, эрүүл мэндийн тусламж үйлчилгээний цахим бүртгэлийн албан ёсны E-Health, E-Clinic, Hinfo, дархлаажуулалт, хөнгөлөлттэй эмийн жор бичих health.gov.mn, шинжилгээний бүртгэлийн eruul.gov.mn болон вакцины гэрчилгээ, шинжилгээний хариу авах, БОЭТ-д үзлэгийн цаг захиалахад E-Mongolia.mn системүүдийг тус тус ашиглаж ажилласан.<br>Тайлант хугацаанд анхан шатны эрүүл мэндийн байгууллагуудад цахим эрүүл мэндийн e-hospital.mn системийг шинээр нэвтрүүлж амбулаторийн болон урьдчилан сэргийлэх эрт илрүүлэг үзлэг, эмнэлгийн хуудсыг цахимаар олгох, өдрийн эмчилгээ, оношилгоо шинжилгээ, сэргээн засах, гэрийн эмчилгээний бүртгэлийг хийж, программ хангамжийн дэд бүтцийг сайжруулсан. Сум, өрхийн эрүүл мэндийн төвүүд, хувийн хэвшлийн 12 ортой эмнэлэг e-hospital.mn програмыг ашиглалт 100% байна.<br>Аймгийн Бүсийн оношилгоо эмчилгээний төв нь цахим эрүүл мэндийн e-health программыг хөгжүүлэгч Метаксплас ХХК-тай албан ёсоор гэрээ байгуулан сар бүр төлбөрийг төлж программын ашиглалт хөгжүүлэлтийг тасралтгүй хийж, үзлэгийн бүртгэл | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | маягтуудын өөрчлөлтүүдийг тухай бүрт системд оруулан эрүүл мэндийн даатгалын системтэй бодит цагийн /realtime/ горимд холбогдон, нэхэмжлэл үүсгэж, гүйцэтгэлээр санхүүжилтээ авч ажилласан. | |
| 56 | 3.2.7.3. Эрүүл мэндийн байгууллагуудад цахим мэдээллийн нууцлал, аюулгүй байдлын холбогдох стандарт, журмыг мөрдүүлнэ. | | Стандарт журмын хэрэгжилтийн хувь | 0 | 80% | Бүсийн оношилгоо, эмчилгээний төв, Эрүүл мэндийн газрын албан ажлын хэрэгцээнд төрийн байгууллагын цахим шуудангийн үйлчилгээг эрүүл мэндийн цахим мэдээллийн нууцлал аюулгүй байдлыг ханган Үндэсний дата төвийн төв серверт байршуулан ашигласан. Бүсийн оношилгоо эмчилгээний төвд орон нутгийн төсвийн 200,0 сая төгрөгийн санхүүжилтээр 39 тоног төхөөрөмж нийлүүлэгдэн, амбулатори, тасаг, нэгжийн үйлчилгээнд цахим бүртгэл, мэдээлэл, хяналтын орчин нөхцөлийг бүрдүүлж, иргэдэд хүргэх эрүүл мэндийн тусламж үйлчилгээний менежментийг сайжруулах, шуурхай, ил тод нээлттэй байдлыг хангах, тусламж үйлчилгээний чирэгдлийг бууруулах зорилгоор "Цахим эрүүл мэнд" төслийг хэрэгжүүлсэн. Төсөл хэрэгжүүлснээр БОЭТ-д шаардлагатай сүлжээ, мэдээллийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр иж бүрэн Firewall сервер, сүлжээний төхөөрөмжүүд, IP камер, windows surface tablet зэрэг тоног төхөөрөмжүүдийг худалдан авч суурилуулан ашиглаж байна. Мэдээллийн нууцлал аюулгүй байдлын стандарт журмын хэрэгжилт 70% байна. | 87,5 |
| 57 | 3.2.7.4. Эрүүл мэндийн байгууллагын тусламж үйлчилгээний мэдээ, мэдээлэл, эмчийн үзлэг, өвчний түүхийг цахим хэлбэрээр цуглуулах, боловсруулах, дамжуулахтай холбоотой цахим соёлыг төлөвшүүлнэ. | | Эрүүл мэндийн байгууллагын тусламж үйлчилгээний мэдээ, мэдээлэл, эмчийн үзлэг, өвчний түүхийг цахимжуулсан | - | 100% | Бүсийн оношилгоо эмчилгээний төв, Эрдэнэт медикал төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, Баян-Өндөр мед нэгдсэн эмнэлэг болон хувийн хэвшлийн ортой 12 клиник нь хэвтэн эмчлүүлэгчдийн өвчний түүхийг цахим программд шивж, мэдээллийг бүрэн цахимаар боловсруулан ажилласан. | 70 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | хувь | | | | |
| 58 | 3.2.7.5. Эрүүл мэндийн байгууллагын тусламж үйлчилгээний үр дүнг иргэдэд бодит цаг хугацаанд шуурхай, хялбар олгоход чиглэлийн арга хэмжээг авч хэрэгжүүлнэ. | | Иргэд хүргэсэн мэдээллийн тоо | 96 | 98 | Эрүүл мэндийн салбарын статистикийн мэдээг сар бүр ЭМС-ын 2019 оны А/619 тушаалын дагуу ЭМТ 501.1 батлагдсан маягтын дагуу 143 үзүүлэлтээр хүлээн авч нэгтгэн, салбарын статистик мэдээллийг байгууллагын и-оффис болон телеграмм групп, байгууллагын ханын самбарт сар бүр байршуулан ажилтан албан хаагчдыг мэдээллээр хангасан. ЭМГ-ын вэб сайт www.or.mohs.gov.mn статистик үзүүлэлтүүдийг сар, улирлаар байршуулан иргэдэд хүргэсэн. Тайлант хугацаанд эрүүл мэндийн тэмдэглэлт өдөр болон салбарын хэмжээнд зохион байгуулсан удирдамж бүхий сургалт, цаг үеийн арга хэмжээний талаар үеийн арга хэмжээний талаар нийт 1550 удаагийн мэдээ сурвалжилгыг орон нутгийн 5 телевизтэй хамтран бэлтгэж иргэдэд хүргэсэн. E-Times сайттай албан ёсны гэрээ байгуулж хамтран ажилласан. | 100 |
| 59 | 3.2.7.6. Нотолгоонд тулгуурласан шийдвэр гаргах үйл ажиллагаанд эрүүл мэндийн байгууллага ялангуяа хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагын мэдээ, мэдээллийн үнэн зөв, шуурхай байдлыг хангана. | | Мэдээ өгөлт<br><br>Мэдээний чанар | 81,2%<br><br>90% | 84%<br><br>92% | Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлж буй 168 байгууллагаас үйл ажиллагааны чиглэлээр сар бүр албан ёсны мэдээ тайланг батлагдсан маягтын дагуу 143 үзүүлэлтээр хүлээн авч нэгтгэн, мэдээлсэн. Байгууллагуудын мэдээний чанарт хуваарийн дагуу 4 удаа цахим хяналт хийж, үнэлгээ дүгнэлт өгч, зөрчлийг арилгуулан зөвлөмж өгч ажилласан. Тайлант хугацаанд хувийн хэвшлийн 69 эмнэлэг, клиникээс 6 байгууллага тодорхой шалтгааны улмаас ажиллаагүй, мэдээний ирц 78 хувьтай, хувийн хэвшлийн 81 эмийн сангийн мэдээний ирц 60.4 хувь байгаа ба эргэн мэдээллээр хангаж, сарын мэдээг хугацаа хоцроосон 25 байгууллагад албан тоот хүргүүлснээр мэдээний өгөлт 2 хувиар нэмэгдсэн. Тайлант хугацаанд 56 клиник, Эрдэнэт медикал, Баян-Өндөр мед нэгдсэн эмнэлэг, ор бүхий 10 клиникт хяналт хийж, ЭМС-ын | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | 2019 А/611 тушаалын дагуу статистик мэдээний чанар сайжруулах, анхан шатны маягт шинэчлэх зөвлөмж хүргүүлсэн. Өрхийн эрүүл мэндийн төвийн цахим бүртгэлд 10 удаа хяналт хийгдсэнээс кодлолт бүрэн гүйцэд бус 756, эмчийн үзлэгийн бүртгэлийг алдаатай буруу сонгож бүртгэсэн 5822 алдаа зөрчлийг илрүүлснээс 78.7 хувьд E-hospital программаас Hinfo программ руу хөрвүүлэх явцад гарсан алдааг илрүүлэн дүгнэлт зөвлөмж өгөн засуулж, зөрүүг арилгасан. Эрүүл мэндийн хөгжлийн төвийн статистикийн хэлтсийн хяналтын баг Бүсийн оношилгоо эмчилгээний төв, Эрдэнэт медикал төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, Баян-Өндөр мед нэгдсэн эмнэлэг, 3 өрхийн эрүүл мэндийн төвд ажиллаж, өгсөн зөвлөмжийн дагуу алдаа зөрчлийг арилгасан.<br>Мэдээ өгөлт 84%, мэдээний чанар 94% байна. | |
| 60 | 3.2.7.7. Орон нутгийн эрүүл мэндийн байгууллагуудад алсын зайн анагаах ухаан (телемедицин) ашиглах боломжийг бүрдүүлнэ | | Алсын зайн оношилгоо, телемедициний техник тоног төхөөрөмжийн хангалтын хувь | 33% | 40% | Бүсийн оношилгооны төвд суурилагдсан зайн оношилгооны телемедициний хурлын төхөөрөмжөөр 134 хурал, сургалт семинар зохион байгуулагдаж 512 холбогдох удирдлага эмч, мэргэжилтэн хамрагдсан. Цахим эрүүл мэнд төслийн хүрээнд орон нутгийн төсвийн 200,0 сая төгрөгийн санхүүжилтээр 39 тоног төхөөрөмж нийлүүлэгдэн, хэрэгжилт 100%-тай байна. Тайлант хугацаанд БОЭТ-ийн телемедициний алсын зайн оношилгоо, техник тоног төхөөрөмжөөр уушги, зүрх судасны өвчний эмгэгийн оношилгоо, эмчилгээний чиглэлээр Улсын нэгдүгээр төв эмнэлэгтэй 2 удаа холбогдож оношилгоо, эмчилгээний зөвлөмж авсан. Эрүүл мэндийн хөгжлийн төвөөс Lifesize программыг нэвтрүүлж, нэвтрэх эрхийг орон нутгийн эрүүл мэндийн байгууллагуудад хүргүүлсэн нь телемедицинийг гар утаснаасаа алсын зайн оношилгоо эмчилгээнд ашиглах боломжийг | 70 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | бүрдүүлсэн.<br>Жаргалант сумын эрүүл мэндийн төвд тус төсөл үргэлжлэн хэрэгжиж байгаа бөгөөд тайлант хугацаанд мобайл тусламж үйлчилгээг 165 өрхөд 355 хүнийг хамруулсан. Эрүүл мэндийн яаманд мобайл технологийн төсөлд хамрагдсан эрүүл мэндийн байгууллагын судалгаа болон тус төсөлд хамрагдах 2 өрхийн эрүүл мэндийн төвийн судалгааг хүргүүлсэн. байна.<br>“Цахим Эрдэнэт-1” хөтөлбөрийн хүрээнд аймгийн Бүсийн оношилгоо эмчилгээний төв, өрхийн эрүүл мэндийн төвүүдийг 20 ширхэг таблетаар хангаснаар түргэн тусламжийн дуудлага болон өрхийн гэрийн эргэлтээр тусламж үйлчилгээ үзүүлсэн эмч тухайн иргэний өвчний түүхийн мэдээллийг цахим системээс харах, үзлэгийн бүртгэл шивэлт хийх, хөнгөлөлттэй эмийн жорыг тухай бүрт нь бичиж хүлээгдэл, чирэгдлийг бууруулсан бөгөөд сум өрхийн эрүүл мэндийн төвүүдийн компьютерын хангалт 95%-д хүрсэн. Алсын зайн оношилгоо, телемедициний техник тоног төхөөрөмжийн хангалтыг 37,9%-тай, суурь үзүүлэлтээс 16%-аар нэмэгдсэн байна. | |
| 61 | 3.2.7.8. Нэгдсэн эмнэлэгт ашиглагдаж байгаа E-Health программ хангамжийн ашиглалтыг сайжруулж үйл ажиллагааг жигдрүүлнэ. | | E-Health программ хангамжийн ашиглалт | 100 | 100 | Тайлант хугацаанд Бүсийн оношилгоо эмчлгээний төв нь :<br>- Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр аймгийн 24 тасаг нэгж, эмийн сан, амбулаторийн 27 кабинетад E-health программыг ашиглаж үйл ажиллагааг жигдрүүлсэн.<br>- Цахим эрүүл мэндийн E-health программыг хөгжүүлэгч Метаксплас ХХК-тай гэрээ байгуулан, e-health програмын ашиглалт хөгжүүлэлтийг тасралтгүй хийж, эрүүл мэндийн даатгалын системтэй бодит цагийн /realtime/ горимд холбогдон, нэхэмжлэл үүсгэж ажилласан. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | - ЭМСайдын 2019 оны 611-р тушаал, ЭМДҮЗ-ийн 2022 оны 01, 02, 06, 11, 12 дугаар тогтоолуудын эмчилгээ үйлчилгээний үнийн тарифт орсон өөрчлөлтүүдийг программд шинэчлэн оруулсан.<br>- ЭМДЕГ-ын даргын 2022 оны А/53 дугаар тушаалын өндөр өртөгтэй оношилгоо, шинжилгээний жагсаалтыг системд бүрэн оруулсан.<br>- Дүрс оношилгооны PACS системийг шинээр нэвтрүүлж дүрс оношилгооны зураг мэдээллийг иргэний цахим өвчний түүхэнд оруулж ажилласан.<br>- Эрүүл мэндийг дэмжих төвд улс даяар эхэлсэн урьдчилан сэргийлэх эрт илрүүлэг үзлэгийн бүртгэл маягтуудыг E-Health системд нэмэлт өөрчлөлт тохируулга хийж, эрт илрүүлгийн өдөр тутмын мэдээг HIEP систем рүү илгээн ажилласан.<br>- “Эрүүл мэндийн өгөгдөл солилцооны платформ” төслийн хүрээнд нийт эмнэлгийн өгөгдөл солилцож буй өгөгдлийг нэг стандартад оруулан, лаборатори болон эрүүл мэндийн үйлчилгээний нэршлийг Эрүүл мэндийн яамнаас гаргасан нэршилтэй тулган холболтыг хийсэн.<br>Бүсийн оношилгоо эмчилгээний төвд ашиглаж байгаа e-health программын ашиглалтыг тогтмол сайжруулж, хөгжүүлэлт хийн үйл ажиллагааг жигдрүүлсэн. E-Health программ хангамжийн ашиглалт 100% байна. | |
| 62 | 3.2.7.9. Өрх, сумын эрүүл мэндийн байгууллагуудыг өндөр хурдны интернетийн шилэн кабель, эрүүл мэндийн салбарын нэгдсэн VPN сүлжээнд холбоно. | | Өндөр хурдны шилэн кабельд холбогдсон хувь | 89 | 100 | Аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа эрүүл мэндийн 168 байгууллага интернетийн сүлжээнд 100% холбогдсоноос 8 өрхийн эрүүл мэндийн төв Юнивишн, Мобинет ХХК-ийн dedicated 20mb хурдтай өндөр хурдны шилэн кабелийн интернетийн сүлжээнд холбогдсон.<br>Тайлант хугацаанд өрхийн эрүүл мэндийн төвүүдээс Мөнхийн гэгээ эмнэлэг Мобинет ХХК-ийн шилэн кабелийн өндөр хурдны интернэтийн сүлжээнд | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | шинээр холбогдсоноор өрхийн эрүүл мэндийн төвүүд 100% өндөр хурдны шилэн кабелийн интернетийн сүлжээнд холбогдон, ашигласан. Өрхийн эрүүл мэндийн төвүүдийн интернэтийн хурд сайжирснаар эрүүл мэндийн тусламж үйлчилгээний мэдээ мэдээллийн тасралтгүй байдлыг хангаж, үзлэгийн бүртгэлийг түргэн шуурхай хийж, эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг сайжирсан. Өрхийн эрүүл мэндийн төвүүд эрүүл мэндийн тусламж үйлчилгээний цахим бүртгэлийн e-hospital.mn, дархлаажуулалт, хөнгөлөлттэй эмийн жор бичих health.gov.mn, шинжилгээний бүртгэлийн eruul.gov.mn болон вакцины гэрчилгээ, шинжилгээний хариу авах, Бүсийн оношилгоо эмчилгээний төвд үзлэгийн цаг захиалахад E-Mongolia.mn системүүдийг тус тус ашиглаж, тусламж үйлчилгээг үзүүлсэн. | |
| 3.2.8. Харьяа нутаг дэвсгэрийн эрүүл мэндийн байгууллагын хүний нөөцийг дэмжин хөгжүүлэх чиглэлээр | | | | | | | |
| 63 | 3.2.8.1. Орон нутгийн эрүүл мэндийн ажилтны нийгмийн баталгааг хангах, тогтвор суурьшилтай ажиллуулах чиглэлээр санаачилгатай ажиллаж, түрээсийн орон сууц, бусад хэлбэрээр орон сууцтай болгох үйл ажиллагааг дэмжиж ажиллана. | | Орон сууцтай болсон эрүүл мэндийн ажилтны тоо | 14 | 14 | Засгийн газрын 2022 оны 107 дугаар тогтоолын дагуу эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний ажилчдын цалин 13%, өрхийн эрүүл мэндийн төвүүдийн ажилчдын цалинг 50-60% нэмэгдүүлсэн. Коронавируст халдварын дэгдэлтийн үед батлагдсан тохиолдлуудыг эмчилсэн хувийн хэвшлийн эмнэлгүүд ажилчдын үндсэн цалинг 2 дахин нэмэгдүүлэн олгосон.<br>Хувийн хэвшлийн эмнэлгүүд ажилчдын цалин дунджаар 35-40% нэмэгдсэн. Хувийн хэвшлийн Ачит клиник 2 ажилтанд 40,0 сая, Очир увидас клиник 8 ажилтанд 8,0 сая, Тайхар клиник 1 хүнд 2,5 сая төгрөгийн дэмжлэг, урамшуулал үзүүлсэн байна.<br>Бүсийн оношилгоо эмчилгээний төв, өрхийн эрүүл мэндийн төвүүд нь байгууллагынхаа дотоод журмын дагуу буюу орон байрны засвар, түлээ нүүрсний мөнгө, эмчлэн эрүүлжүүлэхэд нийт 69.5 сая төгрөгийг | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | зарцуулсан байна. Эмч хөтөлбөрийн хүрээнд 1 сувилагчийн хүүхдийг яаралтай хагалгаанд ороход нь зориулан 1.1 сая төгрөгийн буцалтгүй тусламжийг үзүүлж, 40-ээс дээш насны 329 эрүүл мэндийн ажилтанд хавдрын маркерын шинжилгээнд хамруулж, 3 мэргэжилтнийг эмчлүүлсэн байна.<br>Бүсийн оношилгоо эмчилгээний төв нь ажилтнуудын нийгмийн баталгааг дэмжих зорилгоор шинээр орон сууц авах 30 ажилтанд 20,0 сая төгрөгийн урьдчилгаа олгосноор ажилчдын цалинг 23 хувиар нэмэгдүүлсэн.<br>Тайлант хугацаанд эрүүл мэндийн салбарын нийт 14 ажилтан түрээсийн орон сууцаар хангагдаж, байрны урьдчилгаа авсан 10 ажилтан байранд орж 14 ажилтан нь 2023 онд шинээр ашиглалтад орох орон сууцны захиалгад хамрагдсан байна.<br>Нийт ажилчдын 21% нь нийгмийн дэмжлэгт хамрагдсан байна. | |
| 64 | 3.2.8.2. Орон нутагт эмнэлгийн тусламж, үйлчилгээнд гардан ажиллаж буй сувилагчийн тоог нэмэгдүүлж, эмч, сувилагчийн харьцааг 1:2-т хүргэх арга хэмжээг хэрэгжүүлэх, орон нутгийн захиалгаар жилд сувилагч мэргэжлээр 3-4 суралцагчийг шинээр сургах зардлыг шийдвэрлэнэ. | | Шинээр ажлын байраар хангасан сувилагчийн тоо | 10 | 10 | Тайлант хугацаанд эрүүл мэндийн 14 байгууллагад 24 сувилагчийг шинээр ажлын байраар хангасан байна. 2022 онд төрийн сангийн санхүүжилтээр 5 сувилагч, дархлаажуулалтаар 2 сувилагч, мэс заслын сувилагчаар 1, нярайн сувилагчаар 1, сэтгэцийн эрүүл мэндийн сувилагчаар 1 нарийн мэргэжил эзэмшиж төгссөнөөс 2 өрхийн эрүүл мэндийн төвд, 3 нь Бүсийн оношилгоо эмчилгээний төвд ажилласан. Тайлант хугацаанд төрийн сангийн санхүүжилтээр 12 сувилагч, дархлаажуулалтын сувилагчийн мэргэжил олгох сургалтад байгууллагын зардлаар 5 сувилагч, Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн төгсөлтийн дараах сувилахуйн сургалтад 16 сувилагч элсэн суралцаж байна. Аймгийн хэмжээнд 10 000 эмчид ногдох сувилагчийн тоо 39.8, 1 эмчид ногдох сувилагч 1:1,2 байна. | 70 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 65 | 3.2.8.3. Үр бүтээлтэй ажиллаж байгаа орон нутгийн эрүүл мэндийн удирдах ажилтан, эмнэлгийн мэргэжилтэнд олгох урамшууллын багцыг хэрэгжүүлэн ажиллана. | | Урамшуулалд хамрагдсан эрүүл мэндийн ажилтны хувь | 8,2% | 8,5% | Засгийн газрын 2022 оны 107 дугаар тогтоолын дагуу эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний ажилчдын цалин 13% нэмэгдсэнээр олгосон. Засгийн газрын 2019 оны 472 дугаар тогтоолын дагуу төрийн захиргааны ажилчдын цалинг олгож байгаа бөгөөд Эрүүл мэндийн газрын даргын 2022 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн Б/11 дугаар тушаалын дагуу Эрүүл мэндийн газрын 4 мэргэжилтэнд төрийн захиргааны албан хаагчийн зэрэг дэвийг журмын дагуу нэмэгдүүлсэн. Бүсийн оношилгоо эмчилгээний төв нь үр бүтээлтэй олон жил ажиллаж байгаа 30 ажилтанд орон сууц худалдан авахад зориулан урьдчилгаа төлбөр тус бүр 20,0 сая төгрөг, Эрдэнэт сувилал орон сууц худалдан авсан нийт 6 ажилтанд тус бүр 13.0 сая төгрөгийн дэмжлэг, Эрдэнэт медикал эмнэлэг нь 3 албан хаагчид орон сууцны урьдчилгааг олгох эрхийн бичгийг тус тус олгосон.<br>Тайлан хугацаанд төрийн дээд одон медалиар 6, ардын хувьсгалын 100 жилийн ойн медалиар 15 Засгийн газрын шагналаар 53, орон нутгийн шагналаар 68, бусад 10 эмч, эмнэлгийн мэргэжилтэн тус тус шагнагдсан. Шагнал урамшуулалд нийт эрүүл мэндийн ажилтны 10,4% хамрагдсан байна. | 100 |
| 66 | 3.2.8.4. Эмнэлгийн мэргэжилтний ажиллан суралцах арга хэмжээг хэрэгжүүлэхэд хамтран ажиллаж, орон нутгийн эмнэлгийн мэргэжилтнийг лавлагаа шатлалын тусламж үйлчилгээ үзүүлэх байгууллагын эмнэлгийн мэргэжилтнийг Бүсийн оношилгоо эмчилгээний төв, | | Сэлгэн ажиллуулсан эмч, эмнэлгийн мэргэжилтний тоо | 21 | 21 | Тайлант хугацаанд 74 эмч, эмнэлгийн мэргэжилтнийг лавлагаа шатлалд болон анхан шатлалд сэлгэн ажиллуулсан байна. Үүнд:<br>- Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн Хүүхдийн тасагт томуу, томуу төст өвчний алаг цоог дэгдэлтийн түвшинд өрхийн эрүүл мэндийн төв болон хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагуудаас нийт 62 эмч, сувилагчийг ажлын байранд сэлгэн ажиллуулсан.<br>- Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн тоног төхөөрөмжийн инженерийг хувийн хэвшлийн | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | эмнэлэг, орон нутгийн анхан шатлалын тусламж үйлчилгээ үзүүлэх байгууллагад сэлгэн ажиллуулах арга хэмжээг дэмжиж ажиллана. | | | | | эмнэлгүүдэд болон сум, өрхийн эрүүл мэндийн төвүүдэд гэрээгээр ажиллаж, тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээг хийж үйлчилсэн.<br>- Хувийн хэвшлийн ор бүхий 10 клиник 8 эмч зүйчийг гэрээгээр сэлгэн ажиллуулж байна.<br>- Анхны-Оч, Учралтбаяр өрхийн эрүүл мэндийн төвд БОЭТ-ийн эмэгтэйчүүдийн 2 эмч жирэмсний хяналтыг хариуцаж өртөмтгий бүлгийн жирэмсэн эмэгтэйчүүдийг хяналтад оруулан ажилласан.<br>- Жаргалант сумын эрүүл мэндийн төвд шүдний кабинет ашиглалтад орж БОЭТ-ийн шүдний эмч нар сэлгэн ажилласан.<br>Дадлагажуулах 4 удаагийн сургалтад 100 эмч, эмнэлгийн мэргэжилтнийг хамруулсан. Үүнд:<br>- Улаанбаатар хотын Интерсайнс ХХК-аас лабораторийн тоног төхөөрөмж, шинжилгээ авах, хяналтын тест тавих сургалтад 35 эмч, эмнэлгийн мэргэжилтэн<br>- Цахимаар МЮКЭС-ээс гадаад хяналт, биохими, цусны дэлгэрэнгүй, тохиргоо үзэх сургалтыг лабораторийн нэгдсэн тасгийн эмч, лаборант нарт<br>- БОЭТ-ийн лабораторийн нэгдсэн тасгаас хүлээх авах 5 тасгийн 20 эмч, сувилагч нарт<br>- БОЭТ-ийн лабораторийн нэгдсэн тасгаас түргэвчилсэн тест авах арга зүйн сургалтад 35 эмч, сувилагчид тус тус зохион байгуулсан байна. | |
| 67 | 3.2.8.5. Төрөлжсөн мэргэшлийн тусламж, үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх, орон нутгийн эрүүл мэндийн байгууллагын ажилтнуудыг ажлын байрнаас нь хөндийрүүлэхгүйгээр мэргэжил дээшлүүлэх болон | | Төгсөлтийн дараах сургалтад хамрагдсан эмнэлгийн мэргэжилтний тоо | 41 | 41 | Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2021 оны 08 дугаар тогтоолоор батлагдсан “Эмч” хөтөлбөрийн хүрээнд орон нутгаас 60,0 сая төгрөгийг шийдвэрлэн 96% хэрэгжүүлэн ажилласан. Дараах чиглэлээр мэргэжил дээшлүүлэхэд дэмжлэг үзүүлсэн. Үүнд:<br>- Эмнэлгийн мэргэжилтний англи хэлний чадварыг дээшлүүлэх зорилгоор 30 эрүүл мэндийн ажилтныг англи хэлний сургалтад хамруулсан. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | төрөлжсөн мэргэшил эзэмших, эрүүл мэндийн удирдах ажилтнуудыг үе шаттайгаар бэлтгэн ур чадварыг дээшлүүлэхэд дэмжлэг үзүүлнэ. | | | | | - Австри улсад зохион байгуулагдсан олон улсын мэдрэлийн эмч нарын сургалтад 1 эмч, АНУ-д зохион байгуулагдсан клиник эмгэг судлаачдын холбооны лаборатори оношилгооны сургалтад 1 эмч, Япон улсад төгсөлтийн дараах сувилахуйн сургалтад 2 сувилагчийг тус тус хамрууллаа.<br>- Эмнэлгийн мэргэжилтний хөгжлийн зөвлөлийн 2021 оны 15-р тогтоолоор “Яаралтай тусламжийн сувилахуй” чиглэлээр S(s) 0913-00-22 индекстэй, ”Эрчимт эмчилгээний сувилахуй” чиглэлээр S(s) 0913-00-20 индекстэй төрөлжсөн мэргэшлийн сургалт эрхлэх зөвшөөрлийг олгосноор 16 суралцагч төрөлжсөн мэргэшил эзэмшсэн.<br>- 2022-2023 онд төрийн сангийн санхүүжилт болон хувийн зардлаар үндсэн болон төрөлжсөн мэргэшил, мэргэжил дээшлүүлэх сургалтад 79 эмч, 91 сувилагч, эмнэлгийн бусад мэргэжилтэн нийт 170 эмч, сувилагч, эмнэлгийн бусад мэргэжилтэн суралцаж байгаагаас төрийн сангийн санхүүжилтээр 14 эмч, 16 сувилагч, тусгай мэргэжилтэн суралцаж байна. | |
| 68 | 3.2.8.6. Эмнэлгийн мэргэжилтний төгсөлтийн дараах сургалтын сүлжээг нэгдсэн эмнэлэг, Бүсийн оношилгоо эмчилгээний төвд бий болгон чадавх бэхжүүлэх үйл ажиллагааг дэмжиж ажиллана. | | Хэрэгжилтийн хувь | 92 | 95 | 2022-2023 онд БОЭТ-ийн “Ерөнхий мэргэшил судлал” үндсэн мэргэшлийн сургалтад суралцаж буй резидент эмчтэй хөдөлмөрийн гэрээ байгуулж, ажлын байрын тодорхойлолтын дагуу Засгийн газрын 2019 оны 25 дугаар тогтоолоор баталсан “Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан тушаалын зэрэглэл”-ийн ТҮЭМ-4 зэрэглэлд хамааруулан цалинг олгож, ажиллан суралцах журмын дагуу сургалтын үйл ажиллагааг эрхэлж ажилласан. Тайлант хугацаанд Эрүүл мэндийн хөгжлийн төвтэй хамтран “Сувилахуйн” эмнэл зүйн ТОТ сургалтыг орон нутагт анх удаа зохион байгуулж 12 сувилагч бэлтгэн эмнэлзүйн сургалт удирдан явуулах бүрэн боломжтой | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | болсон. Япон улсад "Эмч болон сувилагчийн төгсөлтийн дараах сургалт болон практик ур чадварыг сайжруулах" сургалтад орон нутгаас 2 мэргэжилтэн хамрагдан чадавхжсан. Тайлант хугацаанд БОЭТ нь Ерөнхий мэргэшил судлалын сургалтад 4 резидент эмчийг элсүүлэн сургалтыг үргэлжлүүлэн амжилттай зохион байгуулж байна. Мөн "Эрчимт эмчилгээний сувилахуй", Яаралтай тусламжийн сувилахуй" мэргэшүүлэх 3 сарын хугацаатай төгсөлтийн дараах сургалтыг орон нутаг анх удаа эхлүүлэн 15 суралцагчийг элсүүлэн сургалтыг амжилттай зохион байгуулж байна. Хэрэгжилт 100% байна. | |
| 69 | 3.2.8.7. Монгол улсын Засгийн газрын 2021 оны "Тогтоол, тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай" 378 дугаар тогтоолоор аймгийн Мэргэжлийн хяналтын газраас Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газарт шилжин ирэх эм биобэлдмэлийн хяналтын улсын байцаагч нарыг аймгийн Эрүүл мэндийн газарт байрлуулан ажиллуулах нөхцөл боломжоор хангаж, дэмжлэгт удирдлагаар ханган ажиллана. | | Эрүүл мэндийн газарт байршин нөхцөл боломжоор хангагдсан байцаагчийн тоо | - | 1 | Тус Засгийн газрын тогтоолын дагуу Төрийн захиргааны 4-р байранд байрлах Эрүүл мэндийн газарт орон нутгийн Өмчийн газраас 2 өрөөний зөвшөөрлийг нэмэлтээр авч Мэргэжлийн хяналтын газраас ирж байрших улсын байцаагч нарын өрөө тасалгааг бэлэн болгож, ЭМГ-ын даргын тушаалаар байгуулагдсан ажил хүлээлцэх комисс ажлыг хүлээлцүүлэн байршууллаа.<br>Орхон аймагт ажиллаж байсан эм, биобэлдмэлийн улсын байцаагч хүүхэд асрах чөлөөтэй байгаа тул Эрүүл мэндийн газарт одоогоор байршин ажиллаагүй байна. | 100 |
| Бусад үйл ажиллагааны чиглэлээр: | | | | | | | |
| 70 | 3.2.9. Тусгай зөвшөөрлийн хэрэгцээний үнэлгээ хийх, тусгай зөвшөөрлийн ажлын байрны | | Ажлын байрны үзлэг, нөхцөл шаардлагад тавих хяналтын | 1 | 1 | 2022 онд нийт тусгай зөвшөөрөлтэй 188 байгууллага ажилласан. Тайлант хугацаанд эрүүл мэндийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох комисс 5 удаа хуралдан тусгай зөвшөөрлийг шинээр 14 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | үзлэг, нөхцөл шаардлагад тавих хяналтын үйл ажиллагаанд төрийн бус байгууллага, мэргэжлийн нийгэмлэгийн оролцоог хангаж, холбогдох бусад байгууллагын үйл ажиллагаатай уялдуулахад нэгдсэн удирдамжаар хангана. | | үйл ажиллагаанд оролцсон ТББ-ын тоо | | | байгууллагад олгож, 59 байгууллагын тусгай зөвшөөрлийн хугацааг сунган, 2 байгууллагад эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чиглэл нэмж, 5 байгууллагын тусгай зөвшөөрлийг цуцлан, 14 байгууллагад хаягийн шилжилтийг зөвшөөрсөн байна. Орон тооны бус шинжээч нар шинээр үйл ажиллагаа явуулах хүсэлт өгсөн 14 байгууллагын ажлын байранд, Ажлын алба хаягийн шилжилт хийгдсэн 11 байгууллагад ажлын байрны дүгнэлт, стандартын хэрэгжилтийг дүгнэж ажилласан.<br>Тайлант хугацаанд эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрлийн сунгалт хийлгэхээр хүсэлт ирүүлсэн 42 байгууллагыг Мэргэжлийн хяналтын газар болон Эм эмнэлгийн хэрэгсэл, хяналт зохицуулалтын газрын баталгаажуулалтад хамруулсан. Е Mongolia системд тусгай зөвшөөрөл сунгуулах байгууллагуудын хүсэлт материалыг хүлээн авах, архивлах, шийдвэрийг хүргүүлэх чиглэлээр төрийн үйлчилгээг шинээр оруулж тайлант хугацаанд 14 байгууллагын материалыг хүлээн авч шийдвэрлэсэн. Бодлогын шийдвэр гаргах үйл ажиллагаанд иргэдийн оролцоог хангаж, мэдээлэл ил тод, нээлттэй, хүртээмжтэй байх нөхцөлийг хангах зорилгоор Эмнэлгийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох комиссын бүрэлдэхүүнд Хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах нийгэмлэгийн төлөөллийг оролцуулсан. | |
| 71 | 3.2.10. Тухайн орон нутагт зайлшгүй шаардлагатай хөрөнгө оруулалт (тоног төхөөрөмж, барилга, засвар үйлчилгээ), бусад дэмжлэгийг аймгийн Засаг даргын нөөц сан, Орон | ОНТ 1,8 сая | Орон нутгийн төсөвт суулгасан хөрөнгө оруулалт | 2 тэрбум | Гүйцэтгэлээр | Тайлант хугацаанд орон нутгаас нийт 1,8 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдсэн.Үүнд:<br>- Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар БОЭТ-ийн цахилгаан кабель шинэчлэхэд 123,0 сая<br>- Цогцос хадгалах байрны өргөтгөлд 147.8 сая,<br>- БОЭТ-ийн инженерийн шугам сүлжээний засварт 230,0 сая | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | нутгийн төсвийн хөрөнгө, Орон нутгийн хөгжлийн сангаас шийдвэрлэх арга хэмжээ авч ажиллана. | | | | | - Сүрьеэ диспансерын агааржуулалтад 4.9 сая төгрөг<br>- БОЭТ-ийн амбулаторийн засварт 200,0 сая төгрөг<br>- Эрүүл мэндийг дэмжих төвийн засварт 289,0 сая төгрөг<br>- Эрүүл мэндийн чиглэлээр төсөл хөтөлбөрт 16,3 сая төгрөг<br>- Тоног төхөөрөмжид 480,2 сая төгрөг | |
| 72 | 3.2.11. Эрүүл мэндийн байгууллагыг цахилгааны тасралтгүй эх үүсвэрээр хангах, цахилгаан эрчим хүчний доголдлоос эмнэлгийн тоног, төхөөрөмж гэмтэх, цахилгааны богино холбоо үүсэх эрсдэлээс сэргийлж дотоод хяналтыг тогтмолжуулж, цахилгааны нөөц эх үүсвэрийн бэлэн байдлыг хангаж ажиллана. | | Нөөц эх үүсвэрийн бэлэн байдлын хувь | 80 | 85 | Аймгийн хэмжээнд эрүүл мэндийн байгууллагуудын 90% цахилгаан эрчим хүчний нөөц эх үүсвэрээр хангагдсан. Цахилгаан эрчим хүчний доголдлоос эмнэлгийн тоног, төхөөрөмж гэмтэх, цахилгааны богино холбоо үүсэх эрсдэлээс сэргийлж дотоод хяналтыг тогтмолжуулсан.<br>Тайлант хугацаанд Жаргалант сумын эрүүл мэндийн төв болон шинээр баригдсан 4 өрхийн эрүүл мэндийн төвүүдэд 220 кв хүчин чадалтай тог баригчийг, Баян-Өндөр мед нэгдсэн эмнэлэгт нэмэлт цахилгаан үүсгүүрийг суурилуулсан байна. Цахилгааны эрчим хүчний доголдлоос эмнэлгийн тоног, төхөөрөмж гэмтэх, цахилгааны богино холбоо үүсэхээс сэргийлж эмнэлгүүд 100% газардуулгыг хийсэн. Хяналтын баг 2-3 хүний бүрэлдэхүүнтэй ажиллаж сар бүр аюулгүй ажиллагааны бүртгэл хөтөлж хэвшсэн. Цахилгаан эрчим хүчний доголдол, эрсдэл үүссэн тохиолдол бүртгэгдээгүй. | 100 |
| 73 | 3.2.12. Эрүүл мэндийн чиглэлээр хэрэгжиж байгаа гадаадын зээл, тусламж, олон улсын байгууллагын төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавьж, дэмжлэг туслалцаа үзүүлнэ. | ДЭМБ 10,0 сая | Төсөл хөтөлбөрийн хэрэгжилтийн хувь | 92,5 | 93 | Тайлант хугацаанд гадаадын төсөл 3 хэрэгжиж, хэрэгжилт дунджаар 95%-тай байна. Үүнд:<br>- Жайка олон улсын байгууллага “Анхан болон хоёрдох шатлалын эмнэлгийн мэргэжилтний төгсөлтийн дараах сургалтыг сайжруулах” төсөл-100%<br>- Глобаль сангийн “Сүрьеэгийн тохиолдлыг эрт илрүүлэх дадлыг дэмжих замаар үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах, өвчтөн төвтэй | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | нэгдсэн халамж үйлчилгээ, урьдчилан сэргийлэх ажиллагааг бүрдүүлж хэвшүүлэх, эмийн дасалттай сүрьеэгийн аюулд анхаарах” төсөл-85%<br>- Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын 10,0 сая төгрөгийн санхүүжилтээр “Коронавируст халдварын эрсдэлээс урьдчилан сэргийлэх контент бэлтгэх, хөгжүүлэх, түгээх нь” төсөл-100% | |
| 74 | 3.2.13. Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулахад иргэн, төрийн бус байгууллагын оролцоог нэмэгдүүлж Нийгмийн эгэх хариуцлагын сайн туршлагыг нэвтрүүлэн ажиллана. | | Нэвтрүүлсэн сайн туршлага | 5 | 5 | - Эрүүл мэндийн анхан шатны хүртээмж, үйлчилгээг чанаржуулах, эрүүл мэндийн салбарын төсөв санхүүгийн ил тод байдлыг сайжруулахын тулд олон нийтийн хяналт оролцоонд тулгуурлан нийгмийн эгэх хариуцлагыг бэхжүүлэх зорилгоор МАСАМ-2 төслийн хүрээнд “Глоб интернэшл төв” төрийн бус байгууллагатай төслийн гэрээ байгуулан өрхийн эрүүл мэндийн төвүүдийн гадна дотно орчны үнэлгээ, өрхийн эрүүл мэндийн төвүүдийн 2021-2022 онуудын шилэн дансны цахим цонхонд байршуулсан мэдээний чанар, мэдээллийн самбарт ил тод байршуулсан мэдээлэлд мониторниг хийж, аймгийн удирдлагууд, Эрүүл мэндийн газар, өрхийн эрүүл мэндийн төвүүдийн удирдлагуудад танилцуулагдсан.<br>- Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хүрээнд байгууллагуудтай хамтран “ Хаалгаа нээе” өдөрлөгийг 2 удаа зохион байгуулж, 0-18 насны 30 гаруй хүүхдэд үзлэг, шинжилгээ, эмчилгээг хийсэн.<br>- Сэргээн засах тусламж үйлчилгээг үзүүлдэг ЭБИС клиник орон нутгаас 10 сая төгрөгийг шийдвэрлүүлж хөгжлийн бэрхшээлтэй 10 хүүхдэд урт хугацааны сэргээн засах тусламж үйлчилгээг үзүүлснээр хөгжлийн үнэлгээ нэмэгдсэн байна.<br>- “Буурлын чагнуур” төрийн бус байгууллага нь “Ач санах” хөтөлбөрөөс 2,0 сая төгрөгийг шийдвэрлэн | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хэвтрийн хүнд өвчтэй 60 хүнийг гэрийн асаргаа сувилгаанд хамруулсан.<br>- “Элбэрэлт энэрэхүй орчлон” ТТБ-тай хамтран хорт хавдрын 3,4-р үе хожуу шатандаа оношлогдож хөнгөвчлөх эмчилгээнд шилжсэн 46 иргэнд хөнгөвчлөх тусламж үйлчилгээг гэрээр үзүүлсэн. Эрүүл мэндийн газраас нийт 25 багийн иргэдтэй уулзалтыг зохион байгуулж, эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах саналуудыг авч анхан болон лавлагаа шатлалд хэрэгжүүлсэн.<br>- Мэндцэцэн, Үйлсбадрах өрхийн эрүүл мэндийн төв, Бүсийн оношилгоо эмчилгээний төвд 2021 оны 11 дүгээр сараас “Хан шунхлай нуруу” ХХК-ийн 8 хөтөч сувилагчийг ажиллуулснаар үйлчлүүлэгчийн сэтгэл ханамж 90% болж өмнөх оноос 15%-иар нэмэгдэж, иргэдийн тодорхойгүй, мэдээлэлгүй, ойлгомжгүй байдал 88,2 хувиар багассан. | |
| Дөрөв. Гэрээний хэрэгжилт, гэрээний тайлагналт | | | | | | | |
| 75 | 4.1. Аймгийн Эрүүл мэндийн газрын даргатай гэрээ байгуулахад энэхүү гэрээ болон Эрүүл мэндийн газрын саналыг харгалзана. | | | | | Эрүүл мэндийн газрын дарга нь аймгийн Засаг даргатай 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг батлуулан ажилласан. Тус гүйцэтгэлийн төлөвлөгөөнд Эрүүл мэндийн сайд, Засаг даргын хамтран ажиллах гэрээнд тусгагдсан чиглэл, үйл ажиллагааг бүрэн тусган хэрэгжүүлж ажилласан. ЭМГ-ын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт 96,4%-тай байна. | 100 |
| 76 | 4.2.Үйл ажиллагааны төсвийн зарлагын хэмнэлт, зардлын бүлэг хооронд шилжүүлэн зарцуулах зохицуулалтыг Төсвийн тухай хуулийн 42, 45, 46 дугаар зүйл, заалтын дагуу Захиалагчид бичгээр хүсэлт гаргаж | | Хүсэлтийн тоо | 2 | Тухай бүр | 2022 оны эхний 11 сарын байдлаар Төсвийн тухай хууль болон Сангийн Сайдын 73-р тушаалын 1 дүгээр хавсралтын дагуу зардлын бүлэг хооронд шилжүүлэн зарцуулах хүсэлтийг Эрүүл мэндийн газрын даргын 2022 оны 04 дүгээр сарын 21-ний өдрийн 01/233 тоот албан бичгээр 6,2 сая төгрөг, 2022 оны 09 сарын 19-ний өдрийн 01/636 тоот албан бичгээр 5,5 сая төгрөг нийт 11,7 сая төгрөгийн санал хүргүүлж | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | шийдвэрлүүлнэ. | | | | | шийдвэрлүүлсэн. | |
| 77 | 4.3. Хэрэгжүүлэгч нь Захиалагчийн үйл ажиллагаатай уялдуулан жилийн санхүүжилтийн төсвийн төсөлд оруулах хөрөнгө оруулалтын талаар 2 тал харилцан тохиролцон аливаа нэг давхцал үүсгэхгүй байна. | | Давхцал үүсгээгүй байх | 0 | 0 | 2022 онд аймгийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд тусгуулсан хөрөнгө оруулалтыг дараа оны буюу 2022 оны улсын төсөвт тухайн төсвийн төслийг оруулахдаа хөрөнгө оруулалтыг ангилан эрэмбэлж давхцал үүсгэхгүйгээр улсын болон орон нутгийн төсөвт хөрөнгө оруулалтын саналуудыг эрэмбэлэн гаргаж албан тоотоор хуулийн хугацаанд хүргүүлэн ажилласан. | 100 |
| 78 | 4.4. Эрүүл мэндийн байгууллагуудын өр, авлагын байдалд хяналт тавин ажиллаж Төсвийн тухай хуулийн 6.2, 6.3, 6.4 болон 16.5.2, 16.5.3, 16.5.5, 57.5-д заасныг мөрдлөг болгон өр, авлага үүсгэсэн орон нутгийн эрүүл мэндийн байгууллагын Ерөнхий менежертэй хариуцлага тооцож тооцсон талаарх тайлангаа тухай бүрт нь Төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлнэ | | Өр авлагагүй ажилласан байдал | - | - | Төсвийн тухай хууль, 2022 оны Төрийн хэмнэлтийн тухай хуулиудын дагуу эрүүл мэндийн салбар байгууллагууд 2022 оны батлагдсан төсөвт багтаан өр төлбөр, авлагагүй ажилласан. Төсвийн ерөнхийлөн захирагчийн нэгтгэлд нэгтгэдэг эрүүл мэндийн салбар байгууллагаас Бүсийн оношилгоо эмчилгээний төв нь 2022 оны 11 сарын байдлаар нийт 366,2 сая төгрөгийн эм эмнэлгийн хэрэгслийн өр төлбөртэй байна. Энэ өр төлбөр нь Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газраас авах даатгалын санхүүжилт тухайн сардаа багтаж орж ирээгүйгээс болж үүссэн өр төлбөр бөгөөд тухайн өр төлбөрийг 2022 оны эцэст бүрэн барагдуулах боломжтой байна. Орон нутгийн нэгтгэл хамаарагддаг өрхийн эрүүл мэндийн төвүүд болон сумын эрүүл мэндийн төв 2022 оны 11 сарын байдлаар өр төлбөргүй, батлагдсан төсөвт багтаан ажилласан. 2021 оны жилийн эцэст аймгийн хэмжээнд эрүүл мэндийн байгууллагууд нийт 33,9 сая төгрөгийн авлагатай байснаас 2022 оны 04 дүгээр сард Сангийн яамнаас 5,0 сая төгрөгийн авлагыг, 05 дугаар сард хувь хүнтэй холбоотой үүссэн 81,1 мянган төгрөгийн авлагыг бүрэн авч авлагыг барагдуулан ажилласан. 28,4 сая /ЭМГазарт-5,0 сая, БОЭТ-д 23,4 сая/ төгрөгийн авлага нь он дамжин ирсэн /татан | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | төвлөрүүлсэн үлдэгдэл, Эрүүл монгол хүүхэд аяны эрүүл мэндийн даатгалын сангаас авах санхүүжилт/ төлөгдөх нь тодорхойгүй авлагууд байна. | |
| 79 | 4.5. “Төсвийн тухай” хуулийн 8.9.2 дахь заалтын дагуу орон нутаг дахь эрүүл мэндийн байгууллагуудын төсвийн гүйцэтгэл, санхүүгийн жилийн тайланг Эрүүл мэндийн газраар нэгтгэн гаргуулж, аудит хийлгэн дараа оны 03 дугаар сарын 05-ны өдрийн дотор төсвийн ерөнхийлөн захирагчид ирүүлнэ. | | Тайлан хугацаанд хүргүүлсэн байдал | Тайлан хугацаанд хүргүүлсэн | Тайлан хугацаанд хүргүүлсэн | Төсвийн тухай хуульд заасны дагуу Эрүүл мэндийн салбар байгууллагуудын 2022 оны сар бүрийн төсвийн гүйцэтгэлийн тайлан, өр авлагын мэдээг авч нэгтгэн төсвийн ерөнхийлөн захирагчид хугацаанд нь хүргүүлсэн. 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг хуулийн хугацаанд төсвийн ерөнхийлөн захирагчид холбогдох баримт материал, Төрийн аудитын дүгнэлтийн хамт 2022 оны 03 дугаар сарын 12-нд нэгтгүүлсэн. | 100 |
| 80 | 4.7. Эрүүл мэндийн сайдын багцаас аймгийн Засаг дарга нарт эрх шилжсэн ажлын явцын мэдээллийг сар бүр Эрүүл мэндийн яаманд дараа сарын 5-ны өдрийн дотор хүргүүлж байна. | | Эрх шилжсэн үйл ажиллагаа | - | - | Тайлант хугацаанд Эрүүл мэндийн сайдын багцаас батлагдсан санхүүжилтийн эрх шилжсэн үйл ажиллагаа хийгдээгүй байна. | - |
| 81 | 4.8 Хэрэгжүүлэгч нь гэрээний биелэлтийг тухайн жилийн хагас жилийн байдлаар 07 дугаар сарын 15, жилийн эцсийн байдлаар дараа оны 01 дүгээр сарын 15-ны дотор тайлагнана. | | | | | Тус гэрээний биелэлтийг 2022 оны эхний хагас жилээр Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний шалгуур үзүүлэлтээр тайлагнасан. 2022 оны жилийн эцсийн байдлаар гэрээний заалт бүрээр, гэрээний хавсралтын дагуу иж бүрэн хугацаанд нь тайлагнасан. | 100 |
| | Хэрэгжилтийн дундаж хувь 95,7% | | | | | | |

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН:

ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ ҮНЭЛГЭЭ, ДОТООД АУДИТ ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН Г.ЭНХЖАРГАЛ

ТАНИЛЦСАН:

ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Д.СҮХЭЭ

ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДААС АЙМГИЙН ЗАСАГ ДАРГАТАЙ 2022 ОНД БАЙГУУЛСАН ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ГЭРЭЭНИЙ БИЕЛЭЛТ

## ОРХОН АЙМГИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

| **д/д** | **Үзүүлэлт** | 2021.11 | 2022.11 | **Тайлбар** |
|---|---|---|---|---|
| 1. | Артерийн даралт ихсэх өвчний эрт илрүүлэгт хамрагдсан 18 ба түүнээс дээш насны хүн амын эзлэх хувь | 41.0 | 42.2 | 2022 онд артерийн гипертензийн эрт илрүүлэг үзлэгт 18-аас дээш насны 68673 хүн хамруулахаар төлөвлөснөөс эхний 11 сарын байдлаар 28981 /42.2%/ хүн хамрагдаж өмнөх оноос 1.2 хувиар өссөн байна. |
| 2. | Чихрийн шижин хэв шинж-2 өвчний эрт илрүүлэгт хамрагдсан 40 ба түүнээс дээш насны хүн амын эзлэх хувь | 57.1 | 52.2 | Чихрийн шижин өвчний эрт илрүүлэг үзлэгт 40-өөс дээш насны 33925 хүн хамруулахаар төлөвлөснөөс эхний 11 сарын байдлаар 17717 хүн хамрагдаж өмнөх оноос 4.9 хувиар буурсан. |
| 3. | Хөхний өмөнгийн эрт илрүүлгийн үзлэгт хамрагдсан 30 ба түүнээс дээш насны эмэгтэйчүүдийн тоо | 70.5 | 36.8 | 2022 онд 20 ба түүнээс дээш насны 34451 эмэгтэйг үзлэгт хамруулахаар төлөвлөснөөс 12678 эмэгтэй хамрагдаж өмнөх оны мөн үеэс 33.7 хувиар буурсан. |
| 4. | Умайн хүзүүний эрт илрүүлгийн үзлэгт хамрагдсан 30 ба түүнээс дээш насны эмэгтэйчүүдийн тоо | 38.0 | 30.9 | 2022 онд умайн хүзүүний өмөнгийн эрт илрүүлэг үзлэгт 7949 эмэгтэйг хамруулахаар төлөвлөснөөс эхний 11 сарын байдлаар 2458 эмэгтэй хамрагдаж өмнөх оны мөн үеэс 7.1 хувиар буурсан. |
| 5. | Урьдчилан сэргийлэх үзлэгийн хувь | 40.1% | 34.4% | Аймгийн хэмжээнд эхний 11 сарын байдлаар 615823 үзлэг |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | | | хийгдсэнээс урьдчилан сэргийлэх үзлэг 211851 хийгдэж, нийт үзлэгийн 33.9 хувийг эзэлж, өмнөх оны мөн үеэс 5.7 хувиар буурсан. |
| 6. | В вируст гепатитын эсрэг сэргийлэх тарилгын 24 цагийн хамралтын хувь | 99.6% | 99.8% | 2022 оны эхний 11 сарын байдлаар В гепатитын тунд 1926 нярай 24 цагийн дотор дархлаажуулалтад хамрагдахаас 1923 нярай буюу 99.8 хувь хамрагдсан. |
| 7. | Тавт (сахуу, хөхүүл ханиад, татран, В гепатит хемофилюсинфлюенза) сэргийлэх тарилгын хамралтын хувь /3-р тун/ | 98.5% | 97.9% | Тавт вакцинд 1764 хүүхэд хамрагдахаас 1727 хүүхэд 97.9% хамрагдсан нь өмнөх оны мөн үеэс 0.6 хувиар буурсан. Дархлаажуулалтад хамрагдаагүй шалтгаан: 37 хүүхэд нь өвчний шалтгаанаар хоцорсон байна. |
| 8. | Улаанбурхан-гахайн хавдар–улаануудын (УГУ) эсрэг сэргийлэх тарилгын хамралтын хувь /2-р тун/ | 99.0% | 98.3% | 2022 оны эхний 11 сарын байдлаар УГУ вакцины бүрэн тунд 1927 хүүхэд хамрагдахаас 1894 хүүхэд 98.3% хамрагдсан нь өмнөх оны мөн үеэс 0.7%-иар буурсан. Хоцорсон 33 хүүхэд нь өвчний шалтгаанаар түр хойшилсон байна. |
| 9. | Эхийн эндэгдлийн түвшин (100 000 амьд төрөлт тутамд) | 42.9 | 0 | Эхийн эндэгдэл гараагүй. |
| 10. | Нялхсын эндэгдлийн түвшин (1000 амьд төрөлт тутамд) | 12.6 | 4.3 | Аймгийн хэмжээнд нялхсын эндэгдлийн 9 тохиолдол бүртгэгдэж, өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 20 тохиолдлоор буюу 8.3 промиллоор буурсан үзүүлэлттэй байна. |
| 11. | Нярайн эндэгдлийн түвшин (1000 амьд төрөлт тутамд) | 10.3 | 2.9 | Нярайн эндэгдлийн 6 тохиолдол бүртгэгдэж, өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 15 тохиолдлоор буюу 7.4 промиллоор буурсан үзүүлэлттэй байна. |
| 12. | 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн түвшин (1000 амьд төрөлт тутамд ) | 13.3 | 4.8 | 2022 оны эхний 11 сарын байдлаар тав хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн 10 тохиолдол бүртгэгдэж, өмнөх оны мөн үеэс 21 тохиолдлоор буюу 8.5 промиллоор буурсан. |
| 13. | Амьгүй төрөлтийн түвшин (1000 төрөлт тутамд) | 4.2 | 4.8 | 2022 оны эхний 11 сарын байдлаар нийт 10 амьгүй төрөлтийн тохиолдол бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 0.6 промиллоор өссөн. |
| 14. | Жирэмсний эхний 3 сард хяналтад орсон эхийн эзлэх хувь | 96.7% | 96.5% | 2022 оны эхний 11 сарын байдлаар хяналтад шинээр 1562 жирэмсэн эмэгтэйчүүд хамрагдсан ба эхний 3 сартайд 1507 хяналтад орсон нь өмнөх оноос 0.2 хувиар буурсан. |
| 15. | Өсвөр насны 1000 эмэгтэйд ногдох төрөлтийн түвшин | 24.1 | 24.2 | Нийт 2082 эх амаржсанаас, өсвөр насны төрөлт 76 буюу 1000 эмэгтэйд ногдох төрөлт 24.2 байгаа нь өмнөх оны мөн үеэс 0.1-оор өссөн. |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 16. | Сүрьеэгийн өвчлөлийн түвшин, 10 000 хүн амд | 4.5 | 4.8 | Сүрьеэ өвчний 51 шинэ тохиолдол бүртгэгдсэн нь өмнөх оноос 4 тохиолдол буюу 0.3 промиллоор өссөн. |
| 17. | Вируст хепатитын өвчлөлийн түвшин, 10 000 хүн амд | 0 | 0 | 2022 оны эхний 11 сарын байдлаар вируст гепатит өвчний тохиолдол бүртгэгдээгүй. |
| 18. | Зүрх судасны өвчлөлөөс шалтгаалсан нас баралтын түвшин, 10 000 хүн амд | 19.4 | 17.4 | Зүрх судасны өвчлөлөөр нас барсан 185 тохиолдол бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 19 тохиолдлоор буюу 2 промиллоор буурсан. |
| 19. | Хорт хавдраас шалтгаалсан нас баралтын түвшин, 10 000 хүн амд | 11.8 | 12.5 | Хорт хавдрын улмаас нас барсан 133 тохиолдол бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 9 тохиолдлоор буюу 0.7 промиллоор өссөн. |
| 20. | Амиа хорлож нас барсан тохиолдлын түвшин, 10 000 хүн амд | 1.1 | 1.8 | Амиа хорлож нас барсан тохиолдол 19 тохиолдол бүртгэгдэж, өмнөх оны мөн үеэс 7 тохиолдлоор буюу 0.7 промиллоор өссөн. |
| 21. | Санамсаргүй хордох, хорт бодист өртсөнөөс шалтгаалсан нас баралтын түвшин, 10 000 хүн амд /X40-X49/ | 3.6 | 3.5 | Санамсаргүй хордох, хорт бодист өртсөнөөс шалтгаалсан нас баралтын 37 тохиолдол бүртгэгдсэн нь спиртэд хордсон тохиолдлууд байгаа бөгөөд өнгөрсөн оны мөн үеэс 0.1 промиллоор буурсан байна. |
| 22. | 0-5 насны хүүхдийн түлэгдэлтийн түвшин (10 000 хүүхдэд, T20-T32) | 15.2 | 23.4 | 0-5 насны хүүхдийн түлэгдэлт эхний 11 сарын байдлаар 33 тохиолдол бүртгэгдэж өмнөх оны мөн үеэс 8.2 промиллоор өссөн. |
| 23. | Хүүхдийн зам тээврийн ослын шалтгаант нас баралтын түвшин, (10 000 хүүхдэд, V00-V99) | 0.5 | 0.5 | Хүүхдийн зам тээврийн ослын шалтгаант нас баралт 2 тохиолдол бүртгэгдэж өнгөрсөн оны мөн үетэй адил байна. |
| 24. | Шинээр ажилд авсан сувилагчийн тоо | 11 | 39 | БОЭТ 12, Эрдэнэт медикал-5, Эрдэнэт сувилал-2, СӨЭМТ-5, ортой 12 эмнэлгүүдэд 17 сувилагч, нийт 39 сувилагч шинээр ажилд авсан. |
| 25. | Хүний нөөцийн хөгжил, нийгмийн баталгааны хөтөлбөрийн тухайн жилийн үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь | 85% | 96% | Эрүүл мэндийн ажилчдын нийгмийн баталгааг дэмжих чиглэлээр аймгийн ИТХ-ын 2021 оны 08-р тогтоолоор “Эмч” хөтөлбөрийг баталсан. Аймгийн Засаг даргын 2022 оны А/223-р захирамжаар “Эмч” хөтөлбөрийн 2022 оны үйл ажиллагааны төлөвлөгөө болон 60,0 сая төгрөгийн төсөв батлагдсан. “Эмч” хөтөлбөрийн хэрэгжилт 96% байна. |
| 26. | Хүний нөөцийг бүрдүүлэх 3-5 жилийн төлөвлөлтийн хэрэгжилтийн хувь | 85.8% | 85% | Эрүүл мэндийн газарт төрийн захиргааны 7 албан хаагчийн сул орон тоонд төрийн албан хаагчдын нөөцөөс 3 албан хаагчийг Төрийн албаны тухай хуульд зааснаар нөхөн хангалт хийснээр хүний нөөцийн хангалт 85 хувьтай байна. Эрүүл мэндийн салбарын хэмжээнд хүний нөөцийн хангалт 78 хувьтай байна. |
| 27. | Орон нутгаас байр, орон сууцаар хангасан эмч, мэргэжилтний тоо | 14 | 14 | Эрүүл мэндийн салбарын нийт 14 ажилтан аймгийн ЗДТГ-аас түрээсийн орон сууцаар хангагдсан. |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | | | Төрийн албан хаагчдад зориулсан орон сууцанд БОЭТ-ийн 40 ажилтан зах зээлийн ханшнаас хөнгөлөлттэй үнээр буюу м/кв нь 1,350.000 төгрөг байхаар гэрээ байгуулсан бөгөөд одоогоор барилгын гүйцэтгэл 20%-тай явагдаж байна. Бүсийн оношилгоо эмчилгээний төв нь 30 ажилтанд орон сууц худалдан авахад зориулан урьдчилгаа төлбөр тус бүр 20,0 сая төгрөг, Эрдэнэт сувилал орон сууц худалдан авсан нийт 6 ажилтанд тус бүр 13.0 сая төгрөгийн дэмжлэг, Эрдэнэт медикал эмнэлэг нь 3 албан хаагчид орон сууцны урьдчилгааг олгох эрхийн бичгийг тус тус олгосон байна. |
| 28. | Эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд орон нутгийн хөгжлийн сангаас зарцуулсан санхүүжилт (чиглэл, төгрөгөөр, хувиар) | - | 50,8 сая | Орон нутгийн хөгжлийн сангаас Бүсийн оношилгоо эмчилгээний төв, Жаргалант сумын эрүүл мэндийн төвд нийт 50.8 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдсэн. Үүнээс Бүсийн оношилгоо эмчилгээний төвд 29,6 сая төгрөгөөр нярайн тасагт шарлагын фото аппарат 10 ширхэг, Жаргалант сумын эрүүл мэндийн төвд 21,2 сая төгрөгөөр өвчтөний ор, тавилга эд хогшлоор ханган ажилласан. |
| 29. | Сувилагч мэргэжлээр тайлангийн жилд орон нутгаас зардлыг даан сургасан шинэ суралцагчийн тоо | | 5 | Дархлаажуулалтын сувилагчийн мэргэшил олгох сургалтад байгууллагын зардлаар 5 сувилагч сурч байна. |
| 30. | Хүний нөөцийн хөгжил, нийгмийн хамгааллыг дэмжих, тогтвор суурьшилтай ажиллуулах чиглэлээр Засаг дарга, ИТХ-ын түвшинд гарсан шийдвэрийн хэрэгжилтийн хувь | 95% | 96% | Эрүүл мэндийн ажилчдын нийгмийн баталгааг дэмжих чиглэлээр аймгийн ИТХ-ын 2021 оны 08-р тогтоолоор “Эмч” хөтөлбөрийг баталсан. Аймгийн Засаг даргын 2022 оны А/223-р захирамжаар “Эмч” хөтөлбөрийн 2022 оны үйл ажиллагааны төлөвлөгөө болон 60,0 сая төгрөгийн төсөв батлагдсан. “Эмч” хөтөлбөрийн хэрэгжилт 96% байна. |
| 31. | Тайлангийн жилд орон нутгийн төсвөөс хүний нөөцийн чадавхыг сайжруулах, нийгмийн хамгааллын чиглэлээр зарцуулсан хөрөнгийн хэмжээ /мянган төгрөгөөр/ | 54.9 сая | 60,0 сая | - Австри улсад зохион байгуулагдсан олон улсын мэдрэлийн эмч нарын сургалтад 1 эмч, АНУ-д зохион байгуулагдсан клиник эмгэг судлаачдын холбооны лаборатори оношилгооны сургалтад 1 эмч тус тус оролцсон.<br>- Дэлхийн эмч нарын өдөр болон Олон улсын сувилагчдын өдрийг тохиолдуулан эрдэм шинжилгээний хурлыг зохион байгуулж 12 илтгэл шалгарсан. Мөн эмч, сувилагчийн мэргэжлийн үнэ цэнийг нэмэгдүүлэх зорилгоор ажил мэргэжлийн уралдаан, хэлэлцүүлэг, нэвтрүүлэг бэлтгэсэн.<br>-Аймгийн эрүүл мэндийн салбарын удирдах ажилтны зөвлөгөөн “Эмнэлгийн тусламж үйлчилгээний чанарыг сайжруулах жил" уриан |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | | | дор зохион байгуулж 70 төлөөлөл оролцлоо.<br>-30 эрүүл мэндийн ажилтныг англи хэлний дунд шатны сургалтад хамруулсан.<br>-40-ээс дээш насны ажилчдыг шаардлагатай хавдрын маркерын шинжилгээнд хамруулсан. |

ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ ГАРГАСАН: ЭРҮҮЛ МЭНДИЙН СТАТИСТИК, МЭДЭЭЛЛИЙН МЭРГЭЖИЛТЭН Г.ИТГЭЛ